МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТ
THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION





# ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЦИЙН СУДАЛГАА 2021





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

# ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЦИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН 2021

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

| | |
|---|---|
| Б.Батбаатар | ХНХСИ-ийн захирал |
| М.Алтансүх | ХНХСИ-ийн дэд захирал |
| С.Батхолбоо | ХЭБСС-ын эрхлэгч |
| Н.Жаргалсайхан | ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан |
| Д.Алтангэрэл | ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан |
| Г.Мягмардулам | ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан |
| С.Хүрэл-Эрдэнэ | ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан |
| М.Энхзориг | ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан |
| Ж.Өлзийсайхан | ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан |

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Утас: 77121286

Вэб хуудас: www.rilsp.gov

**АГУУЛГА**

**ӨМНӨХ ҮГ** ........................................................ 5

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ** ........................................................ 6

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ** ........................................................ 9

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ** ........................................................ 11

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ** ........................................................ 12

**БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ** ........................................................ 20

1.1.Судалгааны зорилго, зорилт ........................................................ 20

1.2.Судалгааны ач холбогдол ........................................................ 20

1.3.Судалгааны хязгаарлагдмал байдал ........................................................ 20

1.4.Судалгааны хамрах хүрээ ........................................................ 21

1.5.Түүврийн хэмжээ ........................................................ 21

1.6.Түүврийн хэмжээг тооцох ........................................................ 22

1.7.Түүврийн хуваарилалт ........................................................ 23

1.8.Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт ........................................................ 24

1.9.Тайлангийн бүтэц, агуулга ........................................................ 24

**БҮЛЭГ 2. ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЭЦ** ........................................................ 25

2.1.Нийт цалин ........................................................ 26

2.2.ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нийт цалин .. 30

2.3.ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр нийт цалин ........................................................ 33

2.4.Ажиллагчдын боловсрол, мэргэжлийн үндсэн ангиллаар нийт цалин .. ........................................................ 34

2.5.Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын нийт цалин ... 36

2.6.Гадаад ажиллагчдын нийт цалин ........................................................ 37

2.7.Шагнал урамшуулал олгосон байдал ........................................................ 38

2.8.Цалин хөлсийг өөрчилсөн шийдвэр ........................................................ 38

**БҮЛЭГ 3. ҮНДСЭН ЦАЛИН** ........................................................ 41

3.1.ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалинг тооцож буй үзүүлэлт ............ 42

3.2.Ажиллагчдын үндсэн цалин, ААНБ-ын байршил ажиллагчдын тоо, хүйсээр ........................................................ 45

3.3.Ажиллагчдын үндсэн цалин, ажиллагчдын нас, тооны бүлгээр ........ 47

3.4.Ажиллагчдын үндсэн цалин, боловсрол,мэргэжлийн үндсэн ангиллаар ........................................................ 48

3.5.Ажиллагчдын үндсэн цалин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ........................................................ 50

3.6. .Ажиллагчдын үндсэн цалин ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр ........................................................................................................ 52
3.7.Үйлдвэрчний эвлэлтэй болон эвлэлгүй ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалин ........................................................................................................ 53
3.8.Бүрэн бус цагаар ажиллагчдын үндсэн цалин ........................................ 53
**БҮЛЭГ 4. ХХДХ БОЛОН ТҮҮНЭЭС БАГА ХЭМЖЭЭГЭЭР ЦАЛИНЖИЖ БУЙ АЖИЛЛАГЧИД ........................................................................ 55**
**БҮЛЭГ 5. АЖЛЫН ЦАГИЙН ҮЗҮҮЛЭЛТ ............................................ 59**
5.1.ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ажиллагчдын илүү цаг болон ажлын бус өдрийн хөдөлмөр эрхлэлт................................................................ 60
5.2. ААНБ-ын өмчийн хэлбэрээр ажиллагчдын илүү цаг болон ажлын бус өдрийн хөдөлмөр эрхлэлт ................................................................ 61
5.3.Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ажиллагчдын илүү цаг болон ажлын бус өдрийн хөдөлмөр эрхлэлт ........................................ 61
5.4.ААНБ -ын үйл ажиллагаанд гарсан цар тахлын нөлөө..................... 62
**БҮЛЭГ 6. ӨМНӨХ СУДАЛГААТАЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН .......... 65**
6.1.Ажиллагчдын цалин хөлсний өөрчлөлт ААНБ-ын байршлаар.......... 67
6.2.Цалин хөлсний өөрчлөлт ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ........................................................................................ 68
6.3.Цалин хөлсний өөрчлөлт ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр..... ........................................................................................................ 71
6.4.Цалин хөлсний өөрчлөлт ажиллагчдын ажил мэргэжлийн үндсэн ангиллаар ........................................................................................ 73
6.5.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс доогуур цалинжиж буй ажиллагчид.................................................................... 75
**БҮЛЭГ 7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗАРДАЛ ..................................77**
7.1.ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц.................................. 78
7.2.ААНБ-ын байршил аймаг бүсээр хөдөлмөр эрхлэлтийн зардал ....... 81
7.3.ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хөдөлмөр эрхлэлтийн зардал ........................................................................ 83
7.4.Хөдөлмөр эрхлэлтийн зардал ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр /хувь/ ................................................................................................ 84
**ДҮГНЭЛТ ........................................................................................87**
**САНАЛ ЗӨВЛӨМЖ........................................................................... 93**
**ХАВСРАЛТ ......................................................................................... 94**

# ӨМНӨХ ҮГ

Улс орны эдийн засгийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаанд чухал нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн нэг нь ААНБ-ын цалин хөлсний бүтэц, түүний тогтолцооны асуудал юм.

Ажиллагчдын цалин хөлс нэмэгдэхэд өрхийн орлого нь тэр хэмжээгээр нэмэгдэж ажилгүйдэл тодорхой хэмжээгээр буурна. Иймд цалин хөлсний бодлого нь тухайн улсын нийгмийн баталгааг илэрхийлэх бодлогын салшгүй нэг хэсэг төдийгүй хөгжлийн чухал үзүүлэлт юм.

Төрөөс цалин хөлсийг тогтоох тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх, цалин хөлсний талаар үнэн бодитой статистик мэдээллээр хангах зорилгоор бид 2009-2010 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын техникийн тусламжаар ҮСХ-той хамтран “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-г олон улсын арга, аргачлалын дагуу улсын хэмжээнд анх удаа хийж гүйцэтгэсэн. Энэхүү судалгаа нь тухайн үедээ ажиллагчдын цалин, хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллын хэмжээг тусгасан, улсын хэмжээний цалин хөлсний бүтцийг тодорхойлсон суурь судалгаа болсон.

2013 оноос эхлэн салбарын яамнаас “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-г хоёр жил тутамд явуулж байхаар шийдвэрлэн, зохион байгуулж ирлээ. Дундаж цалинг салбар, мэргэжлийн болон хүйсийн ангиллаар мэдээллийг гаргаснаар, цалингийн бүтэц хэрхэн өөрчлөгдөх хандлагыг тодорхойлохоос гадна орлогын тогтвортой байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд, ажил мэргэжлийн ангилал, аймаг, нийслэл, бүс нутгаар тодорхойлон харах боломжтой болсон билээ.

Судалгаагаар ажиллагчдын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал зэрэг цалин хөлсний бүтцийг нарийвчлан тодорхойлж, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар, эрдэмтэн, судлаачид, та бүхэнд танилцуулж байна.

Судалгааны түүвэрт сонгогдон, бидний хүсэлтийг хүлээн авч, судалгаанд мэдээллээ өгсөн ААНБ-ын удирдлага, мэргэжилтэн нартаа талархал илэрхийлье. Таны оролцоо салбарын бодлогод ашиглахуйц мэдээллийн эх үүсвэр болж байгаа юм.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, үр дүнтэй холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ Б.БАТБААТАР

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. ААНБ-уудын нийт цалинг тооцож буй үзүүлэлт ............................ 13

Зураг 2. Цалинг тооцож буй үзүүлэлт ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ....... ........................................................................................... 14

Зураг 3. Үндсэн болон нийт цалингийн харьцуулалт, хүйсээр ..................... 15

Зураг 4. Цалингийн бүтцийн харьцуулалт, оноор ........................................ 16

Зураг 2.1 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц /хувь/ ................................ 26

Зураг 2.2 Ажил олгогчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр /хувь/ .... ........................................................................................... 26

Зураг 2.3 Ажиллагчдын нийт цалингийн дундаж, бүсээр /хувь/ ............... 29

Зураг 2.4 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, бүс, хүйсээр /хувь/ ........ 29

Зураг 2.5 Ажиллагчдын олговор тооцсон нийт цалингийн бүтэц /хувь/ ... 30

Зураг 2.6 ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж, салбараар /мян.төг./ ........................................................................ 30

Зураг 2.7 Бүрэн бус цагаар ажиллагчид, насны болон ажиллагчдын тооны бүлгээр /хувь/ ........................................................................ 36

Зураг 2.8 Бүрэн бус цагаар ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/ ..................................................................... 37

Зураг 2.9 Гадаад ажиллагчдын нийт цалингийн бүтэц /хувь/ .................... 37

Зураг 2.10 ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр шагнал урамшуулал авсан ажиллагчид, шагнал урамшууллын хэмжээ /тоо, хувь/ ........... 38

Зураг 2.11 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн ААНБ ........................................... 38

Зураг 2.12 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн шийдвэр ........................................ 39

Зураг 2.13 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ... ........................................................................................... 39

Зураг 2.14 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн шийдвэр ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ........................................................................ 40

Зураг 2.15 Цалинг нэмэгдүүлэхэд тооцсон суурь ........................................ 40

Зураг 2.16 Ажиллагчдын тооны бүлгээр цалин хөлсийг нэмэгдүүлсэн ААНБ /хувь/ ............................................................................. 40

Зураг 3.1 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ........................................... 42

Зураг 3.2 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ........................................................................... 43

Зураг 3.3 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ААНБ-ын өмчийн хэлбэрээр.. ........................................................................................... 43

Зураг 3.4 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ажиллагчдын насны бүлгээр . ........................................................................................... 44

Зураг 3.5 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ажиллагчдын тооны бүлгээр . ........................................................................................................ 44
Зураг 3.6 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлтээр ........................................ 45
Зураг 3.7 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж бүсээр /мян.төг./ ....... 46
Зураг 3.8 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж бүс, хүйсээр /мян.төг./.. ........................................................................................................ 46
Зураг 3.9 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж боловсрол, хүйсээр /мян.төг./ ........................................................................................ 48
Зураг 3.10 ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үндсэн цалин /мян.төг./ ............................................................................ 51
Зураг 3.11 Үйлдвэрчний эвлэлтэй болон эвлэлгүй ААНБ-ын үндсэн цалин /мян.төг./ ....................................................................................... 53
Зураг 3.12 Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгч, үндсэн цалин, хүйсээр /мян.төг./ ........................................................................................ 53
Зураг 3.13 Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгч, үндсэн цалин, ЭЗҮА-ны салбараар /мян төг/ .................................................................. 54
Зураг 4.1 ХХДХ түүнээс бага цалин хөлс авсан ажиллагчид, сард ажилласан өдрөөр ........................................................................ 57
Зураг 4.2 ХХДХ түүнээс бага цалин авсан ажиллагчид ААНБ-ын өмчийн хэлбэрээр ........................................................................................ 57
Зураг 4.3 ХХДХ түүнээс бага цалин авсан ажиллагчид ЭЗҮА-ны салбараар ........................................................................................................ 58
Зураг 4.4 ХХДХ түүнээс бага цалин авсан ажиллагчид, насны бүлэг, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр.................................................. 58
Зураг 5.1 Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчид ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/ ................................. 60
Зураг 5.2 Ажлын бус өдөр ажилласан ажиллагчид, ажлын хөлс олгоогүй ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/ ................................. 61
Зураг 5.3 Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчдын эзлэх хувь ААНБ-ын өмчийн хэлбэрээр /хувь/.................................. 61
Зураг 5.4 Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчдын эзлэх хувь, ажлын хөлс аваагүй ажиллагчид эдийн засгийн үйл ажиллагааны салбараар............................................................... 62
Зураг 5.5 ААНБ-ын дах цар тахлын нөлөө................................................... 62
Зураг 5.6 ААНБ-ын дах цар тахлын нөлөө ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ........................................................................................................ 63
Зураг 5.7 Цар тахлын нөлөө ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр .......... 63
Зураг 5.8 Эдийн засгийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан ААНБ............ 64

Зураг 6.1 Нийт болон үндсэн цалингийн дундаж 2019, 2021 оноор ............ 66
Зураг 6.2 Нийт цалингийн бүтэц 2019, 2021 оноор харьцуулсан ................ 66
Зураг 6.3 Нийт цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, бүсээр.. 67
Зураг 6.4 Үндсэн цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, бүсээр... ........................................................................ 67
Зураг 6.5 Нийт цалингийн өөрчлөлт 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар ........................................................ 68
Зураг 6.6 Нийт цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар ........................................................................ 69
Зураг 6.7 Үндсэн цалингийн өөрчлөлт 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар ........................................................ 70
Зураг 6.8 Үндсэн цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар ........................................................ 71
Зураг 6.9 Нийт цалингийн бүтцийн өөрчлөлт ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр, 2019, 2021 оноор харьцуулсан ................................. 71
Зураг 6.10 Үндсэн цалингийн өөрчлөлт ААНБ-ын өмчийн хэлбэрээр.......... 72
Зураг 6.11 Цалингийн бүтцийн өөрчлөлт ААНБ-ын өмчийн хэлбэрээр....... 73
Зураг 6.12 Нийт болон үндсэн цалингийн дундаж ажил мэргэжлийн үндсэн ангилалаар.................................................... 73
Зураг 6.13 Цалингийн бүтцийн өөрчлөлт ажил мэргэжлийн үндсэн ангилалаар.................................................... 74
Зураг 6.14 Үндсэн цалингийн өөрчлөлт ажил мэргэжлийн үндсэн ангилалаар ........................................................................ 74
Зураг 6.15 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба түүнээс бага үндсэн цалингаар ажиллаж буй ажиллагчдын хувь харьцуулсан дүнгээр.. ........................................................................ 75
Зураг 6.16 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын эзлэх хувь ААНБ-ын өмчийн хэлбэрээр.................................... 76
Зураг 6.17 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын эзлэх хувь ЭЗҮС ........................................................ 76
Зураг 7.1 Нийт хөдөлмөр эрхлэлтийн зардал.......................................... 78
Зураг 7.2 Цалин хөлсний зардал ........................................................ 79
Зураг 7.3 Нөхөн олговрын зардал ...................................................... 79
Зураг 7.4 Нийгмийн хамгааллын зардал ............................................. 80
Зураг 7.5 Сургалтын зардал................................................................ 80
Зураг 7.6 Хөдөлмөр эрхлэлтийн бусад зардал ..................................... 81
Зураг 7.7 Цалин хөлсний зардал эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/ ........................................................ 84
Зураг 7.8 Хөдөлмөр эрхлэлтийн зардал ААНБ-ын өмчийн хэлбэрээр......... 85

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 ААНБ, ажиллагчдын эзлэх хувь ажиллагчдын тооны бүлэг .... 22

Хүснэгт 1.2 Түүврийн хэмжээ, салбар, ажиллагчдын тооны бүлгээр .......... 23

Хүснэгт 2.1 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, цалин тооцож буй нийт үзүүлэлтээр /мян.төг./ .......... 27

Хүснэгт 2.2 ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж, байршил /мян.төг./ .......... 28

Хүснэгт 2.3 ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр /мян.төг./ .......... 32

Хүснэгт 2.4 ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ажиллагчдын нийт цалингийн дундаж /хувь/ .......... 33

Хүснэгт 2.5 ААНБ-ын өмчийн хэлбэрээр ажиллагчдын нийт цалингийн дундаж /мян.төг./ .......... 34

Хүснэгт 2.6 Нийт цалингийн бүтэц, ажиллагчдын боловсролын түвшинээр. .. .......... 35

Хүснэгт 2.7 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, ажил мэргэжлийн үндсэн ангилал .......... 35

Хүснэгт 2.8 Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчдийн цалингийн бүтэц, хүйсээр .......... 36

Хүснэгт 3.1 Ажиллагчдын үндсэн цалин, үндсэн цалин тооцож буй үзүүлэлтээр .......... 42

Хүснэгт 3.2 Үндсэн цалин ажиллагчдын хүйс, ААНБ-ын байршлаар.......... 45

Хүснэгт 3.3 Үндсэн цалин, ажиллагчдын нас, тооны бүлгээр.......... 47

Хүснэгт 3.4 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ажиллагчдын насны болон тооны бүлэг, ААНБ-ын байршил бүсээр .......... 47

Хүснэгт 3.5 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, боловсрол ААНБ-ын байршил бүсээр.......... 48

Хүснэгт 3.6 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн үндсэн ангилал, ажиллагчдын хүйсээр /мян.төг./ .......... 49

Хүснэгт 3.7 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ажил мэргэжлийн ангилал, ажиллагчдын нас, тооны бүлгээр .......... 50

Хүснэгт 3.8 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ЭЗҮА-ны салбараар, ажиллагчдын нас, тооны бүлгээр .......... 51

Хүснэгт 3.9 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ААНБ-ын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр........................................ 52
Хүснэгт 4.1 Ажиллагчдын тоо, үндсэн цалин бүлгээр................................ 56
Хүснэгт 6.1 Нийт цалингийн бүтцийн өөрчлөлт ААНБ-ын ЭЗҮА-ны салбараар /пункт/.................................................................. 69
Хүснэгт 6.2 ХХДХ ба түүнээс доогуур цалинжиж байгаа ажиллагчид......... 75
Хүснэгт 7.1 Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц аймаг бүсээр /хувь/ .... 82
Хүснэгт 7.2 Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/ ....................................... 83
Хүснэгт 7.3 Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/ ................................................................... 85

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХНХСИ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт |
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| ББН | Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл |
| ЗБН | Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл |
| МҮЭХ | Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо |
| МАОЭНХ | Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ХХДХ | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| НХХЯ | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХССМГ | Хөдөлмөрийн судалгаа, сургалт мэдээллийн газар |
| ЦХБС | Цалин хөлсний бүтцийн судалгаа |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ЭЗҮАС | Эдийн засгийн үйл ажиллагааны салбар |

# СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Цалин хөлсний бүтцийн судалгаанд улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг энгийн санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн 2474 байгууллагыг хамруулсан. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 1719 нэгж нь Улаанбаатар хотын, 755 нэгж нь орон нутгийн ААНБ байна.

Эдгээр ААНБ-уудад нийт 148999 ажиллагчид хөдөлмөр эрхэлж байна. Судалгаанд хамрагдсан ААНБ тэдгээрт хөдөлмөр эрхэлж буй нийт ажиллагчдын 15.5 хувь нь буюу 23087 хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг нэгтгэн үр дүнг тооцсон болно. Судалгаанд хамрагдсан нийт ажиллагчдын 47.3 хувь нь эрэгтэй, 52.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байлаа. Ажиллагчдын хөдөлмөр эрхэлж буй байдлаар авч үзвэл 98.6 хувь нь байнгын, 1.4 хувь нь түр ажлын байранд хөдөлмөр эрхлэгчид байна.

**Цалин хөлсний бүтэц**

Судалгааны үр дүнгээр улсын хэмжээнд ажиллагчдын нийт цалингийн дундаж 1087.7 мянган төгрөг байлаа. Нийт цалингийн 84.0 хувийг нь (913.1 мян төг) үндсэн цалин, нэмэгдэл 10.0 хувийг (108.3 мян төг), нэмэгдэл хөлс 52.2 хувийг (56.1 мян төг), 0.9 хувийг (10.2 мян төг), шагнал урамшуулал бүрдүүлж байна.

ААНБ-ын нийт цалингийн дунджийг байршлаар харьцуулан авч үзвэл Орхон аймаг (1.161 мянган төгрөг), Улаанбаатар хотод (1.141 мянган төгрөг) улсын дунджаас 53.5 - 73.4 мянган төгрөгөөр илүү байна. Харин Булган аймаг (653.3 мянган төгрөг), Хэнтий аймагт (860.5 мянган төгрөг) улсын дунджаас 227.2 - 434.4 мянган төгрөгөөр бага байна.

Цалин хөлсний бүтцийг бүсээр харьцуулан авч үзвэл Улаанбаатар хотын ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн 87.6 хувь нь үндсэн цалин, 7.4 хувь нь нэмэгдэл, 4.2 хувь нь нэмэгдэл хөлс, 0.7 хувийг шагнал урамшуулал байгаа нь улсын дундажтай харьцуулахад нийт цалинд эзлэх үндсэн цалин илүү харин нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал бага байна. Орон нутагт эсрэгээр буюу нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь улсын дунджаас бага, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал хувь өндөр байна.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ЭЗҮА-ны салбараар нийт цалингийн дунджийг, судалгааны дундаж нийт цалинтай харьцуулахад уул уурхай, олборлолтын салбар 501.1, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбар 341.9, цахилгаан, хий уур, агааржуулалтын салбар 309.7, мэдээлэл холбооны салбар 229.6, барилга 117.7, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн салбарт 88.9 – 90.1 мянган төгрөгөөр өндөр байна. Бусад салбарын ажиллагчид нийт цалингийн дунджаас доогуур цалингаар ажиллаж байна. Үүнээс үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллагчдын нийт цалин дунджаас 390.3 мянган төгрөгөөр доогуур байгаа нь хамгийн бага нийт цалин байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн бүтцийг авч үзвэл цахилгаан хий, уур агааржуулалтын хангамжийн салбарт ажиллагчдын үндсэн цалин 61.7 хувь байгаа нь бусад

салбартай харьцуулахад хамгийн бага үзүүлэлт болж байна. Харин санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын ажиллагчдын үндсэн цалин 98.0 хувь буюу хамгийн өндөр байна. Харин цахилгаан хий, уур агааржуулалтын хангамжийн салбарт ажиллагчдын нийт цалингийн бүтцэд эзлэх нэмэгдлийн хувь 23.7 хувь байгаа юм.

ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр харвал хувьцаат компанийн ажиллагчдын үндсэн цалин нийт цалингийн 73.1 хувийг бүрдүүлж байгаа ч нийт цалингийн дундаж 1358.9 мянган төгрөг, харин хоршооны ажиллагчдын үндсэн цалин нийт цалингийн 93 хувийг бүрдүүлж байгаа ч нийт цалингийн хэмжээ хамгийн бага буюу 721.1 мянга байв.

ААНБ-ын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын хүйсээр цалингийн бүтцийг харьцуулбал, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эмэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн хувь эрэгтэй ажиллагчдынхаас 3.6 - 7.2 пунктээр өндөр байна.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын 10.1 хувь нь шагнал урамшуулал хүртсэн байна. Шагнал урамшуулалд хамрагдсан ажиллагчдын 58.8 хувь нь эмэгтэй, 41.2 хувь нь эрэгтэй байв. ААНБ-ууд шагнал, урамшууллыг тооцохдоо үндсэн цалингийн дүнгээс дунджаар 10.2 хувиар тооцож олгожээ.

Төсөвт байгууллагын ажиллагчид шагнал урамшуулалд хамрагдах нь түгээмэл хэдий ч хувь, хэмжээ нь улсын дундажтай ойролцоо буюу үндсэн цалингийн 11.1 хувь байна. Харин хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчид үндсэн цалингийн 67.5, 39.4 хувиар тус тус шагнагдсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Цалин хөлс нэмэгдүүлсэн нийт ААНБ-ын 75.4 хувийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, 11.9 хувийг төсөвт байгууллага эзэлж байна. Цалин хөлсөө нэмсэн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 25 хувь нь хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу, 75 хувь нь ажил олгогчдын шийдвэрээр цалин хөлсийг нэмэгдүүлсэн байна. Харин төсөвт байгууллагын 84.4 хувь нь засгийн газрын тогтоол, шийдвэрээр, 14.1 хувь нь ажил олгогчийн шийдвэрээр цалин хөлсийг нэмсэн байна.

### Цалин тооцож буй үзүүлэлт

Ажил олгогчид ажиллагчдын ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэрэг, ажлын гүйцэтгэл буюу хийснээр, ажлын байран дах ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтийг дангаар нь, эсвэл хоёроос гурван үзүүлэлт харгалзан үндсэн цалинг тогтоодог байна.

*Зураг 1. ААНБ-уудын нийт цалинг тооцож буй үзүүлэлт*



Ажил олгогчдын 21.1 хувь нь  ажиллагчдын ажилласан жилээр, 5.3 хувь нь ур чадвар мэргэжлийн зэргээр, 25.5 хувь нь ажлын гүйцэтгэл буюу хийснээр, 48.1 хувь нь ажлын байран дах ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтээр үндсэн цалин тооцож байна. Цалин тооцож буй үзүүлэлт нь өмнөх судалгааны үр дүнгээс ур чадвар мэргэжлийн зэргээр (1.9 пунктээр), ажлын гүйцэтгэл буюу хийснээр (12.3 пунктээр) үндсэн цалин тооцож буй ажил олгогчдын хувь өссөн байна.

*Зураг 2. Цалинг тооцож буй үзүүлэлт ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр*




Ажиллагчдын үндсэн цалинг тооцож буй үндсэн үзүүлэлтийг ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл Хязгаарлагдмал хариуцлагатай компани ажиллагчдын гүйцэтгэл буюу хийснээр үндсэн цалин тооцож буй үзүүлэлтийн 83.2 хувийг, төсөвт байгууллагууд ажилласан жилийг харгалзан үндсэн цалинг тооцож байгаа дүнгээр 65.4 хувийг эзэлж байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь ажиллагчдын гүйцэтгэж буй ажил үүрэг,  ажлын гүйцэтгэл буюу хийснээр гэсэн 2 үзүүлэлтийг харгалзан үндсэн цалинг тооцож байгаа нь бусад ААНБ-аас өндөр байна.

**Үндсэн цалин**

Судалгааны үр дүнгээр ажиллагчдын үндсэн цалингийн улсын дундаж 913.1 мянган төгрөг байна. Эрэгтэй ажиллагчдын үндсэн цалин дунджаар 985.5 мянган төгрөг, эмэгтэй ажиллагчдын үндсэн цалин дунджаар 848.3 мянган төгрөг байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дундаж эмэгтэй ажиллагчдын дунджаас 13.9 хувиар буюу 137.1 мянган төгрөгөөр илүү байна.

Ажиллагчдын үндсэн цалинг ААНБ-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа байршил бүсээр харьцуулан авч үзвэл Улаанбаатар хотын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 9.5 хувиар буюу 86.5 мянган төгрөгөөр өндөр байна. Бусад аймгийн үндсэн цалин (Өмнөговь аймагт 913.7 мянган төгрөг буюу улсын дундажтай тэнцүү) улсын дунджаас доогуур байна. Булган аймгийн хувьд үндсэн цалин улсын дунджаас 37.0 хувиар буюу 337.8 мянган төгрөгөөр бага байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт болж байна.

Бүсээр харьцуулбал орон нутгийн ажиллагчдын үндсэн цалингийн дундаж улсын дунджаас 114.4 - 200.8 мянган төгрөгөөр бага. Баруун бүсэд (712.3 мянган төгрөг) хамгийн бага буюу улсын дунджаас 22.0 хувиар доогуур

байна. Гэхдээ баруун бүсэд эмэгтэй ажиллагчдын үндсэн цалин эрэгтэй ажиллагчдынхаас 2.3 мянган төгрөгөөр илүү төдийгүй бүсийн дунджаас өндөр гэсэн сонирхолтой дүн гарсан.

Ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг насны бүлгээр ангилан улсын дундажтай харьцуулахад 16-25 насны ажиллагчдынх 5.1 хувиар, 46-аас дээш насныхны хувьд 2.3 – 4.3 хувиар доогуур. Харин 26-35 насны ажиллагчдынх 31.1 мянган төгрөгөөр, 36-45 насныхны хувьд 9.4 мянган төгрөгөөр илүү байна.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг хүйс, боловсролоор харьцуулбал магистр зэрэгтэй ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 341.3 мянган төгрөгөөр буюу 37.4 хувиар ахиу байна. Гэвч магистр зэрэгтэй эрэгтэй ажиллагчид улсын дунджаас 561.7 мянган төгрөгөөр буюу 61.5 хувиар илүү цалин авдаг байхад магистр зэрэгтэй эмэгтэй ажиллагчид 203.1 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар л илүү байна. Харин бага боловсролтой эсвэл боловсролгүй эмэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дундаж эрэгтэйчүүдийнхээс ахиу байдаг байна.

ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үндсэн цалингийн дунджийг харьцуулан үзвэл уул уурхай, олборлолтын салбарт хамгийн өндөр буюу 537.0 мянган төгрөгөөр, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт 482.6 мянган төгрөгөөр улсын үндсэн цалингийн дунджаас ахиу байна. Харин үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллагчид улсын үндсэн цалингийн дунджаас 245.0 мянга, урлаг үзвэрийн, тоглоом наадмын үйл ажиллагааны салбар 189.9 мянга, боловсролын салбарын ажиллагчид 166.0 мянга, хүний эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын салбар 147.9 мянган төгрөгөөр доогуур байгаа нь анхаарал хандуулах ёстой асуудлын нэг мөн.

Ажиллагчдын үндсэн цалинг байгууллагын хариуцлагын хэлбэрээр харьцуулбал ХХК-ны ажиллагчдын үндсэн цалин 1046.0 мянган төгрөг байгаа нь улсын үндсэн цалингийн дунджаас 14.6 хувиар өндөр байна. Харин төсөвт байгууллагын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 20.4 хувиар бага байна.

### Нийт ба үндсэн цалингийн өөрчлөлт

Цалин хөлсний бүтцийн 2021 оны судалгааны дүнгээр ажиллагчдын нийт цалингийн дундаж 1087.7 мянган төгрөг байгаа нь 2019 оны дүнгээс 19.8 мянган төгрөг буюу 1.9 хувиар нэмэгдсэн, үндсэн цалин 13.9 мянган төгрөг буюу 1.5 хувиар буурсан.

*Зураг 3. Үндсэн болон нийт цалингийн харьцуулалт, хүйсээр*



Нийт ба үндсэн цалингийн өөрчлөлтийг хүйсээр тодруулбал эрэгтэй ажиллагчдын нийт цалин 0.6 хувь буюу 7.4 мянган төгрөгөөр, эмэгтэй ажиллагчдын цалин 4.4 хувь буюу 43.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин эрэгтэй ажиллагчдын үндсэн цалин 19.0 мянган төгрөг буюу 1.9 хувиар буурсан, эмэгтэй ажиллагчдынх 2.9 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар нэмэгдсэн.

Судалгааны дүнгээр ажиллагчдын цалингийн бүтцийг 2019 оны нийт цалингийн бүтэцтэй харьцуулбал 2021 оны нийт цалинд эзлэх үндсэн цалин 84.0 хувь болж 2.8 пунктээр, шагнал урамшуулал 0.9 хувь болж 0.4 пунктээр өмнөх судалгааны дүнгээс буурсан. Харин ажиллагчдын нэмэгдэл 2021 оны дүнгээр 10.0 хувь болж 2.5 пунктээр, нэмэгдэл хөлс 5.2 хувь байгаа нь 0.7 пунктээр өссөн байна.

*Зураг 4. Цалингийн бүтцийн харьцуулалт, оноор*




**Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид**

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын 3.2 хувь нь бүрэн бус цагаар буюу 7 хоногт дунджаар 36.7 цаг хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй, дундаж нас 41.3 байгаа юм. Эмэгтэй ажиллагчдын 7 хоногийн ажлын дундаж цаг эрэгтэйчүүдээс 1.2 цагаар бага байна.

ААНБ-ын ЭЗҮА-ны салбараар харвал тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар (12.4 хувь), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар (11.1 хувь), бөөний болон жижиглэн худалдааны салбарт (11.0 хувь) хамгийн олон бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчид байна.

Бүрэн бус цагаар ажиллагчид улсын нийт цалингийн дунджаас бага цалингаар хөдөлмөр эрхэлж байна. Нийт цалингийн дундаж 806.2 мянган төгрөг байгаагийн 90.9 хувь нь үндсэн цалин, 4.3 хувь нь нэмэгдэл, мөн 4.3 хувь нь нэмэгдэл хөлс, 0.5 хувь нь шагнал урамшуулал байна.

Бүрэн бус цагаар ажиллагчдын үндсэн цалингийн дундаж 732.7 мянган төгрөг буюу улсын үндсэн цалингийн дунджаас 180.5 мянган төгрөгөөр бага байна. Хүйсийн харьцааны хувьд эрэгтэй бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчийн үндсэн цалингийн дундаж эмэгтэй ажиллагчдынхаас 34.0 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар доогуур байна.

**ХХДХ болон түүнээс бага хэмжээгээр цалинжиж буй ажиллагчид**

Судалгааны мэдээлэл цуглуулах үе буюу 2021 оны 5-р сарын байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэг цагт 2500 төгрөг буюу сард 420.000 төгрөг байв.

Судалгаанд хамрагдсан нийт ажиллагчдын 31.2 хувь нь үндсэн цалингийн дундаж буюу 913.1 мянган төгрөгөөс дээш үндсэн цалингаар хөдөлмөр эрхэлж байгаа бол 64.3 хувь нь үндсэн цалингийн дунджаас бага ч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш үндсэн цалингаар цалинжиж байгаа үр дүн гарсан. Харин 4.6 хувь буюу 1053 нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 4.7 хувь буюу 1082 ажиллагчид ХХДХ-ээс бага цалинтай байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй, 94.6 хувь нь байнгын ажлын байранд, 5.4 хувь нь түр ажлын байранд ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалинтай ажиллагчдын 88.3 хувийг нөхөрлөл хоршоо, төрийн бус байгууллагын ажиллагчид бүрдүүлж байна. ААНБ-ын өмчийн хэлбэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын 77.8 хувь нь Монгол Улсын иргэний өмчийн ААНБ-д ажиллаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа (22.7 хувь), барилга (15.7 хувь), боловсруулах үйлдвэрлэл (12.8 хувь), үйлчилгээний бусад салбарт (9.8 хувь) хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалинтай ажиллагчдын талаас илүү хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалингаар ажиллаж буй ажиллагчдын дунд 26-45 насныхан өндөр хувийг эзэлж байна. Ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл томоохон ААНБ-ууд ажиллагчдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс доогуур үндсэн цалингаар цалинжуулах нь ховор байдгийг ажиглаж болно.

**Ажлын цагийн үзүүлэлт**

Судалгааны мэдээлэл цуглуулсан 2021 оны 5 сарын байдлаар судалгаанд хамрагдсан 23087 ажиллагчдын 8.6 хувь буюу 1984 нь ажлын бус өдрөөр юм уу илүү цагаар ажиллаж байжээ. Ажиллагчдын ажлын бус өдөр юм уу илүү цагаар ажиллах өмнөх судалгааны мөн дүнгээс буурсан байна.

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 3.2 хувь нь ажлын бус өдрөөр, 5.2 хувь нь илүү цагаар хөдөлмөр эрхэлсэн байна. Ажлын бус өдөр ажиллаж байсан ажиллагчид тухайн ажлын байранд сард дунджаар 3.4 өдөр, илүү цагаар ажилласан ажиллагчид сард дунджаар 39.3 цаг ажилласан байна.

ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл ажлын бус өдөр ажилласан ажиллагчдын 82 хувь, илүү цагаар ажилласан ажиллагчдын 70.5 хувь нь ХХК-ийн ажиллагч байна.

Ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан ажиллагчдын 47 хувь нь нэмэгдэл хөлс авсан бол 53 хувь нь ажлын хөлс аваагүй байна.

ААНБ-ын өмчийн хэлбэрээр авч үзвэл ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан нийт ажиллагчдын 74.2 хувь нь Монгол Улсын иргэний хувийн, 15.3 хувь нь төрийн өмчийн ААНБ-уудад ажиллаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар дүнг харьцуулан авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа 27.3, боловсруулах үйлдвэрлэл 12.4, барилга 18.2, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбар 11.3 хувиар ажлын бус өдөр болон илүү цагаар ажиллагчдаа ажиллуулдаг нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

**ААНБ -ын үйл ажиллагаанд гарсан цар тахлын нөлөө**

Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын үйл ажиллагаанд үзүүлсэн цар тахлын нөлөөг тодруулбал ажил олгогчдын 35.0 хувь үйл ажиллагаагаа түр хугацаагаар хаасан, 32.3 хувь нь үйл ажиллагаагаа багасгасан гэж хариулсан байна. Бусад 32.8 хувь нь тодорхой өөрчлөлт гараагүй гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан байгууллагын цар тахлын нөлөөгөөр орлогод гарсан өөрчлөлтийг хөл хорио болон бусад арга хэмжээний өмнөх хэвийн үйл ажиллагааны орлогоор харьцуулж тодруулахад нийт ААНБ-ын 65.3 хувьд нь үйл ажиллагааны орлого ихээхэн буурсан бол 34.7 хувьд орлого буураагүй байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн зардал**

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийн нийт зардлын 80.0 хувийг нь ажиллагчдын цалин хөлс, 2.5 хувийг нөхөн олговор, 12.5 хувийг нийгмийн хамгааллын зардал, 0.6 хувийг сургалтын зардал, 4.5 хувийг хөдөлмөрийн бусад зардал эзэлдэг байна.

Цалин хөлсний нийт зардалд үндсэн цалин 77.1 хувийг, нэмэгдэл 0.6 хувийг, нэмэгдэл хөлс 9.8 хувийг, шагнал урамшуулал 8.8 хувийг ажиллаагүй цагийн олговор 3.4 хувийг, ажил гүйцэтгэх түүнтэй холбоотой олговрын зардал 0.2 хувийг бүрдүүлж байна.

Ажиллагчдад биет болон бүтээгдэхүүн хэлбэрээр олгосон нийт нөхөн олговрын зардлын 63.9 хувийг хоолны, 12.3 хувийг унааны, 14.1 ажиллагчдын тээврийн түлш шатахууны, 7.1 хувийг түлээ нүүрсний, 2.6 хувийг бусад зардал эзэлж байна.

Ажил олгогчоос ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн зардал нь нийт нийгмийн хамгааллын зардлын 94.3 эзэлж байна.

Ажиллагчдыг давтан сургах тухайн ажил мэргэжилд мэргэшүүлэх зардалд нийт сургалтын зардлын 49.5 хувийг, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд 39.5 хувийг, шинэ ажиллагчдыг дадлагажуулахад 2.0 хувийг, ажиллагчдын сургалт түүнтэй холбоотой бусад зардалд 9.0 хувийг зарцуулж байна.

# I
# БҮЛЭГ

## СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ



Цалин хөлсний бүтцийн тухай асуудал хөдөлмөрийн харилцаанд голлох үүрэг гүйцэтгэдэг. 2010 онд НХХЯ /тухайн үеийн нэрээр/ Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын техникийн тусламжтайгаар ҮСХ-той хамтран Цалин хөлсний бүтцийг судалгааг зохион байгуулж байжээ. Улмаар 2013 оноос хоёр жил тутамд тогтмол гүйцэтгэж байхаар болсон бөгөөд 2021 онд давтамжийн дагуу үндэсний хэмжээнд зургаа дахь удаагаа амжилттай хийж гүйцэтгэлээ.

### 1.1. Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэгчдийн цалин хөлс, түүний бүтцийн талаарх мэдээллийг шинэчлэх, ААНБ-ын үйл ажиллагаа, ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр тэдгээрт зарцуулж буй зардлын мэдээллийг бий болгох, ажил олгогчоос олгож буй үндсэн болон нийт цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал зэргийг нарийвчлан судалж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад цалин хөлстэй холбогдох үзүүлэлтүүдтэй уялдуулан дүгнэлт гаргахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг ханган ажиллаа.

- Цалин хөлсний бүтцийн мэдээллийг тодорхой үзүүлэлтүүдээр шинэчлэн шинжилгээний ажлын мэдээллийг баяжуулах;
- Цалин хөлсний бүтэц, үндсэн цалин тооцож буй үзүүлэлтийг тодорхойлох;
- Аж ахуй нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тоо, ажиллагчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд, мэргэжлийн чиглэл, ангилал, албан тушаал, цалин олголтын хугацааны давтамжаар нь цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшууллын хэмжээ, өөрчлөлт зэргийг харьцуулан гаргах;
- ААНБ-ын үйл ажиллагаа, ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, ажлын байранд зарцуулсан зардлын мэдээллээр хөдөлмөр эрхлэлтийн зардлын индекс тооцох;
- Судалгааны мэдээллийг боловсруулан тайлан, зөвлөмж бэлтгэх, хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах;

### 1.2. Судалгааны ач холбогдол

Цалин, хөлсний бүтцийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар шинэчлэхийн зэрэгцээ ажиллагчдын цалин хөлсний бүтцийг нарийвчлан судалж, санал зөвлөмжийг салбарын яамны бодлого боловсруулагчид болон бусад судлаачид, хэрэглэгчдэд хүргэнэ. Судалгааны үр дүнгээр хөдөлмөрийн харилцааны гол үзүүлэлт болох ажиллагчдын цалин хөлсний дунджийг мэргэжлийн үндсэн бүлэг болон нас, хүйс, ажиллагчдын бүрэн, бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж буй байдал зэрэг үндсэн үзүүлэлтийг тогтоохын зэрэгцээ тодорхой давтамжтайгаар хийгддэг судалгааны онцлогийн дагуу өмнөх жилийн судлагааны үр дүнгээр цалингийн өөрчлөлт бусад хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр харьцуулан үзэх боломжтой болно.

### 1.3. Судалгааны хязгаарлагдмал байдал

Цалин хөлсний бүтцийн судалгаа нь мэдээллийн хүрээнд дараах хязгаарлалтыг өөртөө агуулсан болно.

Үүнд:

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-аас түүврийн хүрээг бэлтгэсэн тул албан бус сектор болон олон улсын санхүүжилт бүхий томоохон төсөл, хөтөлбөр судалгааны хүрээнд хамрагдаагүй;
- Үйл ажиллагаа явуулаагүй Х тайлантай болон хаяг байршил тодорхой бус ААНБ-ыг хамруулаагүй;
- Цалин хөлсний бүтцийн судалгааг түүвэрт хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын 2021 оны 5 дугаар сарын цалингийн цэсэд үндэслэн авсан;
- Олон Улсын байгууллагуудын мэдээлэл хангалтгүй тул түүврийн хүрээнээс хасаж тооцсон;
- Судалгааны мэдээлэл цуглуулах явцад үйл ажиллагаа явуулаагүй болон мэдээлэл өгөхөөс татгалзсан ААНБ-ын мэдээллийг тайланд тусгаагүй болно;

## 1.4. Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсын хэмжээнд 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар ҮСХ-ны бизнес регистрийн санд нийт 205.7 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 91.6 буюу 47.1 хувь нь байнгын үйл ажиллагаа явуулж байна. Цалин хөлсний бүтцийн судалгааны түүврийн хүрээг тогтоохдоо 59.9 мянган буюу 29.1 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 47.1 мянга буюу 22.9 хувь нь түр зогссон, 4.7 мянга буюу 2.3 хувь нь бүрэн зогссон, 2.3 мянга буюу 1.1 хувь нь хаяг байршил тодорхойгүй болон 2021 оны эхний улиралд санхүүгийн Х тайлан өгсөн ААНБ-ыг хасаж түүврийн хүрээг тодорхойлсон. Судалгааны мэдээллийн чанар, нэгжийн хамрагдалтыг хангах, түүврийг оновчтой сонгохын тулд дараах үзүүлэлтийн харгалзан, 2727 ААНБ-ыг судалгаанд хамруулахаар тооцсон.

Үүнд:

- Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудыг;
- ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр;
- ААНБ-ын хариуцлагын хэлбэрийг;
- ААНБ-ын өмчийн хэлбэрийг;
- Газар зүйн байршлыг;

Судалгаанд хамрагдахаар сонгогдсон нийт байгууллагын 69.1 хувь нь Улаанбаатар хот, 30.9 хувь нь орон нутагт байнгын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд байна.

## 1.5. Түүврийн хэмжээ

Судалгааны түүврийн хэмжээг тооцохдоо өмнө хийгдсэн судалгааны мэдээллийг харьцуулах боломжийг бүрдүүлэх үүднээс ажиллагчдын тооны бүлэг, дизайныг хэвээр хадгалсан. Тухайн жилийн ААНБ-ын тоо, тэдгээрт ажиллаж буй ажиллагчдын тооны өөрчлөлтөөс хамаарч ЭЗҮА-ны салбарыг ажиллагчдын тооны бүлгийн хуваарилалттай хосолмол болгон түүврийн хүрээг үүсгэсэн. Энэ нь түүврийн дизайны онцлогийг илэрхийлэх бөгөөд, түүврийн жигд оновчтой хуваарилалт хийх боломжийг бүрдүүлсэн. ААНБ-ын ажиллагчдын тооны интервалаар дараах бүлгийг үүсгэж бүлгийн дагуу

түүврийн хүрээг хуваарилсан. Судалгаанд хамрагдах ААНБ-ын хэмжээг тодорхойлох арга аргачлалын  дагуу 150 ба түүнээс дээш ажиллагчидтай ААН-үүдийг нэлэнхүйд нь судалгаанд хамруулна.

*Хүснэгт 1.1 ААНБ, ажиллагчдын эзлэх хувь ажиллагчдын тооны бүлэг*

| Бүлэг | Ажиллагчдын тоо | ААНБ-ийн эзлэх хувь | Ажиллагчдын эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | 1 - 5 | 39.5 | 87.5 |
| 2 | 6 - 19 | 14.9 | 5.4 |
| 3 | 20 - 49 | 3.8 | 4.3 |
| 4 | 50 - 149 | 16.7 | 2,8 |
| 5 | 150+ | 25.0 | |
| | | 100.0 | 100.0 |

Судалгааны үндсэн үр дүнг ЭЗҮА-ны салбар болон бусад үндсэн үзүүлэлтээр тооцох бөгөөд 2019 оны судалгааны түүврийн дизайныг хэвээр хадгалснаар өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулах боломжийг хангасан юм.

## 1.6.Түүврийн хэмжээг тооцох

Судалгаанд 150 ба түүнээс дээш ажиллагчидтай  байгууллагыг нэлэнхүй хамруулах учир түүврийн хүрээ  5 дугаар бүлгийн ААН-үүдийн тоогоор багасна. 2021 оны нэг дүгээр улирлын байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа ААНБ-ын 683 нэгж нь 150 ба түүнээс дээш ажиллагчидтай байна.

Иймд 91685-683=91002 гэсэн хүрээнээс хоёр дахь түүврийн хэмжээг тодорхойлно.

Түүврийн хэмжээг тодорхойлохдоо дараах томьёог ашиглана. Үүнд:

$$n_{SRS} = \left( \frac{z_{\alpha/2} \cdot S}{e} \right)^2 \quad (1)$$

Судалгааны түүвэр нь 95 хувийн ач холбогдолтой байх түвшинд статистик тооцооллын утгыг авч үздэг бөгөөд энэ үед t статистикийн утга 1.96 гэсэн утгыг авдаг. Нөгөөтээгүүр бид үлдсэн эх олонлогийн түвшинд ажиллагчдын тооны дундаж болон стандарт хазайлтыг тооцоход дараах үр дүн гарсан.

$$\bar{y} = 6.06 \qquad S = 23.7$$

Харьцангуй алдааг ойролцоогоор 9.0 хувь байна гэж үзвэл бидний таамаглаж байгаа түүврийн харьцангуй алдааны хязгаар e=0.09* 6.06=0.54 болно. Дээрх утгуудыг түүврийн томьёонд орлуулан тооцъё.

$$n = \left( \frac{Z_{\alpha/2} * S}{e} \right)^2 = \left( \frac{1.96 * 23.7}{0.54} \right)^2 = 2044$$

Хэрвээ N буюу эх олонлогийн хэмжээг харьцангуй бага гэж үзвэл (2) томьёоны дагуу шинэчлэн тооцож болно.

$$n = \frac{n_{SRS}}{1 + \frac{n_{SRS}}{N}} \quad (2)$$

Улмаар $n = \frac{2091}{1+\frac{2091}{91002}} = 2044$ болно.

Ингэвэл бидний түүврийн нийт хэмжээ  n(f)=683+2044=2727

### 1.7. Түүврийн хуваарилалт

Ажиллагчдын тооны бүлгээр 5 дугаар бүлэг нь нэлэнхүй түүвэр учир ямар нэгэн байдлаар хуваарилах шаардлагагүй. Бусад буюу 1-4 дүгээр бүлгийн ажиллагчдын тооны бүлэгт 2044 нэгжийг хуваарилах шаардлага гарч байна.

Өгөгдсөн түүврийн хэмжээг(n*) бүлгүүдэд хуваарилах дараах аргууд байдаг.

1. Пропорционал хуваарилалт буюу эх олонлогийн тодорхой мэдээлэл (стандарт хэлбэлзэл) өгөгдөөгүй бөгөөд энгийн хуваарилалтыг хийхийг хүсэж байгаа үед ашигладаг арга

$$(3)\quad n_h = \frac{N_h}{N} \cdot n^*$$

2. Оновчтой буюу Ньюманы (Neyman) хуваарилалт буюу бүлэг тус бүрийн стандарт хэлбэлзлийн талаарх мэдээлэл өгөгдсөн үед эх олонлогийн нийт хэмжээтэй уялдуулан жигнэж бүлэг тус бүрийн түүврийн хэмжээг тогтоодог оновчтой арга.

$$(4)\quad n_h = n^* \cdot \frac{N_h S_h}{\sum_{h=1}^{H} N_h S_h}$$

3. Зардлын хувьд зохистой хуваарилалт нь оновчтой хуваарилалтын өргөтгөсөн арга буюу өгөгдсөн нэгжийн зардлын түвшинд түүврийн хэмжээг оновчтой хуваарилах арга юм.

$$(5)\quad n_h = n^* \cdot \frac{N_h S_h (1/\sqrt{C_h})}{\sum_{h=1}^{H} N_h S_h (1/\sqrt{C_h})}$$

Дээрх 3 аргаас ихэвчлэн оновчтой (Neyman) хуваарилалтын аргыг илүү өргөн ашигладаг. Тус судалгааны эх олонлогийн бүлгүүдийн стандарт хазайлт мэдэгдэж байгаа болохоор 2 дахь аргыг ашигласан.

*Хүснэгт 1.2 Түүврийн хэмжээ, салбар, ажиллагчдын тооны бүлгээр*

| Код | Салбарын нэр | Ажиллагчдын тооны бүлэг | | | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | |
| A | ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 40 | 8 | 1 | 5 | 3 | 57 |
| B | Уул уурхай, олборлолт | 11 | 9 | 3 | 16 | 64 | 103 |
| C | Боловсруулах үйлдвэрлэл | 77 | 31 | 7 | 35 | 80 | 230 |
| D | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 2 | 6 | 1 | 7 | 25 | 41 |
| E | Ус хангамж: Бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 1 | 2 | 1 | 7 | 16 | 27 |
| F | Барилга | 104 | 56 | 9 | 27 | 82 | 85 |
| G | Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ | 424 | 79 | 12 | 59 | 92 | 666 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| H | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 29 | 12 | 5 | 30 | 63 | 139 |
| I | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 37 | 14 | 2 | 15 | 17 | 85 |
| J | Мэдээлэл, холбоо | 25 | 8 | 2 | 6 | 14 | 55 |
| K | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 30 | 5 | 2 | 9 | 20 | 66 |
| L | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 20 | 6 | 2 | 5 | 7 | 40 |
| M | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 68 | 19 | 5 | 24 | 18 | 134 |
| N | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 40 | 14 | 4 | 11 | 22 | 91 |
| P | Боловсрол | 40 | 64 | 35 | 166 | 83 | 388 |
| Q | Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 36 | 47 | 8 | 12 | 62 | 165 |
| R | Урлаг, үзвэр, тоглоом наадам | 16 | 9 | 2 | 8 | 5 | 40 |
| S | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 77 | 18 | 3 | 14 | 10 | 122 |
| | Нийт ААНБ | 1077 | 407 | 104 | 456 | 683 | 2727 |

### 1.8. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Тус судалгааг улсыг хэмжээнд гүйцэтгэсэн бөгөөд мэдээллийг сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн судлаачид түүвэрт сонгогдсон ААНБ бүрээр зочилж, цуглуулсан. Судалгааны асуулгыг хүлээж авахдаа мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг хангах үүднээс ярилцлагын үед хийгдсэн аудио бичлэгтэй тулгалт хийх хяналтыг тогтмол явуулж, тодорхойгүй буюу шаардлага хангаагүй мэдээллийг тодруулж, баталгаажуулсан. Цуглуулсан мэдээллийг CSPro программаар бэлтгэн, засварласан, харин боловсруулалтыг Stata.15 программыг ашиглан гүйцэтгэлээ.

### 1.9. Тайлангийн бүтэц, агуулга

Цалин хөлсний бүтцийн судалгааны тайлан нь дараах 7 бүлгээс бүрдэнэ. Тайлангийн Бүлэг 1-т судалгааны аргачлалын талаар, Бүлэг 2-т цалин хөлсний бүтэц болох үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшууллын талаар дэлгэрэнгүй, Бүлэг 3-т судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг нас, хүйс, аймаг, нийслэл, бүс, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, ажиллагчдын тооны бүлэг болон эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргээр тодруулна, мөн үйлдвэрчний эвлэлтэй эсэх тухай, Бүлэг 4-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /ХХДХ/ болон түүнээс багаар цалинжиж буй ажиллагчдын талаар, Бүлэг 5-д ажлын өдөр болон ажлын цагийн үзүүлэлт, цар тахлын нөлөө, бусад хүчин зүйлтэй хэрхэн холбогдож буй талаар, Бүлэг 6-д тус судалгаанд үндэслэн гарсан нийт болон үндсэн цалингийн үр дүнг 2019 онд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулсан үр дүн, өөрчлөлтийг, Бүлэг 7-д Ажил олгогчдын хөдөлмөр эрхлэлт түүнтэй холбоотой гарсан зардал тооцсон байдлаар харуулсан бөгөөд эцэст нь судалгааны дүгнэлт, санал зөвлөмжийг оруулсан болно.

Тайлангийн энэ бүлэгт судалгаанд хамрагдсан ажиллагчдын нийт цалин хөлсний бүтэц болох үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал зэрэг бүрэлдэхүүнийг ААНБ-ын ажиллагчдын тооны бүлэг, байршил, аймаг, бүс, байгууллагын хариуцлагын болон өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажиллагчдын нас, хүйс, боловсрол, мэргэжлийн үндсэн ангилал зэргээр харьцуулан үр дүнг танилцуулна.

# II
# БҮЛЭГ

## ЦАЛИН ХӨЛСНИЙ БҮТЭЦ



## 2.1. Нийт цалин

Судалгаанд хамрагдсан байгууллагын ажиллагчдын нийт цалингийн дундаж улсын хэмжээнд 1.087.7 мянган төгрөг байна.

*Зураг 2.1 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц /хувь/*




Нийт цалингийн 84.0 хувийг буюу 913.1 мянган төгрөг нь үндсэн цалин, 108.3 мянган төгрөг буюу 10.0 хувийг нэмэгдэл цалин, 56.1 мянган төгрөг буюу 5.2 хувийг нэмэгдэл хөлс, үлдсэн 10.2 мянган төгрөг буюу 0.9 хувийг шагнал урамшуулал ээлж байна.

ААНБ-ын ажиллагчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлт болох ажиллагчдын ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэрэг, ажлын гүйцэтгэл буюу хийснээр, ажлын байран дахь ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтээр үндсэн болон нийт цалин, цалингийн бүрэлдэхүүн тэдгээрийн дунджаар харьцуулан авч үзлээ.

Цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр ажил олгогчдын 21.1 хувь нь ажиллагчдын ажилласан жилээр, 5.3 хувь нь ур чадвар мэргэжлийн зэргээр, 25.5 хувь нь ажлын гүйцэтгэл буюу хийснээр, 48.1 хувь нь ажлын байран дах ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтээр үндсэн цалин тооцож байна.

*Зураг 2.2 Ажил олгогчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр /хувь/*




ААНБ-ын ажиллагчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр ангилан, нийт цалингийн хэмжээтэй харьцуулан харвал *ур чадвар мэргэжлийн зэрэг, гүйцэтгэлээр буюу хийснээр, ажил үүрэг, албан тушаалаар* харгалзан тогтоосон нийт цалин улсын нийт дундаж цалингаас 11.2 хувиар, *ур чадвар мэргэжлийн зэрэг, ажил үүрэг албан тушаалаар* харгалзан үндэслэн цалингаа тогтоолгосон ажиллагчдын нийт цалин 7.3 хувиар өндөр байна. Харин *ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэрэг, гүйцэтгэлд* суурилан тогтоосон цалинтай ажиллагчдын дундаж нийт цалин улсын дунджаас 26.2 хувиар бага байна.

*Хүснэгт 2.1 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, цалин тооцож буй нийт үзүүлэлтээр /мян төг/*

| ААНБ-ын цалин тооцож буй үзүүлэлт | Нийт цалингийн дундаж /мян, төг/ | Үүнээс: бүтэц, хувиар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Үндсэн цалин | Нэмэгдэл | Нэмэгдэл хөлс | Шагнал урамшуулал |
| Улсын дундаж | 1087.7 | 913.1 | 108.3 | 56.1 | 10.2 |
| АЖ | 1014.4 | 772.7 | 166.8 | 65.2 | 9.8 |
| УЧ | 1127.9 | 1022.9 | 60.7 | 42.5 | 1.8 |
| ГХ | 1031.6 | 941.5 | 53.6 | 33.6 | 2.8 |
| АБ | 1146.7 | 1004.8 | 78.9 | 49.4 | 13.6 |
| АЖ + УЧ | 1117.5 | 881.5 | 179.8 | 40.1 | 16.2 |
| АЖ + ГХ | 1010.9 | 813.5 | 117.2 | 73.6 | 6.5 |
| АЖ + АБ | 1071.6 | 920.7 | 113.5 | 35.8 | 1.7 |
| УЧ + ГХ | 1162.1 | 1024.4 | 120.5 | 11.4 | 5.8 |
| УЧ + АБ | 1167.1 | 884.6 | 147.9 | 119.7 | 14.9 |
| ГХ + АБ | 1119.7 | 945.9 | 84.1 | 79.0 | 10.7 |
| АЖ + УЧ + ГХ | 802.8 | 740.2 | 56.1 | 6.4 | 0.1 |
| АЖ + УЧ + АБ | 1112.8 | 967.3 | 142.4 | 0.0 | 3.1 |
| АЖ + ГХ + АБ | 1156.1 | 1148.7 | 6.2 | 0.4 | 0.9 |
| УЧ + ГХ + АБ | 1209.0 | 911.3 | 80.4 | 215.8 | 1.6 |
| АЖ + УЧ + ГХ + АБ | 1129.4 | 840.8 | 215.4 | 68.0 | 5.1 |

*АЖ - Ажилласан жилээр* *ГХ- Гүйцэтгэлээр буюу хийснээр*

*УЧ - Ур чадвар, мэргэжлийн зэргээр* *АБ - Ажил үүрэг, албан тушаал*

ААНБ-ын нийт цалингийн дунджийг байршлаар харьцуулан авч үзвэл Орхон аймаг (1.161 мянган төгрөг), Улаанбаатар хотод (1.141 мянган төгрөг) улсын дунджаас 53.5 - 73.4 мянган төгрөгөөр илүү байна. Харин Булган аймаг (653.3 мянган төгрөг), Хэнтий аймагт (860.5 мянган төгрөг) улсын дунджаас 227.2 - 434.4 мянган төгрөгөөр бага байна.

Ажиллагчдын улсын нийт цалингийн дундаж, цалин хөлсний бүтцийг ААНБ-ын байршил, бүс ажиллагчдын хүйсээр харьцуулан хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 2.2 ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж, байршил /мян төг/*

| Байршил, бүс, аймаг, нийслэл | Нийт цалингийн дундаж /мян, төг/ | | | Үүнээс: бүтэц, хувиар | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| Улсын дундаж | 1087.7 | 1151.9 | 1030.2 | 913.1 | 985.5 | 848.3 | 108.3 | 95.3 | 119.9 | 56.1 | 60.3 | 52.4 | 10.2 | 10.8 | 9.6 |
| Баруун бүс | 929.4 | 891.6 | 954.7 | 712.3 | 711.0 | 713.2 | 167.0 | 129.2 | 192.3 | 41.3 | 42.1 | 40.8 | 8.8 | 9.4 | 8.4 |
| Баян-Өлгий | 872.9 | 835.0 | 894.4 | 698.2 | 674.0 | 711.9 | 130.2 | 112.6 | 140.2 | 39.4 | 47.1 | 35.1 | 5.1 | 1.3 | 7.3 |
| Говь-Алтай | 1041.5 | 952.3 | 1084.2 | 746.6 | 750.0 | 744.9 | 262.1 | 177.7 | 302.5 | 23.3 | 17.8 | 25.9 | 9.5 | 6.8 | 10.8 |
| Завхан | 861.6 | 804.1 | 893.3 | 689.7 | 672.0 | 699.4 | 140.5 | 111.0 | 156.8 | 15.2 | 8.8 | 18.7 | 16.3 | 12.3 | 18.5 |
| Увс | 946.9 | 901.6 | 982.6 | 692.4 | 683.3 | 699.6 | 191.8 | 161.3 | 215.8 | 52.4 | 37.2 | 64.4 | 10.3 | 19.8 | 2.8 |
| Ховд | 930.1 | 959.2 | 895.5 | 752.0 | 788.9 | 708.0 | 98.0 | 80.9 | 118.4 | 77.0 | 85.3 | 67.0 | 3.1 | 4.0 | 2.1 |
| Хангайн бүс | 985.5 | 1026.4 | 958.9 | 725.9 | 741.1 | 716.1 | 156.7 | 161.4 | 153.7 | 89.0 | 107.0 | 77.3 | 13.8 | 16.9 | 11.8 |
| Архангай | 945.9 | 1003.4 | 914.8 | 733.9 | 771.3 | 713.6 | 106.7 | 107.0 | 106.5 | 89.8 | 112.4 | 77.6 | 15.5 | 12.6 | 17.1 |
| Баянхонгор | 1079.1 | 1002.0 | 1115.4 | 730.6 | 721.7 | 734.8 | 249.6 | 200.1 | 272.8 | 83.3 | 70.1 | 89.5 | 15.6 | 10.0 | 18.2 |
| Булган | 653.3 | 609.3 | 688.3 | 575.3 | 584.6 | 567.9 | 77.6 | 24.4 | 119.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.4 | 0.3 | 0.4 |
| Орхон | 1161.1 | 1347.3 | 1042.8 | 808.3 | 869.7 | 769.2 | 195.3 | 269.2 | 148.4 | 133.3 | 164.1 | 113.7 | 24.2 | 44.3 | 11.5 |
| Өвөрхангай | 893.3 | 844.6 | 928.3 | 642.8 | 603.2 | 671.2 | 131.7 | 82.9 | 166.8 | 118.8 | 158.5 | 90.3 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хөвсгөл | 899.7 | 931.8 | 872.3 | 707.1 | 714.4 | 700.9 | 145.3 | 159.6 | 133.0 | 36.2 | 48.5 | 25.7 | 11.1 | 9.3 | 12.6 |
| Төвийн бүс | 1026.1 | 1087.4 | 982.3 | 798.7 | 860.5 | 754.5 | 123.1 | 108.3 | 133.8 | 85.4 | 94.8 | 78.6 | 18.9 | 23.8 | 15.4 |
| Говьсүмбэр | 975.3 | 982.5 | 971.2 | 717.3 | 725.8 | 712.5 | 71.1 | 65.1 | 74.6 | 163.9 | 172.1 | 159.1 | 23.0 | 19.5 | 25.0 |
| Дархан-Уул | 1028.5 | 1177.7 | 921.5 | 749.9 | 812.4 | 705.1 | 142.9 | 169.6 | 123.8 | 91.5 | 129.9 | 63.9 | 44.2 | 65.7 | 28.7 |
| Дорноговь | 1004.1 | 1047.3 | 974.7 | 796.4 | 884.3 | 736.8 | 116.9 | 68.6 | 149.6 | 89.7 | 93.3 | 87.2 | 1.1 | 1.1 | 1.2 |
| Дундговь | 974.2 | 880.7 | 1010.7 | 694.2 | 689.7 | 695.9 | 190.2 | 120.5 | 217.3 | 73.7 | 61.1 | 78.6 | 16.2 | 9.4 | 18.9 |
| Өмнөговь | 1035.1 | 1068.2 | 1006.3 | 913.7 | 931.3 | 898.4 | 36.2 | 28.9 | 42.6 | 84.5 | 107.9 | 64.1 | 0.7 | 0.1 | 1.2 |
| Сэлэнгэ | 1047.5 | 1057.6 | 1039.1 | 818.3 | 900.0 | 749.9 | 132.8 | 106.7 | 154.6 | 86.7 | 46.8 | 120.1 | 9.8 | 4.0 | 14.5 |
| Төв | 1078.1 | 1103.5 | 1054.7 | 903.6 | 956.9 | 854.2 | 119.3 | 96.7 | 140.3 | 53.1 | 48.5 | 57.3 | 2.1 | 1.4 | 2.9 |
| Зүүн бүс | 1011.5 | 1114.1 | 946.8 | 779.0 | 852.9 | 732.4 | 177.2 | 187.5 | 170.7 | 48.2 | 64.6 | 37.8 | 7.1 | 9.1 | 5.9 |
| Дорнод | 1068.6 | 1219.2 | 963.2 | 807.3 | 915.0 | 731.9 | 214.5 | 263.1 | 180.5 | 38.1 | 35.1 | 40.2 | 8.7 | 6.0 | 10.6 |
| Сүхбаатар | 1064.4 | 1159.8 | 1007.8 | 797.8 | 873.4 | 752.8 | 186.4 | 160.8 | 201.6 | 71.1 | 105.7 | 50.5 | 9.2 | 19.8 | 2.9 |
| Хэнтий | 860.5 | 861.0 | 860.2 | 711.8 | 710.1 | 712.7 | 104.7 | 68.9 | 124.6 | 41.7 | 78.0 | 21.4 | 2.3 | 3.9 | 1.4 |
| Улаанбаатар | 1141.2 | 1204.8 | 1074.8 | 999.7 | 1069.0 | 927.1 | 84.7 | 76.0 | 93.7 | 48.4 | 51.2 | 45.5 | 8.5 | 8.6 | 8.5 |
| Улаанбаатар | 1141.2 | 1204.8 | 1074.8 | 999.7 | 1069.0 | 927.1 | 84.7 | 76.0 | 93.7 | 48.4 | 51.2 | 45.5 | 8.5 | 8.6 | 8.5 |

Цалин хөлсний бүтцийг бүсээр харьцуулан авч үзвэл Улаанбаатар хотын ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн 87.6 хувь нь үндсэн цалин, 7.4 хувь нь нэмэгдэл, 4.2 хувь нь нэмэгдэл хөлс, 0.7 хувийг шагнал урамшуулал байгаа нь улсын дундажтай харьцуулахад нийт цалинд эзлэх үндсэн цалин илүү харин нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал бага байна. Орон нутагт эсрэгээр буюу нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь улсын дунджаас бага, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал хувь өндөр байна.

*Зураг 2.3 Ажиллагчдын нийт цалингийн дундаж, бүсээр /хувь/*




Эдгээр үзүүлэлтийг хүйсээр харьцуулан харвал бүсүүдийн эрэгтэй ажиллагчдын нэмэгдэл хөлс 0.4 - 2.4 пунктээр, шагнал урамшуулал 0.2 - 0.6 пунктээр өндөр, харин эрэгтэй ажиллагчдын нэмэгдэл нь эмэгтэй ажиллагчдаас 0.3 - 5.7 пунктээр бага байна.

*Зураг 2.4 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, бүс, хүйсээр /хувь/*




Нийт цалинд олговор оруулан тооцсон байдлаар ажил олгогчийн үйл ажиллагаа эрхэлж буй байршил бүсээр харьцуулан авч үзвэл олговрын хэмжээ Баруун бүсэд (1.7 хувь) хамгийн өндөр бол Улаанбаатарт (0.9 хувь) хамгийн бага байна. Харин Улаанбаатарт нийт цалингийн (олговор оруулснаар) 86.8 хувийг үндсэн цалин эзэлж байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр хувийг бүрдүүлдэг байна.

*Зураг 2.5 Ажиллагчдын олговор тооцсон нийт цалингийн бүтэц /хувь/*




## 2.2. ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нийт цалин

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дунджийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын нийт цалин хамгийн өндөр буюу улсын дунджаас 46.4 хувиар ахиу байна. Түүнчлэн санхүү болон даатгалын үйл ажиллагааны, цахилгаан, хий уур, агааржуулалтын, мэдээлэл холбоо, барилга, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, тээвэр, агуулах, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллагчдын нийт цалингийн дундаж улсын дунджаас өндөр байна. Бусад салбарын хувьд нийт цалингийн дундаж улсын дунджаас бага байна. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа болон хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын ажиллагчдын нийт цалингийн дундаж хамгийн бага буюу нийт дунджаас 20.6 – 35.9 хувиар бага байгаа юм.

*Зураг 2.6 ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж, салбараар /мян төг/*



Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн бүтцийг авч үзвэл цахилгаан хий, уур агааржуулалтын хангамжийн салбарт ажиллагчдын нийт цалингийн бүтцэд эзлэх үндсэн цалин 61.7 хувь байгаа нь бусад салбартай харьцуулахад бага боловч нэмэгдэл, шагнал урамшуулал өндөр байна. Мөн хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарын ажиллагчдын хувьд дээрхитэй ижил үзүүлэлттэй байлаа.

Салбарын нийт цалингийн бүтцийг ажиллагчдын хүйсээр харьцуулж авч үзвэл санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эмэгтэй ажиллагчдын нийт цалингийн 96.9 - 98.0 хувийг үндсэн цалин бүрдүүлж байгаа нь тухайн салбаруудын эрэгтэй ажиллагчдын үндсэн цалингаас 0.7 - 1.6 пунктээр илүү байсан.

*Хүснэгт 2.3 ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр /мян төг/*

| ЭЗҮА-ны салбарын ангилал | Нийт цалингийн дундаж /мян төг/ | | | Үүнээс: бүтэц, хувиар | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| **Улсын дундаж** | 1,087.7 | 1,151.9 | 1,030.2 | 913.1 | 985.5 | 848.3 | 108.3 | 95.3 | 119.9 | 56.1 | 60.3 | 52.4 | 10.2 | 10.8 | 9.6 |
| ХАА | 863.2 | 881.0 | 839.3 | 825.7 | 849.9 | 793.1 | 27.5 | 24.8 | 31.2 | 9.8 | 6.0 | 15.0 | 0.2 | 0.4 | - |
| Уул уурхай | 1,592.8 | 1,639.1 | 1,418.6 | 1,450.1 | 1,476.3 | 1,351.4 | 91.0 | 106.9 | 31.0 | 42.8 | 46.6 | 28.4 | 8.9 | 9.3 | 7.8 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 1,094.6 | 1,181.4 | 999.5 | 944.3 | 1,022.2 | 858.9 | 69.3 | 72.4 | 65.9 | 70.2 | 75.6 | 64.3 | 10.8 | 11.2 | 10.4 |
| Цахилгаан, хий уур, агааржуулалт | 1,397.4 | 1,408.0 | 1,371.3 | 862.5 | 856.4 | 877.4 | 331.5 | 338.9 | 313.3 | 124.4 | 134.0 | 100.8 | 79.1 | 78.8 | 79.8 |
| Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 1,011.3 | 1,054.5 | 957.3 | 773.1 | 793.8 | 747.3 | 176.3 | 193.7 | 154.6 | 60.8 | 66.1 | 54.2 | 1.0 | 0.8 | 1.2 |
| Барилга | 1,205.4 | 1,209.6 | 1,196.1 | 1,110.4 | 1,104.5 | 1,123.5 | 33.8 | 35.6 | 30.1 | 56.6 | 65.0 | 37.8 | 4.6 | 4.5 | 4.8 |
| Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклийн засвар үйлчилгээ | 1,057.8 | 1,113.5 | 990.6 | 955.2 | 1,009.8 | 889.5 | 51.1 | 49.4 | 53.1 | 49.2 | 52.5 | 45.3 | 2.2 | 1.9 | 2.7 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1,121.2 | 1,079.6 | 1,259.4 | 1,034.7 | 1,002.9 | 1,140.2 | 50.6 | 35.5 | 100.6 | 31.9 | 37.5 | 13.3 | 4.1 | 3.7 | 5.3 |
| Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 930.6 | 982.7 | 895.4 | 886.3 | 937.7 | 851.6 | 26.1 | 28.4 | 24.6 | 17.1 | 15.2 | 18.3 | 1.1 | 1.4 | 1.0 |
| Мэдээлэл холбоо | 1,317.3 | 1,459.8 | 1,132.4 | 1,212.6 | 1,347.2 | 1,038.0 | 55.9 | 56.5 | 55.2 | 46.9 | 53.4 | 38.6 | 1.8 | 2.8 | 0.6 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 1,429.6 | 1,574.7 | 1,307.1 | 1,395.7 | 1,532.2 | 1,280.6 | 29.8 | 39.8 | 21.3 | 1.5 | 2.6 | 0.6 | 2.5 | - | 4.6 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 1,177.8 | 1,175.7 | 1,180.5 | 1,130.7 | 1,120.1 | 1,143.5 | 25.9 | 33.8 | 16.4 | 12.9 | 16.8 | 8.0 | 8.4 | 4.9 | 12.6 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 1,176.7 | 1,192.6 | 1,164.0 | 1,001.0 | 1,019.2 | 986.7 | 133.0 | 132.2 | 133.5 | 29.3 | 28.1 | 30.3 | 13.3 | 13.1 | 13.5 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 1,052.7 | 1,037.3 | 1,081.3 | 950.9 | 931.8 | 986.2 | 68.1 | 63.4 | 76.8 | 32.1 | 41.4 | 14.9 | 1.6 | 0.6 | 3.3 |
| Боловсрол | 971.2 | 941.0 | 981.1 | 747.1 | 726.3 | 754.0 | 166.0 | 151.4 | 170.7 | 48.6 | 53.0 | 47.2 | 9.5 | 10.4 | 9.2 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 1,064.6 | 1,118.7 | 1,047.1 | 765.2 | 783.4 | 759.2 | 158.7 | 159.3 | 158.5 | 129.9 | 165.4 | 118.4 | 10.8 | 10.6 | 10.9 |
| Урлаг, үзвэр , тоглоом наадам | 887.4 | 892.3 | 881.0 | 723.2 | 744.9 | 694.6 | 109.5 | 93.2 | 131.0 | 38.7 | 40.1 | 36.9 | 16.1 | 14.2 | 18.5 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 697.4 | 717.5 | 678.3 | 667.3 | 688.1 | 647.6 | 20.5 | 22.0 | 19.2 | 8.0 | 6.2 | 9.7 | 1.6 | 1.3 | 1.9 |

## 2.3. ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр нийт цалин

Байгууллагын хариуцлагын хэлбэрээр нийт цалингийн дунджийг харьцуулан харвал улсын хэмжээнд хоршооны ажиллагчид улсын дунджаас 33.7 хувиар, төрийн бус байгууллага 23.6 хувиар бага байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт юм. Харин хувьцаат компанийн ажиллагчид 24.9 хувиар, төрийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчид 21.9 хувиар нийт цалингийн дунджаас өндөр байна.

Эдгээр ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр нийт цалингийн бүтцийг харвал хувьцаат компанийн ажиллагчдын үндсэн цалин нийт цалингийн 73.1 хувийг бүрдүүлж байгаа ч нэмэгдэл 12.2 хувь, нэмэгдэл хөлс 9.7 хувь, шагнал урамшууллын эзлэх хувь 5.0 байна. Судалгааны дүнгээр төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нэмэгдэл хамгийн өндөр хувиар олгодог байна.

ААНБ-ын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын хүйсээр цалингийн бүтцийг харьцуулбал, эмэгтэй ажиллагчдын нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар эрэгтэй ажиллагчдынхаас 3.6 - 7.2 пунктээр өндөр байна. Харин тухайн хариуцлагын хэлбэрийн ААНБ-ын эрэгтэй ажиллагчдад нэмэгдэл болон нэмэгдэл хөлс шагнал урамшуулал илүү өндөр олгогддог байна.

*Хүснэгт 2.4 ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ажиллагчдын нийт цалингийн дундаж /хувь/*

| Байгууллагын хариуцлагын хэлбэр | Нийт цалингийн дундаж /мян төг/ | Үүнээс: бүтэц, хувиар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Үндсэн цалин | Нэмэгдэл | Нэмэгдэл хөлс | Шагнал урамшуулал |
| **Улсын дундаж** | 1087.7 | 84.0 | 10.0 | 5.2 | 0.9 |
| Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл | 902.4 | 94.6 | 3.2 | 2.1 | 0.1 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл | 1159.4 | 87.9 | 4.3 | 7.8 | 0.0 |
| Зарим гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хоршоо | 721.1 | 93.0 | 5.0 | 2.0 | 0.0 |
| Хувьцаат компани | 1358.9 | 73.1 | 12.2 | 9.7 | 5.0 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай компани | 1130.3 | 92.5 | 3.9 | 3.3 | 0.3 |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 1325.7 | 65.4 | 22.8 | 8.8 | 3.0 |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | 1036.4 | 76.2 | 21.6 | 2.0 | 0.1 |
| Төсөвт байгууллага | 994.2 | 73.1 | 18.4 | 7.3 | 1.1 |
| Төрийн бус байгууллага | 830.8 | 92.1 | 3.6 | 3.9 | 0.4 |
| Бусад | 1354.9 | 85.2 | 0.0 | 14.8 | 0.0 |

Ажиллагчдын нийт цалингийн дунджийг ААНБ-ын өмчийн хэлбэрээр авч үзэхэд нийт цалингийн улсын дунджаас төрийн өмчийн, орон нутгийн

өмчийн болон Монгол Улсын иргэний хувийн ААНБ-ын цалингийн дундаж бага харин бусад хариуцлагын хэлбэрийн ААНБ-ын цалингийн дундаж 17.7 - 48.6 хувиар өндөр байна. Ажиллагчдын нийт цалинг бүтцээр харвал орон нутгийн өмчийн (52.6 хувь) болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын (62.3 хувь) үндсэн цалин нь хамгийн бага байхад хувийн өмчийн ААНБ-уудын үндсэн цалингийн нийт цалинд эзлэх хувь хамгийн өндөр буюу 91.5 - 92.2 хүртэл хувийг бүрдүүлдэг байна.

Харин хувийн өмчийн ААНБ-уудын нийт цалинд эзлэх нэмэгдэл, нэмэгдэл хөлсний эзлэх хувь бусад өмчийн хэлбэрийн байгууллагуудтай харьцуулахад бага байдаг бол орон нутгийн өмчийн ААНБ-уудын ажиллагчдын нэмэгдэл хамгийн өндөр хувьтай байна.

*Хүснэгт 2.5 ААНБ-ын өмчийн хэлбэрээр ажиллагчдын нийт цалингийн дундаж /мян төг/*

| Байгууллагын өмчийн хэлбэр | Нийт цалингийн дундаж / мян төг/ | Цалингийн бүтэц, хувиар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Үндсэн цалин | Нэмэгдэл | Нэмэгдэл хөлс | Шагнал урамшуулал |
| **Улсын дундаж** | 1087.7 | 84.0 | 10.0 | 5.2 | 0.9 |
| Төрийн өмчийн | 1043.0 | 71.9 | 19.0 | 7.3 | 1.8 |
| Төрийн өмчийн оролцоотой | 1616.6 | 62.3 | 17.6 | 18.2 | 1.8 |
| Төрийн өмчийн хамтарсан | 1448.8 | 90.5 | 5.8 | - | 3.8 |
| Орон нутгийн өмчийн | 876.8 | 79.9 | 13.7 | 6.1 | 0.3 |
| Орон нутгийн өмчийн оролцоотой | 1280.7 | 68.5 | 27.6 | 3.9 | - |
| Орон нутгийн хамтарсан | 1348.7 | 52.7 | 47.3 | - | - |
| Хувийн Монгол улсын иргэн | 1086.4 | 92.0 | 3.9 | 3.8 | 0.3 |
| Хувийн хамтарсан | 1285.5 | 91.5 | 4.3 | 3.2 | 1.0 |
| Хувийн гадаадын иргэн | 1455.1 | 92.2 | 4.4 | 2.9 | 0.5 |

## 2.4. Ажиллагчдын боловсрол, мэргэжлийн үндсэн ангиллаар нийт цалин

Ажиллагчдын боловсролын түвшингээр нийт цалингийн дунджийг авч үзвэл боловсролын түвшин нэмэгдэхэд нийт цалингийн дундаж нэмэгддэг байна. Магистр болон докторын зэрэгтэй ажиллагчдын цалин хамгийн өндөр буюу улсын дунджаас 40.6 хувиар өндөр юм. Суурь болон түүнээс доош боловсролтой ажиллагчдын нийт цалингийн дундаж улсын дунджаас 28.0 - 29.3 хувиар бага байгаа зэргээс харахад боловсролын түвшин нийт цалингийн дундажтай эерэг хамааралтай болохыг харуулж байна.

Судалгааны дүнгээр эрэгтэй ажиллагчдын нийт цалингийн дундаж нь 1151.9 мянган төгрөг, эмэгтэй ажиллагчдынх 1030.2 мянган төгрөг байна. Магистр болон докторын зэрэгтэй эрэгтэй ажиллагчдын нийт цалингийн дундаж (эрэгтэй ажиллагчдын) улсын дунджаас 60.4 хувиар өндөр байгаа бол мөн зэрэгтэй эмэгтэй ажиллагчдынх (эмэгтэй ажиллагчдын) улсын дунджаас 28.2 хувиар өндөр байна. Харин суурь болон түүнээс бага боловсролтой эрэгтэй ажиллагчдынх (эрэгтэй ажиллагчдын) улсын дунджаас 23.5 – 33.7

хувиар бага бол бүрэн дунд, суурь боловсролтой эмэгтэй ажиллагчдын нийт цалингийн дундаж (эмэгтэй ажиллагчдын) улсын нийт дунджаас 31.4 -37.0 хувиар бага байна.

Цалингийн бүтцийн хувьд Хүснэгт 2.6-с дэлгэрэнгүй харж болно.

*Хүснэгт 2.6 Нийт цалингийн бүтэц, ажиллагчдын боловсролын түвшинээр.*

| Ажил мэргэжлийн ангилал | Нийт цалингийн дундаж /мян, төг/ | | | Үүнээс: бүтэц, хувиар | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| Улсын дундаж | 1087.7 | 1151.9 | 1030.2 | 84.0 | 85.6 | 82.3 | 10.0 | 8.3 | 11.6 | 5.2 | 5.2 | 5.1 | 0.9 | 0.9 | 0.9 |
| Боловсролгүй | 792.3 | 759.4 | 829.3 | 85.5 | 84.5 | 86.5 | 8.4 | 8.3 | 8.6 | 6.0 | 7.2 | 4.7 | 0.1 | 0.0 | 0.2 |
| Бага | 783.7 | 721.0 | 856.0 | 88.0 | 81.6 | 94.2 | 4.4 | 6.8 | 2.0 | 7.5 | 11.4 | 3.7 | 0.2 | 0.3 | 0.1 |
| Суурь | 768.8 | 832.3 | 685.4 | 80.3 | 80.4 | 80.1 | 10.0 | 9.7 | 10.5 | 8.3 | 8.2 | 8.5 | 1.4 | 1.7 | 0.9 |
| Бүрэн дунд | 845.9 | 926.6 | 746.1 | 84.9 | 85.1 | 84.5 | 8.6 | 8.2 | 9.1 | 5.8 | 5.8 | 5.7 | 0.7 | 0.8 | 0.7 |
| Техникийн болон мэргэжлийн | 1000.5 | 1081.0 | 838.4 | 83.1 | 83.4 | 82.4 | 8.7 | 8.3 | 9.9 | 7.0 | 7.3 | 6.5 | 1.1 | 1.1 | 1.2 |
| Тусгай мэргэжлийн дунд | 1009.3 | 1053.1 | 965.2 | 80.9 | 84.4 | 77.2 | 9.8 | 7.1 | 12.7 | 8.2 | 7.9 | 8.6 | 1.1 | 0.6 | 1.6 |
| Дээд | 1184.1 | 1278.0 | 1119.0 | 84.3 | 86.5 | 82.5 | 10.4 | 8.3 | 12.1 | 4.4 | 4.2 | 4.5 | 4.4 | 4.2 | 4.5 |
| Магистр, доктор | 1529.6 | 1744.4 | 1394.9 | 82.0 | 84.5 | 80.0 | 11.4 | 9.1 | 13.1 | 5.5 | 5.3 | 5.8 | 1.1 | 1.1 | 1.1 |

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын мэргэжлийн үндсэн ангиллыг нийт цалингийн дундаж болон цалингийн бүтцээр харьцуулан авч үзье. ХАА, загас агнуур (628.1 мянган төгрөг), энгийн ажил мэргэжил (721.4 мянган төгрөг), худалдаа үйлчилгээний ажилтан (762.6 мянган төгрөг) нь нийт цалингийн дундаж хамгийн бага ажил мэргэжилд багтдаг. Энэ нь урьдын судалгаануудын үр дүнтэй адилхан байгаа юм. ХАА, загас агнуурын эмэгтэй ажиллагчдын цалин (эмэгтэй ажиллагчдын) улсын нийт дунджаас бараг 42.6 хувиар бага байна.

Удирдах ажилтан, менежерийн нийт цалин улсын дунджаас өндөр хэвээр байна. Энэ ажил мэргэжлийн эрэгтэй ажиллагчдын цалин (эрэгтэй ажиллагчдын) улсын дунджаас 24 хувиар өндөр байна. Ажиллагчдын үндсэн мэргэжлийн ангилал, ажил үүргээс шалтгаалсан цалингийн бүтэц дэх хүйсийн ялгааг доорх хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 2.7 Ажиллагчдын нийт цалингийн бүтэц, ажил мэргэжлийн үндсэн ангилал*

| **Ажил мэргэжлийн ангилал** | **Нийт цалингийн дундаж /мян, төг/** | | | **Үүнээс: бүтэц, хувиар** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Үндсэн цалин** | | | **Нэмэгдэл** | | | **Нэмэгдэл хөлс** | | | **Шагнал урамшуулал** | | |
| | **Нийт** | **Эр** | **Эм** | **Нийт** | **Эр** | **Эм** | **Нийт** | **Эр** | **Эм** | **Нийт** | **Эр** | **Эм** | **Нийт** | **Эр** | **Эм** |
| Улсын дундаж | **1087.7** | **1151.9** | **1030.2** | **84.0** | **85.6** | **82.3** | **10.0** | **8.3** | **11.6** | **5.2** | **5.2** | **5.1** | **0.9** | **0.9** | **0.9** |
| Хууль тогтоогч, удирдах албан тушаалын ажилтан, менежер | 1380.2 | 1430.4 | 1335.4 | 90.9 | 91.4 | 90.3 | 5.7 | 5.7 | 5.8 | 2.9 | 2.4 | 3.3 | 0.6 | 0.5 | 0.6 |
| Мэргэжилтэн | 1182.6 | 1287.4 | 1116.5 | 83.1 | 86.0 | 81.1 | 11.2 | 8.7 | 13.0 | 4.7 | 4.4 | 4.9 | 1.0 | 1.0 | 1.0 |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Инженер, техникийн ажилтан | 1061.7 | 1253.0 | 896.1 | 82.9 | 83.4 | 82.3 | 8.9 | 8.1 | 9.8 | 7.1 | 7.4 | 6.6 | 1.1 | 1.1 | 1.2 |
| Бичиг хэргийн туслах ажилтан | 986.5 | 1135.7 | 890.3 | 89.2 | 92.1 | 86.8 | 7.6 | 4.8 | 9.8 | 2.4 | 2.8 | 2.1 | 0.8 | 0.3 | 1.3 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 762.6 | 745.8 | 787.9 | 84.7 | 84.4 | 85.0 | 8.9 | 7.7 | 10.6 | 5.9 | 7.4 | 3.8 | 0.5 | 0.5 | 0.6 |
| ХАА, загас, ан агнуурын ажилтан | 628.1 | 700.8 | 591.7 | 89.8 | 90.8 | 89.2 | 5.9 | 6.0 | 5.9 | 3.5 | 3.3 | 3.7 | 0.7 | 0.0 | 1.2 |
| Үйлдвэр, худалдааны ажилтан | 1044.4 | 1106.9 | 871.6 | 81.2 | 81.7 | 79.5 | 10.4 | 10.0 | 11.9 | 6.5 | 6.3 | 7.3 | 1.9 | 2.1 | 1.3 |
| Машин тоног төхөөрөмжийн оператор | 1038.9 | 1041.3 | 1019.7 | 82.0 | 81.5 | 85.7 | 9.0 | 9.4 | 5.8 | 8.2 | 8.3 | 7.7 | 0.8 | 0.7 | 0.9 |
| Энгийн ажил мэргэжил | 721.4 | 823.2 | 672.2 | 86.2 | 87.9 | 85.3 | 8.4 | 5.6 | 10.1 | 4.8 | 6.1 | 4.0 | 0.6 | 0.5 | 0.6 |
| Зэвсэгт хүчний | 1449.5 | 1449.5 | 0.0 | 90.9 | 90.9 | 0 | 9.1 | 9.1 | 0 | 0.0 | 0.0 | 0 | 0.0 | 0.0 | 0 |
| Мэргэжилгүй | 827.5 | 895.3 | 750.2 | 86.0 | 86.6 | 85.1 | 7.5 | 6.8 | 8.3 | 6.0 | 6.0 | 6.0 | 0.6 | 0.6 | 0.6 |

## 2.5. Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын нийт цалин

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын 3.2 хувь нь бүрэн бус цагаар буюу 7 хоногт дунджаар 36.7 цаг хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй, дундаж нас 41.3 байгаа юм. Эмэгтэй ажиллагчдын 7 хоногийн ажлын дундаж цаг эрэгтэйчүүдээс 1.2 цагаар бага байна. Ажиллагчдын 27.1 хувь нь 6 - 19 ажиллагчидтай ААНБ-д хөдөлмөр эрхэлж байна.

*Зураг 2.7 Бүрэн бус цагаар ажиллагчид, насны болон ажиллагчдын тооны бүлгээр /хувь/*




Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчид улсын нийт цалингийн дунджаас бага цалинтай байна. Цалингийн бүтцийн хувьд үндсэн цалин 90.9 хувийг, нэмэгдэл 4.3 хувийг, нэмэгдэл хөлс 4.3 хувийг, шагнал урамшуулал 0.5 хувийг бүрдүүлж байна.

*Хүснэгт 2.8 Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчдийн цалингийн бүтэц, хүйсээр*

| ББ цагаар ажиллагч | Нийт цалин | Үндсэн цалин | Нэмэгдэл | Нэмэгдэл хөлс | Шагнал урамшуулал |
|---|---|---|---|---|---|
| Дундаж цалин | 806.2 | 732.7 | 34.8 | 34.9 | 3.8 |
| Эрэгтэй | 785.5 | 718.8 | 21.5 | 43.2 | 2.1 |
| Эмэгтэй | 836.3 | 752.9 | 54.1 | 23.0 | 6.3 |

ААНБ-ын ЭЗҮА-ны салбараар харвал тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар (12.4 хувь), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар (11.1 хувь), бөөний болон жижиглэн худалдааны салбарт (11.0 хувь) хамгийн олон бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчид байна. Уул уурхайн салбарт ажиллаж буй ажиллагчид улсын нийт дундаж цалингаас өндөр бусад салбарт улсын нийт цалингийн дунджаас бага цалингаар 7 хоногт дунджаар 37.2 цаг хөдөлмөр эрхэлж байна. Тодруулбал санхүү даатгалын салбарт 18.5 цагаар, тээвэр ба агуулахын салбарт 27.2 цагаар хамгийн бага цаг ажилладаг бол хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт 43.3 цаг, мэдээлэл холбооны салбарт 44 цагаар хамгийн их цаг ажилладаг байна.

*Зураг 2.8 Бүрэн бус цагаар ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/*




## 2.6. Гадаад ажиллагчдын нийт цалин

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 0.5 хувь гадаадын харьяат иргэд бөгөөд ажиллагчдын нийт цалингийн дунджийг авч үзвэл улсын нийт цалингийн дунджаас 61.5 хувиар өндөр байна. Цалингийн бүтцийн хувьд 98.7 хувь нь үндсэн цалин байна.

*Зураг 2.9 Гадаад ажиллагчдын нийт цалингийн бүтэц /хувь/*




Гадаад ажиллагчдын 95 хувь нь Улаанбаатар хотод ажил хөдөлмөр эрхэлж байгаа ба ажиллагчдын 24.0 хувь нь барилгын салбарт, 16.5 хувь боловсролын салбарт, мөн хувь нь уул уурхайн салбарт, 14.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарын ААНБ -д ажиллаж байна.

## 2.7. Шагнал урамшуулал олгосон байдал

ААНБ-ын ажиллагчдын 10.1 хувь нь шагнал урамшуулалд хамрагдсан байна. Шагнал урамшуулалд хамрагдсан ажиллагчдын 58.8 хувь нь эмэгтэй, 41.2 хувь нь эрэгтэй байна. ААНБ шагналыг тооцохдоо үндсэн цалингийн дүнгээс дунджаар 10.2 хувиар тооцож, шагнал урамшуулал олгожээ.

Шагнал урамшуулал авсан ажиллагчдын ААНБ-ыг хариуцлагын хэлбэрээр тодруулбал, 20.9 хувийг ХХК, 52.4 хувийг төсөвт байгууллагын ажиллагчид эзэлж байна. Хувьцаат компанийн нэг хүнд ногдох шагнал урамшууллын хэмжээ нь бусдаас өндөр байна.

*Зураг 2.10 ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр шагнал урамшуулал авсан ажиллагчид, шагнал урамшууллын хэмжээ /тоо, хувь/*




Төсөвт байгууллагын ажиллагчид шагнал урамшуулалд хамгийн их хамрагдсан (1224 ажиллагч) бөгөөд хэмжээ нь улсын дундажтай ойролцоо үндсэн цалингийн 11.1 хувь байна. Харин хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчид үндсэн цалингийн 67.5, 39.4 хувиар тус бүр шагнагдсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

## 2.8. Цалин хөлсийг өөрчилсөн шийдвэр

Судалгаанд хамрагдсан нийт 2474 ААНБ-ын 541 буюу 21.9 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд цалин хөлсөө дунджаар 15.6 хувиар нэмэгдүүлсэн байна. Харин нийт ААНБ-ын 3.7 хувь нь ажил олгогчдын шийдвэрээр ажиллагчдынхаа цалин хөлсийг бууруулнаас 2.7 хувь нь бүх ажиллагчдын, 1.1 хувь нь зарим ажиллагчдынхаа цалин хөлсийг бууруулсан байна.

*Зураг 2.11 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн ААНБ*




Ажиллагчдын цалин хөлс нэмэгдүүлсэн ААНБ-ын 10.7 хувь нь Засгийн газрын тогтоол, шийдвэрээр ажиллагчдын цалин хөлсийг 14.2 хувиар, 84.7 хувь нь ажил олгогчийн шийдвэрээр 17.6 хувиар, 4.6 хувь нь хамтын гэрээ хэлэлцээрийн үр дүнд 14.6 хувиар нь тус тус нэмсэн байна.

Ажил олгогчийн шийдвэрээр ажиллагчдын цалин хөлсийг нэмсэн шалтгааныг авч үзвэл. хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн, бараа үйлчилгээний үнэ нэмэгдсэн, ажиллагчдын ажлын ачаалал нэмэгдсэн, ажиллагчдын ажлын бүтээмж ур чадварыг үнэлсэн, үйл ажиллагаа нэмэгдсэн, ажиллагчдын өрхийн амьжиргааг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг харгалзан цалин хөлсийг нэмэгдүүлсэн гэсэн байна.

*Зураг 2.12 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн шийдвэр*




ААНБ-ын 53.1 хувь нь бүх ажиллагчдын цалин хөлсийг 16.3 хувиар нэмсэн, харин 46.9 хувь нь зарим буюу тодорхой цөөн тооны ажиллагчдын цалин хөлсийг 14.9 хувиар нэмэгдүүлсэн байна. Бүх ажиллагчдынхаа цалинг нэмсэн байгууллагын 83.3 хувь нь ажил олгогчдын шийдвэрээр цалин хөлсийг 17.8 хувиар нэмэгдүүлсэн бол 6.3 хувь нь хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу 13.8 хувиар ажиллагчдын цалин хөлсийг нэмсэн үр дүн гарсан байна.

*Зураг 2.13 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр*




Цалин хөлс нэмэгдүүлсэн нийт ААНБ-ын 74.7 хувийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, 11.8 хувийг төсөвт байгууллага эзэлж байна. Цалин хөлсөө нэмсэн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 25 хувь нь хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу, 75 хувь нь ажил олгогчдын шийдвэрээр цалин хөлсийг нэмэгдүүлсэн байна. Харин төсөвт байгууллагын 84.4 хувь нь засгийн газрын тогтоол, шийдвэрээр, 14.1 хувь нь ажил олгогчийн шийдвэрээр цалин хөлсийг нэмсэн байна. Хамтын гэрээ хэлэлцээрийн үр дүнд Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, ОНӨҮГ, ТӨҮГ цалин хөлсийг 20 - 25 хувиар нэмэгдүүлсэн боловч ХК болон ХХК-ын хувьд хамгийн бага хувиар нэмэгдүүлсэн нь хамтын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт ХК болон ХХК-уудад сул байгаа харуулж байна.

*Зураг 2.14 Цалин хөлсийг нэмэгдүүлсэн шийдвэр ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр*




*Зураг 2.15 Цалинг нэмэгдүүлэхэд тооцсон суурь*




Цалин хөлс нэмэгдүүлэхэд тооцсон суурь үзүүлэлт тус бүрээр авч үзвэл ажил олгогчдын 84.3 хувь нь үндсэн цалингаас 7.9 хувь нь үндсэн цалин нэмэгдлийн нийлбэр дүнгээс, 7.7 хувь нь нийт цалингийн дүнгээс тооцож цалин хөлсийг нэмсэн байна. Бүх ажиллагчдын цалин хөлсийг нэмсэн ААНБ-ын 85.8 хувь нь үндсэн цалингаас тооцсон дүнгээр цалин хөлсийг нэмэгдүүлсэн байна.

*Зураг 2.16 Ажиллагчдын тооны бүлгээр цалин хөлсийг нэмэгдүүлсэн ААНБ /хувь/*




Цалин хөлс нэмэгдүүлсэн ААНБ-ыг ажиллагчдын тооны бүлгээр харвал 150-аас дээш ажиллагчидтай байгууллага нийт ААНБ-ын 67.3 хувийг, 6-19 ажиллагчидтай байгууллага 42.3 хувийг, харин 5-аас доош ажиллагчидтай байгууллагууд 35.6 хувийг, 50-149 ажиллагчидтай байгууллагууд 25.7 хувийг, 20-49 ажиллагчидтай байгууллага 22.5 хувийг бүрдүүлж байгаа нь аж ахуй нэгжүүдэд цаг үеийн байдал, үйл ажиллагааны доголдол нөлөөлсөн байх магадлалтай юм.

# III БҮЛЭГ

## ҮНДСЭН ЦАЛИН



Тайлангийн энэ бүлэгт үндсэн цалингийн дундаж, тооцож буй үзүүлэлт, судалгаанд хамрагдсан ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хариуцлагын болон өмчийн хэлбэр, байршил, ажиллагчдын тооны бүлэг, нас, хүйс, боловсрол, мэргэжлийн үндсэн ангилал, бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчид зэрэг үзүүлэлтээр харьцуулан дүнг харууллаа. Судалгааны үр дүнгээр ажиллагчдын үндсэн цалингийн улсын дундаж 913.1 мянган төгрөг байна. Эрэгтэй ажиллагчдын үндсэн цалин дунджаар 985.5 мянган төгрөг, эмэгтэй ажиллагчдынх 848.3 мянган төгрөг байна. Өөрөөр хэлбэл эрэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дундаж эмэгтэй ажиллагчдынхаас 13.9 хувиар илүү байна.

## 3.1. ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалинг тооцож буй үзүүлэлт

Монгол Улсын хэмжээнд ажил олгогчид ажиллагчдын үндсэн цалинг тооцохдоо ажил үйлчилгээний онцлогоос хамаарч ажиллагчдын ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэрэг, ажлын гүйцэтгэл, ажил үүрэг албан тушаал гэсэн үндсэн үзүүлэлтийг дангаар нь буюу бусад үзүүлэлтүүдийг харгалзан үндсэн цалинг тогтоодог байна. Ажиллагчдын үндсэн цалинг ихэвчлэн ажил үүрэг, албан тушаалын онцлогт суурилсан хэлбэрээр тогтоож, нэмэгдэл, илүү цагийн хөлс, шагнал урамшууллыг олгодог байна.

*Зураг 3.1 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт*




Ажил олгогчдын цалин тооцож буй үзүүлэлт тус бүрээр харьцуулан харвал нийт ААНБ-ын ихэнх нь ажиллагчдын гүйцэтгэж буй ажил үүрэг, албан тушаалын онцлог ажилласан жилд суурилсан үндсэн цалинг олгодог байна.

*Хүснэгт 3.1 Ажиллагчдын үндсэн цалин, үндсэн цалин тооцож буй үзүүлэлтээр*

| Үндсэн цалин тооцож буй үзүүлэлт | Үндсэн цалин | Ажиллагчид | Хувь |
|---|---|---|---|
| Ажилласан жилээр | 772.7 | 7112 | 30.8 |
| Ур чадвар мэргэжлийн зэргээр | 1022.9 | 633 | 2.7 |
| Гүйцэтгэлээр буюу хийснээр | 941.5 | 2258 | 9.8 |
| Ажил албан тушаал | 1004.8 | 9324 | 40.4 |
| Ажилласан жил, Ур чадвар мэргэжлийн зэргээр | 881.5 | 250 | 1.1 |
| Ажилласан жил, Гүйцэтгэлээр буюу хийснээр | 813.5 | 402 | 1.7 |
| Ажилласан жил, Ажил албан тушаал | 920.7 | 375 | 1.6 |
| Ур чадвар мэргэжлийн зэрэг, Гүйцэтгэлээр буюу хийснээр | 1024.4 | 247 | 1.1 |
| Ур чадвар мэргэжлийн зэрэг+Ажил албан тушаал | 884.6 | 352 | 1.5 |
| Гүйцэтгэлээр буюу хийснээр, Ажил албан тушаал | 945.9 | 1417 | 6.1 |
| Ажилласан жил, Ур чадвар мэргэжлийн зэргээр | 740.2 | 112 | 0.5 |
| Ажилласан жил, Ур чадвар мэргэжлийн зэрэг, Албан тушаал | 967.3 | 127 | 0.6 |

| | | | |
|---|---|---|---|
| Ажилласан жил, Гүйцэтгэл буюу хийснээр, Албан тушаал | 1148.7 | 78 | 0.3 |
| Ур чадвар мэргэжлийн зэрэг, Гүйцэтгэл буюу хийснээр, Албан тушаал | 911.3 | 207 | 0.9 |
| Бүх үзүүлэлтээр | 840.8 | 193 | 0.8 |

Ажиллагчдын үндсэн цалинг тооцож буй үндсэн үзүүлэлт тус бүрийг ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр тодруулбал хязгаарлагдмал хариуцлагатай компани ажиллагчдын гүйцэтгэл буюу хийснээр үндсэн цалин тооцож буй үзүүлэлт 83.2 хувийг, төсөвт байгууллагууд ажилласан жилийг харгалзан үндсэн цалинг тооцож байгаа дүнгээр 65.4 хувийг эзэлж байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь ажиллагчдын гүйцэтгэж буй ажил үүрэг, ажлын гүйцэтгэл буюу хийснээр гэсэн 2 үзүүлэлтийг харгалзан үндсэн цалинг тооцож байгаа нь бусад ААНБ-аас өндөр байна.

*Зураг 3.2 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр*




Харин ААНБ-ын өмчийн хэлбэрээр дээрх үзүүлэлтийг тодруулбал Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй хамтарсан өмчийн болон төрийн өмчийн оролцоотой ААНБ-ууд ажиллагчдын үндсэн цалинг гүйцэтгэж буй ажил үүрэг, албан тушаалыг харгалзан тогтоох нь түгээмэл байна. Харин төрийн өмчийн байгууллагууд үндсэн цалинг ажилласан жилээс тооцон тогтоодог нь хэвээр байна.

*Зураг 3.3 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ААНБ-ын өмчийн хэлбэрээр*



Үндсэн цалин тооцож буй үзүүлэлтийг ажиллагчдын насны бүлэгт харьцуулан авч үзвэл залуучууд ажиллагчдын үндсэн цалинг гүйцэтгэж буй ажил үүрэг, албан тушаалыг харгалзан тогтоох нь давамгайлж байсан ч ажиллагчдын насны бүлэг нэмэгдэх тусам ажилласан жилд үндэслэн тооцох нь нэмэгддэг ажээ.

*Зураг 3.4 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ажиллагчдын насны бүлгээр*




Ажиллагчдын насны бүлгээс гадна байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, хэмжээ нь үндсэн цалин тооцох үзүүлэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Тухайлбал, 1-5 ажиллагчидтай ААНБ ажил үүрэг, албан тушаалын онцлог ба гүйцэтгэлээр буюу хийснээр цалин хөлс олгох нь ойролцоо хувьтай байгаа ч ААНБ-ын ажиллагчдын тоон нэмэгдэж тусамгүйцэтгэл буюу хийснээр, ажил үүрэг, албан тушаалын онцлогт үндэслэх байдал буурч, ажилласан жилээр үндсэн цалин тооцох нь нэмэгдсэн байна.

*Зураг 3.5 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлт ажиллагчдын тооны бүлгээр*




Ажилласан жил, гүйцэтгэлээр буюу хийснээр, ажил үүрэг, албан тушаалын гэсэн гурвалсан үзүүлэлтээр тооцсон ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 25.8 хувиар өндөр, ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэргийн хосолмол үзүүлэлтээр тооцсон үндсэн цалин хамгийн бага буюу 18. 9 хувиар бага байна.

*Зураг 3.6 Цалин хөлсийг тооцож буй үзүүлэлтээр*




## 3.2. Ажиллагчдын үндсэн цалин, ААНБ-ын байршил ажиллагчдын тоо, хүйсээр

Цалин хөлсний бүтцийн судалгаанд хамрагдсан 2474 ААНБ-ын 755 нэгж буюу 30.5 хувь нь орон нутгийн, 1719 нэгж буюу 69.5 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ байсан. Нийт хамрагдсан ААНБ тэдгээрт ажил хөдөлмөр эрхэлж буй 148.999 ажиллагчдын 15.5 хувь буюу 23087 ажиллагчдын мэдээллийг нэгтгэн судалгааны нэгдсэн үр дүнг тооцсон. Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 47.3 хувь нь эрэгтэй, 52.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байлаа.

*Хүснэгт 3.2 Үндсэн цалин ажиллагчдын хүйс, ААНБ-ын байршилаар*

| Байршил, бүс, аймаг, нийслэл | Ажиллагчдын тоо | | | Үндсэн цалин, мян.төг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | |
| | | Эр | Эм | | Эр | Эм |
| Нийт | 23087 | 10912 | 12175 | 913.1 | 985.5 | 848.3 |
| **Баруун бүс** | 1906 | 764 | 1142 | 712.3 | 711.0 | 713.2 |
| Баян-Өлгий | 473 | 171 | 302 | 698.2 | 674.0 | 711.9 |
| Говь-Алтай | 352 | 114 | 238 | 746.6 | 750.0 | 744.9 |
| Завхан | 315 | 112 | 203 | 689.7 | 672.0 | 699.4 |
| Увс | 481 | 212 | 269 | 692.4 | 683.3 | 699.6 |
| Ховд | 285 | 155 | 130 | 752.0 | 788.9 | 708.0 |
| **Хангайн бүс** | 2423 | 954 | 1469 | 725.9 | 741.1 | 716.1 |
| Архангай | 541 | 190 | 351 | 733.9 | 771.3 | 713.6 |
| Баянхонгор | 291 | 93 | 198 | 730.6 | 721.7 | 734.8 |
| Булган | 113 | 50 | 63 | 575.3 | 584.6 | 567.9 |
| Орхон | 615 | 239 | 376 | 808.3 | 869.7 | 769.2 |
| Өвөрхангай | 359 | 150 | 209 | 642.8 | 603.2 | 671.2 |
| Хөвсгөл | 504 | 232 | 272 | 707.1 | 714.4 | 700.9 |
| **Төвийн бүс** | 2524 | 1053 | 1471 | 798.7 | 860.5 | 754.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Говьсүмбэр | 66 | 24 | 42 | 717.3 | 725.8 | 712.5 |
| | Дархан-Уул | 831 | 347 | 484 | 749.9 | 812.4 | 705.1 |
| | Дорноговь | 344 | 139 | 205 | 796.4 | 884.3 | 736.8 |
| | Дундговь | 296 | 83 | 213 | 694.2 | 689.7 | 695.9 |
| | Өмнөговь | 380 | 177 | 203 | 913.7 | 931.3 | 898.4 |
| | Сэлэнгэ | 347 | 158 | 189 | 818.3 | 900.0 | 749.9 |
| | Төв | 260 | 125 | 135 | 903.6 | 956.9 | 854.2 |
| **Зүүн бүс** | | 1265 | 489 | 776 | 779.0 | 852.9 | 732.4 |
| | Дорнод | 576 | 237 | 339 | 807.3 | 915.0 | 731.9 |
| | Сүхбаатар | 349 | 130 | 219 | 797.8 | 873.4 | 752.8 |
| | Хэнтий | 340 | 122 | 218 | 711.8 | 710.1 | 712.7 |
| **Улаанбаатар** | | 14969 | 7652 | 7317 | 999.7 | 1,069.0 | 927.1 |

Ажиллагчдын үндсэн цалинг ААНБ-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа байршил бүсээр харьцуулан авч үзвэл Улаанбаатар хотын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 9.5 хувиар өндөр байна. Бусад аймгийн үндсэн цалин (Өмнөговь аймагт 913.7 мянган төгрөг буюу улсын дундажтай тэнцүү байна) улсын дунджаас доогуур байна. Булган аймгийн хувьд үндсэн цалин улсын дунджаас 37.0 хувиар бага байгаа нь хамгийн бага цалин болж байгаа юм.

*Зураг 3.7 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж бүсээр /мян төг/*




Ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг бүсээр харьцуулан харвал Улаанбаатар хотын ААНБ-уудын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 9.5 хувиар өндөр байхад баруун бүсийн ААНБ 22.0 хувиар, хангайн бүс 20.5 хувиар, зүүн бүс 14.7 хувиар, төвийн бүс 12.5 хувиар тус тус бага байна.

*Зураг 3.8 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж бүс, хүйсээр /мян төг/*




Улаанбаатарын бүсээс бусад бүсэд ажиллагчдын үндсэн цалингийн дундаж улсын дунджаас мөн бага байна.

## 3.3 Ажиллагчдын үндсэн цалин, ажиллагчдын нас, тооны бүлгээр

Ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг насны бүлгээр харьцуулан авч үзвэл ажиллагчдын 16-25 насныхан 5.1 хувиар, 46-аас дээш насныхан 2.3 – 4.3 хувиар тус тус бага харин 26-35 насны ажиллагчдын үндсэн цалин улсын үндсэн цалингийн дунджаас 3.4 хувиар, 36-45 насныхан 1.0 хувиар илүү байна.

*Хүснэгт 3.3 Үндсэн цалин, ажиллагчдын нас, тооны бүлгээр*

| | | Ажиллагчдын тоо | | | Үндсэн цалин, мян.төг | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | |
| | | | Эр | Эм | | Эр | Эм |
| Улсын дундаж | | 23,087 | 10,912 | 12,175 | 913.1 | 985.5 | 848.3 |
| Насны бүлэг | 16-25 | 1746 | 875 | 871 | 866.3 | 911.9 | 820.6 |
| | 26-35 | 7748 | 3947 | 3801 | 944.3 | 1,010.0 | 876.0 |
| | 36-45 | 6997 | 3142 | 3855 | 922.5 | 1,005.1 | 855.2 |
| | 46-55 | 4624 | 1867 | 2757 | 873.6 | 949.5 | 822.2 |
| | 55+ | 1972 | 1081 | 891 | 891.8 | 960.4 | 808.6 |
| Ажиллагчдын тооны бүлэг | 1-5 | 1971 | 998 | 973 | 838.5 | 879.7 | 796.1 |
| | 6-19 | 5055 | 2664 | 2391 | 991.7 | 1,036.0 | 942.3 |
| | 20-49 | 4426 | 2072 | 2354 | 957.1 | 1,053.0 | 872.7 |
| | 50-149 | 6640 | 2878 | 3762 | 839.5 | 897.7 | 795.0 |
| | 150+ | 4995 | 2300 | 2695 | 922.1 | 1,021.7 | 837.0 |

ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр 6 - 49 ба 150-с дээш ажиллагчидтай ААНБ-ын үндсэн цалин улсын дунджаас илүү байна. Хүйсээр дээрх үзүүлэлтийг тодруулбал насны болон тооны бүлгээр эмэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дундаж эрэгтэй ажиллагчдаас 83.6 - 184.7 мянган төгрөгөөр бага байв.

ААНБ-ын үйл ажиллагаа эрхэлж буй байршил бүсээр ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг харьцуулж харвал Улаанбаатараас бусад газарт ажиллагчдын тооны болон ажиллагчдын насны бүлгээр улсын дунджаас бага үндсэн цалинтай байна

*Хүснэгт 3.4 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ажиллагчдын насны болон тооны бүлэг, ААНБ-ын байршил бүсээр*

| | Дундаж | Насны бүлэг | | | | | Ажиллагчдын тооны бүлэг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 16-25 | 26-35 | 36-45 | 46-55 | 55+ | 1-5 | 6-19 | 20-49 | 50-149 | 150+ |
| Улсын дундаж | **913.1** | **866.3** | **944.3** | **922.5** | **873.6** | **891.8** | **838.5** | **991.7** | **957.1** | **839.5** | **922.1** |
| Баруун бүс | 712.3 | 695.3 | 715.9 | 700.7 | 708.1 | 763.0 | 555.1 | 667.1 | 686.6 | 726.3 | 800.0 |
| Хангайн бүс | 725.9 | 672.0 | 738.1 | 730.2 | 708.5 | 739.6 | 640.1 | 728.4 | 749.2 | 736.6 | 708.6 |
| Төвийн бүс | 798.7 | 785.3 | 831.7 | 787.9 | 792.6 | 745.8 | 697.3 | 784.5 | 756.6 | 787.5 | 893.0 |
| Зүүн бүс | 779.0 | 780.4 | 797.2 | 778.7 | 750.6 | 783.5 | 611.2 | 927.1 | 710.0 | 742.9 | 903.1 |
| Улаанбаатар | 999.7 | 906.0 | 1030.2 | 1025.3 | 961.2 | 969.3 | 912.2 | 1057.6 | 1062.6 | 940.7 | 968.9 |

### 3.4. Ажиллагчдын үндсэн цалин, боловсрол, мэргэжлийн үндсэн ангиллаар

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг хүйс, боловсролоор харьцуулбал магистр зэрэгтэй ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 37.4 хувиар ахиу байна. Магистр зэрэгтэй эрэгтэй ажиллагчид 61.5 хувиар илүү цалин авдаг байхад магистр зэрэгтэй эмэгтэй ажиллагчид 22.2 хувиар илүү цалин авч байгаа нь улсын хэмжээнд боловсролын болон хүйсээр үндсэн цалингийн зөрүү байгааг харуулж байна. Дипломын тусгай мэргэжлээс болох түүнээс боловсролтой ажиллагчдын үндсэн цалингийн дундаж улсын дундажаас бага байгааг Зураг 4.8-с дэлгэрүүлэн харж болно. Харин бага боловсролтой эсвэл боловсролгүй эмэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дундаж эрэгтэйчүүдийнхээс  ахиу байдаг байна.

*Зураг 3.9 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж боловсрол, хүйсээр /мян төг/*




Ажиллагчдын боловсрол, ААНБ-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа байршил бүсээр үндсэн цалинг харьцуулбал хангайн болон зүүн бүсийн магистр ба түүнээс дээш боловсролтой, Улаанбаатар хотын бакалавр ба түүнээс дээш боловсролтой ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас өндөр байна.

*Хүснэгт 3.5 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, боловсрол ААНБ-ын байршил бүсээр*

| Боловсрол | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 712.3 | 725.9 | 798.7 | 779.0 | 999.7 |
| Боловсролгүй | 519.9 | 664.0 | 781.4 | 674.5 | 690.8 |
| Бага | 594.7 | 979.8 | 523.6 | 492.0 | 696.3 |
| Суурь | 593.2 | 514.1 | 618.8 | 531.8 | 674.6 |
| Бүрэн дунд | 549.4 | 582.4 | 706.6 | 603.7 | 770.4 |
| ТБМАШ | 616.7 | 598.2 | 773.1 | 848.2 | 893.9 |
| Дипломын тусгай мэргэжлийн | 622.9 | 660.2 | 764.3 | 646.9 | 893.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Дээд /бакалавр/ | 782.9 | 794.3 | 845.3 | 843.3 | 1098.3 |
| Зэрэгтэй дээд / магистр ба дээш/ | 818.9 | 1012.5 | 936.4 | 1046.5 | 1383.1 |

Ажил мэргэжлийн үндсэн ангиллаар харьцуулан авч үзвэл хууль тогтоогч, удирдах албан тушаалын ажилтан, менежерүүд, мэргэжилтнүүдийн үндсэн цалин улсын дунджаас 7.7 - 37.3 хувиар өндөр байна. Харин бусад ажил мэргэжлийн ажиллагчид улсын дунджаас доогуур цалинжиж байгаа ба ХАА, загас, ан агнуурын мэргэжлийн ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 38.2 хувиар бага байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт юм.

*Хүснэгт 3.6 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн үндсэн ангилал, ажиллагчдын хүйсээр /мян төг/*

| Ажил мэргэжлийн ангилал | Ажиллагчдын тоо | Улсын дундаж | Хүйсээр | |
|---|---|---|---|---|
| | | | Эр | Эм |
| **Бүгд** | 23,087 | 913.1 | 985.5 | 848.3 |
| Хууль тогтоогч, удирдах албан тушаалын ажилтан, менежер | 1,053.0 | 1254.0 | 1308.0 | 1205.8 |
| Мэргэжилтэн | 12,858.0 | 983.3 | 1106.9 | 905.1 |
| Инженер, техникийн ажилтан | 1,203.0 | 880.3 | 1044.9 | 737.9 |
| Бичиг хэргийн туслах ажилтан | 370.0 | 880.0 | 1046.2 | 772.9 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 226.0 | 645.5 | 629.8 | 669.3 |
| ХАА, загас, ан агнуурын ажилтан | 33.0 | 564.1 | 636.2 | 528.0 |
| Үйлдвэрийн ба худалдааны ажилтан | 1,367.0 | 847.9 | 904.0 | 692.7 |
| Машин тоног төхөөрөмжийн оператор, угсрагч | 1,232.0 | 851.9 | 849.2 | 873.5 |
| Энгийн ажил мэргэжил | 184.0 | 622.1 | 723.3 | 573.2 |
| Мэргэжилгүй | 4,557.0 | 711.2 | 775.4 | 638.1 |

Хүйсээр харьцуулбал машин тоног төхөөрөмжийн оператор, угсрагч ажил, мэргэжлийн эмэгтэй ажиллагчдын үндсэн цалин эрэгтэй ажиллагчдынхаас 24.3 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өндөр байгаа нь анхаарал татаж байгаа юм. Бусад ажил мэргэжлийн хувьд эрэгтэй ажиллагчдын үндсэн цалин эмэгтэй ажиллагчдаас өндөр байна.

Ажил мэргэжлээрх үндсэн цалингийн дунджийг ажиллагчдын тооны бүлэг, насны бүлгээр харьцуулан харвал 6-аас дээш ажиллагчидтай ААНБ–ын удирдах албан тушаалын ажиллагчид, мэргэжилтэн, 150-аас дээш ажиллагчидтай ААНБ-ын хувьд удирдах албан тушаалын ажиллагчид инженер техникийн ажилтан, машин тоног төхөөрөмжийн оператор, угсрагч нар улсын дунджаас өндөр үндсэн цалин авдаг байна.

Насны бүлгээр бүх насны удирдах албан тушаалын ажиллагчид болон 16-25 насны залуучуудаас бусад мэргэжилтэн нар улсын дунджаас өндөр үндсэн цалин авдаг байна. Удирдах албан тушаалын ажиллагчдын 55-аас дээш насныхан улсын дунджаас 55.3 хувиар өндөр үндсэн цалингаар цалинжиж буй нь хамгийн өндөр цалин авч байгаа үр дүн байлаа.

*Хүснэгт 3.7 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ажил мэргэжлийн ангилал, ажиллагчдын нас, тооны бүлгээр*

| Ажил мэргэжлийн ангилал | Улсын дундаж | Насны бүлэг | | | | | Ажиллагчдын тооны бүлэг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 16-25 | 26-35 | 36-45 | 46-55 | 55+ | 1-5 | 6-19 | 20-49 | 50-149 | 150+ |
| Бүгд | 913.1 | 866.3 | 944.3 | 922.5 | 873.6 | 891.8 | 838.5 | 991.7 | 957.1 | 839.5 | 922.1 |
| Хууль тогтоогч, удирдах албан тушаалын ажилтан, менежер | 1254.0 | 1106.9 | 1190.4 | 1365.8 | 1252.1 | 1418.6 | 864.5 | 1343.4 | 1382.3 | 1123.6 | 1326.1 |
| Мэргэжилтэн | 983.3 | 893.3 | 977.3 | 990.2 | 1000.6 | 1022.1 | 913.9 | 1123.1 | 1035.2 | 900.5 | 956.5 |
| Инженер, техникийн ажилтан | 880.3 | 860.9 | 927.8 | 909.6 | 780.7 | 908.4 | 658.0 | 905.4 | 826.3 | 807.0 | 1044.8 |
| Бичиг хэргийн туслах ажилтан | 880.0 | 875.2 | 918.3 | 892.8 | 786.9 | 966.2 | 853.4 | 868.3 | 1053.8 | 742.4 | 892.8 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 645.5 | 720.4 | 703.7 | 669.0 | 582.8 | 552.8 | 604.0 | 641.0 | 656.8 | 610.5 | 672.6 |
| ХАА, загас, ан агнуурын ажилтан | 564.1 | 936.0 | 460.0 | 567.9 | 454.7 | 1000.0 | 420.0 | 513.6 | 707.4 | 466.7 | 915.4 |
| Үйлдвэрийн ба худалдааны ажилтан | 847.9 | 926.0 | 929.7 | 819.2 | 815.4 | 716.8 | 738.1 | 820.7 | 999.5 | 756.8 | 854.2 |
| Машин тоног төхөөрөмжийн оператор, угсрагч | 851.9 | 859.1 | 895.8 | 878.9 | 799.0 | 739.4 | 690.3 | 791.8 | 869.4 | 753.1 | 1015.0 |
| Энгийн ажил мэргэжил | 622.1 | 721.8 | 685.4 | 614.3 | 605.5 | 532.0 | 526.7 | 744.3 | 606.9 | 603.0 | 633.2 |
| Мэргэжилгүй | 711.2 | 764.8 | 762.5 | 696.1 | 673.6 | 663.7 | 645.4 | 709.6 | 755.5 | 677.9 | 736.5 |

## 3.5. Ажиллагчдын үндсэн цалин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үндсэн цалингийн дунджийг харьцуулан үзвэл уул уурхай, олборлолтын салбарт хамгийн өндөр буюу 537.0 мянган төгрөгөөр, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт 482.6 мянган төгрөгөөр, мэдээлэл холбооны салбар 299.5 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн салбар 217.6 мянган төгрөгөөр, тээвэр ба агуулахын салбар 121.6 мянган төгрөгөөр улсын үндсэн цалингийн дунджаас өндөр байна.

*Зураг 3.10 ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үндсэн цалин /мян төг/*




Дээрх салбаруудаас үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллагчид 245.0, урлаг үзвэрийн, тоглоом наадмын үйл ажиллагааны салбар 189.9, боловсролын салбарын ажиллагчид 166.0, хүний эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын салбар 147.9 мянган төгрөгөөр улсын үндсэн цалингийн дунджаас доогуур байгаа нь анхаарал татаж байгаа юм.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг ажиллагчдын тоотой харьцуулахад уул уурхай болон санхүү даатгалын үйл ажиллагааны салбарын ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн дундаж улсын дунджаас харгалзан 482.6 – 537 мянган төгрөгөөр ахиу байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Тэрэн дундаа санхүү даатгалын үйл ажиллагааны салбарын 20 - 49 ажиллагчидтай ААНБ-ын ажиллагчид хамгийн өндөр үндсэн цалингаар цалинжиж байгаа үр дүн гарсан. Цахилгаан, хий уур, агааржуулалтын салбарын ААНБ-ын ажиллагчдын тооны бүлэг нэмэгдэх бүрд үндсэн цалингийн дундаж тодорхой дүнгээр нэмэгдэж байгаа бол бусад салбарын ажиллагчдын үндсэн цалингийн өөрчлөлт харилцан адилгүй байгаа дүр төрх ажиглагдаж байна.

*Хүснэгт 3.8 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ЭЗҮА-ны салбараар, ажиллагчдын нас, тооны бүлгээр*

| ЭЗҮА-ы салбарын ангилал | Улсын дундаж | Ажиллагчдын тооны бүлэг | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1-5 | 6-19 | 20-49 | 50-149 | 150+ |
| Улсын дундаж | 913.1 | 838.5 | 991.7 | 957.1 | 839.5 | 922.1 |
| ХАА | 825.7 | 672.2 | 699.4 | 983.4 | 769.1 | 1690.7 |
| Уул уурхай | 1450.1 | 869.3 | 1508.4 | 1473.1 | 1393.5 | 1546.2 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 944.3 | 759.6 | 943.8 | 1007.6 | 891.7 | 990.9 |
| Цахилгаан, хий уур, агааржуулалт | 862.5 | 645.6 | 686.9 | 703.2 | 752.0 | 958.8 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх | 773.1 | 529.9 | 625.2 | 700.6 | 795.9 | 801.8 |
| Барилга | 1110.4 | 966.4 | 1074.6 | 1220.3 | 1015.9 | 1433.2 |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 955.2 | 836.9 | 965.2 | 1060.3 | 1059.1 | 923.0 |
| Тээвэр ба агуулах | 1034.7 | 1012.3 | 1034.0 | 900.1 | 1012.7 | 1183.0 |
| Зочид буудал, байр сууц болон нийтийн хоол | 886.3 | 679.6 | 970.5 | 914.9 | 721.3 | 995.7 |
| Мэдээлэл холбоо | 1212.6 | 983.0 | 1475.7 | 0.0 | 661.8 | 1183.2 |
| Санхүүгийн болон даатгал | 1395.7 | 1119.2 | 1390.9 | 1973.5 | 1206.0 | 1481.9 |
| Үл хөдлөх хөрөнгө | 1130.7 | 987.5 | 978.5 | 1277.5 | 1438.6 | 795.0 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техник | 1001.0 | 861.9 | 1283.0 | 1130.9 | 903.1 | 818.2 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх | 950.9 | 821.3 | 914.0 | 926.3 | 1248.1 | 858.7 |
| Боловсрол | 747.1 | 684.9 | 849.0 | 702.6 | 736.0 | 789.6 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж | 765.2 | 761.2 | 823.1 | 748.6 | 748.0 | 754.4 |
| Урлаг, үзвэр , тоглоом наадам | 723.2 | 661.3 | 723.9 | 722.3 | 740.1 | 707.7 |
| Үйлчилгээний бусад | 667.3 | 650.4 | 658.9 | 905.0 | 576.0 | 193.5 |

## 3.6. Ажиллагчдын үндсэн цалин ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр

Ажиллагчдын үндсэн цалинг байгууллагын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр харьцуулан үзвэл ХХК-ны ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 14.6 хувиар өндөр байна. Харин хоршоо, төсөвт байгууллагын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 26.6-20.4 хувиар бага үндсэн цалингаар цалинжиж байна. ААНБ-ын өмчийн хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр 1-19 ажиллагчидтай Монгол Улсын иргэний гадаадын иргэдтэй хамтарсан, төрийн өмчийн хамтарсан 50-149 ажиллагчидтай ААНБ-ын ажиллагчид улсын дунджаас хамгийн өндөр үндсэн цалингаар ажиллаж байна.

*Хүснэгт 3.9 Ажиллагчдын үндсэн цалингийн дундаж, ААНБ-ын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын тооны бүлгээр*

| Байгууллагын хариуцлагын хэлбэр | Үндсэн цалин мян.төг | | | Ажиллагчдын тооны бүлэг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Улсын дундаж | Эр | Эм | 1-5 | 6-19 | 20-49 | 50-149 | 150+ |
| Дундаж | 913.1 | 985.5 | 848.3 | 838.5 | 991.7 | 957.1 | 839.5 | 922.1 |
| ББН | 853.4 | 980.7 | 792.5 | 611.9 | 751.6 | 1,117.2 | 1,431.0 | 29.2 |
| ХХН | 1,019.1 | 1,092.2 | 947.5 | 716.0 | 799.4 | 1,203.6 | | |
| Хоршоо | 670.5 | 632.0 | 701.8 | 755.2 | 659.0 | 307.5 | | |
| ХК | 992.7 | 1,023.9 | 937.8 | 950.4 | 709.0 | 1,207.6 | 890.0 | 1,077.5 |
| ХХК | 1,046.0 | 1,091.0 | 983.7 | 868.0 | 1,047.3 | 1,101.2 | 1,046.6 | 1,141.0 |
| ТӨҮГ | 866.5 | 885.0 | 836.5 | 710.8 | 676.8 | 1,025.0 | 809.6 | 896.8 |
| ОНӨҮГ | 789.7 | 792.7 | 784.7 | 385.5 | 618.9 | 615.8 | 810.9 | 867.9 |
| Төсөвт ААНБ | 727.2 | 717.9 | 730.6 | 672.5 | 766.3 | 689.7 | 727.2 | 746.3 |
| ТББ | 765.3 | 706.6 | 806.4 | 651.7 | 732.5 | 868.8 | 824.5 | 1,142.4 |

## 3.7. Үйлдвэрчний эвлэлтэй болон эвлэлгүй ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалин

Судалгаанд хамрагдсан 2474 ААНБ-ын 18.9 хувь нь үйлдвэрчний эвлэлтэй байсан ба тэдгээр байгууллагын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 11.0 хувиар бага байна. Харин үйлдвэрчний эвлэлгүй ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 5.9 хувиар илүү байгаа юм.

*Зураг 3.11 Үйлдвэрчний эвлэлтэй болон эвлэлгүй ААНБ-ын үндсэн цалин /мян төг/*




## 3.8. Бүрэн бус цагаар ажиллагчдын үндсэн цалин

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 3.2 хувь буюу 749 нь бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлдэг байна. Эдгээрийн 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй байв.

Бүрэн бус цагаар ажиллагчдын үндсэн цалингийн дундаж улсын үндсэн цалингийн дунджаас 180.5 мянган төгрөгөөр бага байна. Харин хүйсийн харьцаагаар эрэгтэй бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчийн үндсэн цалингийн дундаж эмэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дунджаас 4.7 хувиар бага байна.

*Зураг 3.12 Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгч, үндсэн цалин, хүйсээр /мян төг/*



Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчдын үндсэн цалингийн дунджийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодруулбал уул уурхай, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас өндөр, бусад салбарт ажиллаж байгаа бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчид улсын үндсэн цалингийн дунджаас доогуур цалинжиж байна.

*Зураг 3.13 Бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгч, үндсэн цалин, ЭЗҮА-ны салбараар /мян төг/*



# IV БҮЛЭГ

## ХХДХ БОЛОН ТҮҮНЭЭС БАГА ХЭМЖЭЭГЭЭР ЦАЛИНЖИЖ БУЙ АЖИЛЛАГЧИД



Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж буй иргэдийн талаар, байгууллагын хариуцлагын болон өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажиллагчдын нас, хүйс, ажиллагчдын тооны бүлэг зэрэг үзүүлэлтээр харьцуулсан мэдээллийг авч үзэж байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах худалдаа, үйлчилгээний газрын үйлчилгээ, цэвэрлэгээний ажил, ачаа ачих, зөөх, буулгах зэрэг энгийн ажилд ажиллаж буй ажилтанд төлөх нэг цагийн хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээ юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах үе буюу 2021 оны 5-р сарын байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэг цагт 2500 төгрөг буюу сард 420.000 төгрөг байв.

Судалгаанд хамрагдсан нийт ажиллагчдын 31.2 хувь нь үндсэн цалингийн дундаж буюу 913.1 мянган төгрөгөөс дээш үндсэн цалингаар хөдөлмөр эрхэлж байгаа бол 64.3 хувь нь үндсэн цалингийн дунджаас бага ч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш үндсэн цалингаар цалинжиж байгаа үр дүн гарсан. Харин 4.6 хувь буюу 1053 нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 4.7 хувь буюу 1082 ажиллагчид ХХДХ-ээс бага цалинтай байна.

*Хүснэгт 4.1 Ажиллагчдын тоо, үндсэн цалин бүлгээр*

| Цалингийн бүлэг | Ажиллагчид | Хувь | Хүйсээр | |
|---|---|---|---|---|
| | | | Эр | Эм |
| Бүгд | 23087 | 100% | 10912 | 12175 |
| 420.0 хүртэл | 1053 | 4.6% | 575 | 478 |
| 420.0 | 1082 | 4.7% | 608 | 474 |
| 420.1-500.0 | 1536 | 6.7% | 662 | 874 |
| 500.1-600.0 | 2409 | 10.4% | 1,047 | 1362 |
| 600.1-700.0 | 2377 | 10.3% | 1,129 | 1,248 |
| 700.1-800.0 | 4012 | 17.4% | 1,292 | 2,720 |
| 800.1-1000.0 | 4534 | 19.6% | 1,883 | 2,651 |
| 1000.1-1500.0 | 3810 | 16.5% | 2,253 | 1,557 |
| 1500.1 дээш | 2274 | 9.8% | 1,463 | 811 |

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй бол эдгээр ажиллагчдын 94.6 хувь нь байнгын ажлын байранд, 5.4 хувь нь түр ажлын байранд ажиллаж байна.

*Зураг 4.1 ХХДХ түүнээс бага цалин хөлс авсан ажиллагчид, сард ажилласан өдрөөр*




Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалингаар цалинжиж байсан ажиллагчдын сард ажилласан өдөр тус бүрээр авч үзвэл (судалгааны мэдээлэл цуглуулсан 5 дугаар сард ажлын 22 хоног байсан) 20 ба түүнээс доош өдөр ажилласан 23.7 хувь, 21-23 өдөр ажилласан 72.1 хувь, 4.1 хувь нь 24 ба түүнээс олон хоног ажиллажээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалинтай ажиллаж буй ажиллагчдын 14.3 хувь нь ажлын 22 өдөр ажилласан бол 9.6 хувь нь 1-10 өдөр хөдөлмөр эрхэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалинтай ажиллагчдын 88.3 хувийг нөхөрлөл хоршоо төрийн бус байгууллагын ажиллагчид бүрдүүлж байна. ААНБ-ын өмчийн хэлбэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын 77.8 хувь нь Монгол Улсын иргэний өмчийн ААНБ-д ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн, өмчийн оролцоотой байгууллагын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын хувь бага байгаа нь тухайн байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан болон үйл ажиллагаа явуулсан өдөр хангалтгүй байсан зэрэг шалтгаан байлаа.

*Зураг 4.2 ХХДХ түүнээс бага цалин авсан ажиллагчид ААНБ-ын өмчийн хэлбэрээр*




Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа (22.7 хувь), барилга (15.7 хувь), боловсруулах үйлдвэрлэл (12.8 хувь), үйлчилгээний бусад салбарт (9.8 хувь) хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээнээс бага цалинтай ажиллагчдын талаас илүү хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

*Зураг 4.3 ХХДХ түүнээс бага цалин авсан ажиллагчид ЭЗҮА-ны салбараар*




Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалингаар ажиллаж буй ажиллагчдыг насны бүлгээр харьцуулан авч үзвэл 26-35 насныхан өндөр хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлтийг ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл 150 ба түүнээс дээш ажиллагчидтай буюу томоохон ААНБ-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс доогуур үндсэн цалинтай ажиллагчид хамгийн бага хувийг бүрдүүлж байна. Харин 6-19 ажиллагчидтай ААНБ-д 39.7 хувь байна. Үүнийг үзүүлэлт тус бүрээр задлан харвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага үндсэн цалинтай ажиллагчид 46.1 хувь нь, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр үндсэн цалинтай ажиллагчид 33.5 хувь байна.

*Зураг 4.4 ХХДХ түүнээс бага цалин авсан ажиллагчид, насны бүлэг, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр*



# V БҮЛЭГ

## АЖЛЫН ЦАГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Тайлангийн энэхүү бүлэгт судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын ажлын бус цагаар болон амралтын өдрүүдээр ажилласан эсэх, ажилласан тохиолдолд ажил олгогчдоос түүнд тохирсон цалин хөлс олгосон эсэхийг тодрууллаа.

Судалгааны мэдээлэл цуглуулсан 2021 оны 5 сарын байдлаар судалгаанд хамрагдсан 23087 ажиллагчдын 8.6 хувь буюу 1984 нь ажлын бус өдрөөр юм уу илүү цагаар ажиллажээ. Ажиллагчдын ажлын бус өдөр юм уу илүү цагаар ажиллах өмнөх судалгааны мөн дүнгээс буурсан байна.

## 5.1. ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ажиллагчдын илүү цаг болон ажлын бус өдрийн хөдөлмөр эрхлэлт

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 735 буюу 3.2 хувь нь ажлын бус өдрөөр, 1249 буюу 5.2 хувь нь илүү цагаар хөдөлмөр эрхэлсэн байна. Ажлын бус өдөр ажиллаж байсан ажиллагчид тухайн ажлын байранд сард дунджаар 3.4 өдөр, илүү цагаар ажилласан ажиллагчид сард дунджаар 39.3 цаг ажилласан байна.

ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл ажлын бус өдөр ажилласан ажиллагчдын 82 хувь нь, илүү цагаар ажилласан ажиллагчдын 70.5 хувь нь ХХК-д ажиллаж байна. Судалгааны үр дүнгээс харахад ХХК болон төсвийн байгууллагын ажиллагчид амралтын өдрүүдээр болон илүү цагаар хамгийн их ажилладаг байна.

*Зураг 5.1 Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчид ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/*




Ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан ажиллагчдын 47 хувь нь нэмэгдэл хөлс авсан бол 53 хувь нь ажлын хөлс аваагүй байна. Ажлын хөлс аваагүй ажиллагчдыг ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр харьцуулан доорх зурагт харууллаа.

*Зураг 5.2 Ажлын бус өдөр ажилласан ажиллагчид, ажлын хөлс олгоогүй ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/*




## 5.2. ААНБ-ын өмчийн хэлбэрээр ажиллагчдын илүү цаг болон ажлын бус өдрийн хөдөлмөр эрхлэлт

ААНБ-ын өмчийн хэлбэрээр авч үзвэл ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан нийт ажиллагчдын 74.2 хувь нь Монгол Улсын иргэний хувийн, 15.3 хувь нь төрийн өмчийн ААНБ-уудад ажиллаж байна

*Зураг 5.3 Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчдын эзлэх хувь ААНБ-ын өмчийн хэлбэрээр /хувь/*




## 5.3. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ажиллагчдын илүү цаг болон ажлын бус өдрийн хөдөлмөр эрхлэлт

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодруулбал бөөний болон жижиглэн худалдаа 27.3, боловсруулах үйлдвэрлэл 12.4, барилга 18.2, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбар 11.3 хувиар ажлын бус өдөр болон илүү цагаар ажиллагчдаа ажиллуулдаг нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан ч ажлын хөлс аваагүй ажиллагчдыг эдийн засгийн салбараар доорх зурагт харууллаа.

*Зураг 5.4 Илүү цагаар болон ажлын бус өдөр ажилласан ажиллагчдын эзлэх хувь, ажлын хөлс аваагүй ажиллагчид эдийн засгийн үйл ажиллагааны салбараар*




## 5.4. ААНБ -ын үйл ажиллагаанд гарсан цар тахлын нөлөө

2019 онд дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахлын улмаас ААНБ-уудын үйл ажиллагаа ихээхэн доголдсон. Ажил олгогчдын үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн харилцааны зарим асуудлыг шийдэх зорилгоор Монгол Улсын засгийн газраас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Тус судалгааны мэдээлэл цуглуулалт цар тахлын хорио цээр, засгийн газраас авч хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх үетэй давхцсан тул ажил олгогч нарт хэрхэн нөлөөлж байгааг тодруулахыг зорилоо.

*Зураг 5.5 ААНБ-ын дах цар тахлын нөлөө*




Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын үйл ажиллагаанд үзүүлсэн цар тахлын нөлөөг тодруулбал ажил олгогчдын 35.0 хувь үйл ажиллагаагаа түр хугацаагаар хаасан, 32.3 хувь нь үйл ажиллагаагаа бууруулсан гэж хариулсан байна. Бусад 32.8 хувь нь тодорхой өөрчлөлт гараагүй гэж хариулжээ. ААНБ-ын байршлаар харвал баруун бүсийн ажил олгогчдын 42.5 хувь нь үйл ажиллагаагаа түр хаасан 25.3 хувь нь үйл ажиллагаа буурсан гэсэн бол зүүн бүсийн ААНБ-уудын 45.5 хувьд ямар нэгэн өөрчлөлт гараагүй, 29.5 хувьд нь түр хугацаанд үйл ажиллагаагаа хаасан, 21.4 хувьд нь үйл ажиллагаа буурсан гэжээ.

ААНБ-ын хариуцлагын авч үзвэл орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ААНБ-ын 75.9 хувь нь үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй, 3.4 хувь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 13.8 хувь нь үйл ажиллагаа нь буурсан гэж хариулжээ. Төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрын ААНБ-ын 47.5 - 56.8 хувь үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй ажилласан байна. Хариуцлагын хэлбэрийн хувьд бусад ААНБ -ын хувьд гарсан нөлөөг доорх зурагт харуууллаа.

*Зураг 5.6 ААНБ-ын дах цар тахлын нөлөө ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр*




ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл ажиллагчдын тооны бүлэг нэмэгдэх тусам тухайн байгууллагуудад цар тахлын нөлөөлөл бага байсан дүн судалгаагаар гарсан.

*Зураг 5.7 Цар тахлын нөлөө ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр*




Судалгаанд хамрагдсан байгууллагын цар тахлын нөлөөгөөр орлогод гарсан өөрчлөлтийг хөл хорио болон бусад арга хэмжээний өмнөх хэвийн үйл ажиллагааны орлогоор харьцуулж тодруууллаа. Нийт ААНБ-ын 65.3 хувьд нь үйл ажиллагааны орлого ихээхэн буурсан бол 34.7 хувьд орлого буураагүй байна.

Монгол Улсын Засгийн газраас цар тахлын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан улсын хэмжээнд эдийн засгийг дэмжих

чиглэлээр авсан арга хэмжээ зохион байгуулагдсан бөгөөд тухайн арга хэмжээнд судалгаанд хамрагдсан ААНБ хэрхэн хамрагдсан талаар тодруууллаа.

*Зураг 5.8 Эдийн засгийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан ААНБ*




Ажиллагчдын нийгмийн даатгалыг бүрэн тэглэх арга хэмжээнд судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 26.8 хувь нь, Цахилгаан дулаан усан хангамжийн төлбөр тэглэх арга хэмжээнд 26.0 хувь нь, Цалингаас орлогын албан татвар авахгүй чөлөөлөх арга хэмжээнд 25.8 хувь нь, Орлогоос шалтгаалан ААНОАТ авахгүй чөлөөлөх арга хэмжээнд 12.2 хувь нь, зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулах арга хэмжээнд 9.2 хувь нь тус тус хамрагдсан байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 57.1 хувь нь цахилгаан дулаан усан хангамжийн төлбөр тэглэх арга хэмжээнд, Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн 35.3 хувь нь Нийгмийн даатгалыг бүрэн тэглэх арга хэмжээнд хамгийн өндөр хувьтай хамрагдсан бол бусад арга хэмжээний хамрагдалт ойролцоо түвшинд байна.

# VI БҮЛЭГ

## ӨМНӨХ СУДАЛГААТАЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН



Тайлангийн энэ бүлэгт 2019 ба 2021 онд хийгдсэн “Цалин хөлсний бүтцийн судалгаа”-ны ажиллагчдын цалингийн бүтэц, үндсэн болон нийт цалин зэрэг бусад үзүүлэлтээр тооцсон үр дүнг харьцуулан өөрчлөлтийг танилцуулж байна.

Цалин хөлсний бүтцийн 2021 оны судалгааны үр дүнгээр ажиллагчдын нийт цалингийн дундаж 2019 оны дүнгээс 1.9 хувиар нэмэгдсэн, үндсэн цалин 1.5 хувиар буурсан.

Үндсэн болон нийт цалингийн өөрчлөлтийг хүйсээр тодруулбал эрэгтэй ажиллагчдын нийт цалин 0.6 хувь, эмэгтэй ажиллагчдын 4.4 хувиар нэмэгдсэн байна. Үндсэн цалингийн хувьд эрэгтэй ажиллагчдын дундаж үндсэн цалин 1.9 хувиар буурсан, эмэгтэй ажиллагчдын дундаж үндсэн цалин 0.3 хувиар нэмэгдсэн үр дүн гарсан. Цалингийн дунджийн өөрчлөлт нь цаг үеийн байдал эдийн засгийн нөхцлөөс шалтгаалсан гэж дүгнэж байна.

*Зураг 6.1 Нийт болон үндсэн цалингийн дундаж 2019, 2021 оноор*




Судалгааны үр дүнгээс гарсан цалингийн бүтцийг 2019 оны нийт цалингийн бүтэцтэй харьцуулбал 2021 оны нийт цалинд эзлэх үндсэн цалин 84.0 хувь болж 2.8 пунктээр, шагнал урамшуулал 0.9 хувь болж 0.4 пунктээр өмнөх судалгааны дүнгээс буурсан. Харин ажиллагчдын нэмэгдэл 2021 оны дүнгээр 10.0 хувь болж 2.5 пунктээр, нэмэгдэл хөлс 5.2 хувь болж 0.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

*Зураг 6.2 Нийт цалингийн бүтэц 2019, 2021 оноор харьцуулсан*



### 6.1. Ажиллагчдын цалин хөлсний өөрчлөлт ААНБ-ын байршлаар

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж 2019 оны дүнгээр 2017 оныхоос 29.1 хувиар нэмэгдэж байсан бол 2021 онд 2019 оныхоос 1.9 хувиар өссөн үр дүн гарч байна.

Бүсээр харьцуулан авч үзвэл 2021 онд Улаанбаатар хотын ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн дундаж 2019 оны судалгааны дунджаас 2.8 хувиар буурсан. Бусад бүсийн нийт цалингийн дундаж 11.1 - 13.5 хувиар нэмэгджээ.

*Зураг 6.3 Нийт цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, бүсээр*




Үндсэн цалингийн дундаж зүүн бүсэд 16.5 хувиар, баруун бүсэд 13.5 хувиар, төвийн бүсэд 12.4 хувиар, хангайн бүсэд 11.1 хувиар нэмэгдсэн үр дүн гарсан. Харин Улаанбаатар хотын ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн дундаж 2019 оны дүнгээс 6.1 хувиар буурсан байна.

*Зураг 6.4 Үндсэн цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, бүсээр*



## 6.2. Цалин хөлсний өөрчлөлт ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Нийт цалингийн дунджийг 2019 оны судалгааны үр дүнгээр харьцуулан, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үзвэл үйлчилгээний бусад салбарт хамгийн их бууралт (22.4 хувь) ажиглагдсан. Түүнчлэн уул уурхай (14.2 хувь), санхүү даатгал (12.8 хувь), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт (11.3 хувь) нийт цалингийн хэмжээний бууралт өндөр байна. Харин усан хангамж, бохир ус, хог хаягдлын салбарын ажиллагчдын нийт цалин 2019 оны дунджаас 31.3 хувиар нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлт болж байгаа юм.

*Зураг 6.5 Нийт цалингийн өөрчлөлт 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар*




Уул уурхай, санхүүгийн болон даатгалын салбарын ажиллагчдын нийт цалингийн дунджийг бусад салбаруудтай харьцуулахад 2019 оныхоос буурсан хэдий ч 2021 онд хамгийн өндөр хэвээр байна. Харин ХАА-н ба тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын нийт цалин дундаж өөрчлөлт хамгийн багатай байлаа. ХАА-н салбарын ажиллагчдын нийт цалингийн дундаж хамгийн багаар буюу 0.8 хувиар өссөн. Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын ажиллагчдын нийт цалингийн дундаж хамгийн бага буюу 0.8 хувиар буурсан байна.

*Зураг 6.6 Нийт цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар*




Нийт цалингийн бүтцийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулбал санхүү болон даатгалын салбарын ажиллагчдын нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь (12.8 пункт) хамгийн их өссөн ч бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшууллын эзлэх хувь буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 6.1 Нийт цалингийн бүтцийн өөрчлөлт ААНБ-ын ЭЗҮА-ны салбараар /пункт/*

| ЭЗҮА-ы салбар | Үндсэн цалин | Нэмэгдэл | Нэмэгдэл хөлс | Шагнал урамшуулал |
|---|---|---|---|---|
| Хөдөө аж ахуй, загас ан агнуур | 7.7 | 1.4 | -8.5 | -0.7 |
| Уул уурхай | 1.6 | 1.1 | -2.4 | -0.4 |
| Боловсруулах үйлдвэрлэл | -3.4 | 3.2 | -0.2 | 0.4 |
| Цахилгаан, хий уур, агааржуулалт | -5.6 | 5.1 | 0.4 | 0.1 |
| Усан хангамж, хаягдал менежмент болон цэвэрлэх | -10.5 | 9.2 | 2.0 | -0.6 |
| Барилга | -3.4 | 0.7 | 2.6 | 0.0 |
| Бөөний болон жижиглэн худалдаа | -2.7 | 1.5 | 1.7 | -0.5 |
| Тээвэр ба агуулах | 6.1 | -3.6 | -2.1 | -0.3 |
| Зочид буудал, байр сууц болон нийтийн хоол | 1.6 | -1.1 | -0.3 | -0.2 |
| Мэдээлэл холбоо | 1.3 | 0.2 | 2.4 | -3.9 |
| Санхүүгийн болон даатгал | 12.8 | -12.1 | -0.5 | -0.2 |
| Үл хөдлөх хөрөнгө | 4.0 | -3.3 | -1.0 | 0.3 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техник | -4.3 | 2.6 | 1.7 | 0.0 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх | -0.6 | 1.4 | 0.4 | -1.1 |
| Боловсрол | -4.5 | 7.6 | -1.9 | -1.2 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамж | -5.3 | 3.8 | 2.0 | -0.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Урлаг, үзвэр , тоглоом наадам | -6.7 | 5.4 | 1.0 | 0.3 |
| Үйлчилгээний бусад | -3.0 | 2.0 | 1.0 | 0.0 |
| **Улсын дундаж** | -2.9 | 2.5 | 0.7 | -0.4 |

Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын ажиллагчдын нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хэмжээ 10.5 пунктээр буурсан ч нэмэгдэл, нэмэгдэл хөлсийн эзлэх хэмжээ харгалзан 9.2, 2 пунктээр нэмэгдсэн. Нийт цалинд эзлэх нэмэгдлийн хэмжээ өссөн боловсрол, цахилгаан хий уур, агааржуулалт, урлаг, үзвэр, хүний эрүүл мэндийн салбарын нийт цалин өссөн дүн гарсан байна.

Үндсэн цалингийн дундаж 2021 оны дүнгээр нийт цалингийн 84.0 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх судалгааны үр дүнгээс 2.8 пунктээр буурсан үзүүлэлт байсан. Үндсэн цалингийн өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар 2019 оны дүнгээр харьцуулбал санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын ажиллагчдын үндсэн цалингийн эзлэх хувь 2019 оны дүнгээс хамгийн их (12.8 пункт) нэмэгдсэн бол усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт хамгийн их (10.5 пункт) буурсан байна.

*Зураг 6.7 Үндсэн цалингийн өөрчлөлт 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар*




2019 оны судалгааны үр дүнгээр үйлчилгээний болон бусад үйл ажиллагааны салбарын ажиллагчдын үндсэн цалингийн дундаж 886.5 мянган төгрөг байсан нь тус судалгааны дүнгээр 667.3 мянган төгрөг, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын үндсэн цалин 1185.0 мянган төгрөг байсан бол 2021 онд 1001.0 мянган төгрөг болж буурчээ.

*Зураг 6.8 Үндсэн цалингийн дундаж 2019, 2021 оноор харьцуулсан, салбараар*




## 6.3. Цалин хөлсний өөрчлөлт ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын цалингийн бүтцийг өмнөх судалгааны үр дүнтэй ААНБ-ын хариуцлагын болон өмчийн хэлбэрээр харьцуулан авч үзлээ.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчдын үндсэн цалингийн эзлэх хувь 10.6 пунктээр, нэмэгдэл хөлс 2.7 пунктээр, шагнал урамшуулал 0.7 пунктээр буурч нэмэгдэл 14.0 пунктээр өссөн бөгөөд нийт цалингийн дундаж 22.7 хувиар нэмэгджээ. Бусад дэлгэрэнгүй үр дүнг зурагт харуулав.

*Зураг 6.9 Нийт цалингийн бүтцийн өөрчлөлт ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр, 2019, 2021 оноор харьцуулсан*



Ажиллагчдын үндсэн цалингийн өөрчлөлтийг ААНБ-ын өмчийн хэлбэрээр тодруулбал төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн нийт цалинд эзлэх хувь хамгийн их буюу 14.0 - 16.5 пунктээр буурсан ч бусад үзүүлэлт нэмэгдсэн байна. Үндсэн цалингийн эзлэх хувь орон нутгийн өмчийн, хувь иргэний өмчийн ААНБ-ын ажиллагчдын үндсэн цалингийн хувь нэмэгдсэн бусад өмчийн байгууллагуудад буурсан үр дүн гарсан.

*Зураг 6.10 Үндсэн цалингийн өөрчлөлт ААНБ-ын өмчийн хэлбэрээр*




Ажиллагчдын цалингийн бүтцийн өөрчлөлтийг байгууллагын өмчийн хэлбэрээр 2019 оны судалгааны үр дүнтэй харьцууллаа. Орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагын ажиллагчдын нийт цалинд эзлэх үндсэн цалин 2019 оны судалгааны дүнгээр 85.0 хувь байсан бол тус судалгаагаар 68.5 хувь болж 16.5, нэмэгдэл хөлс 0.5, шагнал урамшуулал 0.3 пунктээр буурсан ч өмнөх судалгааны дүнгээр нэмэгдэл 10.3 хувийг бүрдүүлж байсан бол энэ удаагийн судалгаагаар 27.6 хувь болж 17.3 пунктээр нэмэгдсэн. Төрийн өмчийн байгууллагад дээрх үзүүлэлт үндсэн цалингийн хувь 3.6 пунктээр, шагнал урамшууллын хувь 0.6 пунктээр хасагдаж бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс өссөн үр дүн гарсан.

*Зураг 6.11 Цалингийн бүтцийн өөрчлөлт ААНБ-ын өмчийн хэлбэрээр*




## 6.4. Цалин хөлсний өөрчлөлт ажиллагчдын ажил мэргэжлийн үндсэн ангиллаар

Ажил мэргэжлийн үндсэн ангиллаар ажиллагчдын нийт болон үндсэн цалингийн дунджийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцууллаа. 2019 оны судалгааны дүнгээр хууль тогтоогч, удирдах албан тушаалын ажиллагчид хамгийн өндөр нийт болон үндсэн цалингаар цалинжиж байсан бол 2021 оны судалгааны дүнгээр бага зэрэг буурсан ч бусад ажил мэргэжлийн ажиллагчдын цалингийн дунджаас өндөр хэвээр байна. ХАА, загас, ан агнуурын үндсэн мэргэжлийн ажиллагчдын цалингийн хэмжээ бага зэрэг өссөн ч хамгийн бага дундаж цалингаар ажиллаж байгаа нь мөн хэвээр байна.

*Зураг 6.12 Нийт болон үндсэн цалингийн дундаж ажил мэргэжлийн үндсэн ангилалаар*




Ажиллагчдын ажил мэргэжлийн үндсэн ангиллаар нийт цалингийн бүтцийг өмнөх судалгааны үр дүнгээр харьцуулсан дүнгээр бичиг хэргийн туслах ажиллагчид, ХАА, загас, ан агнуурын үндсэн мэргэжлийн ажиллагчдын нийт

цалинд эзлэх үндсэн цалингийн хэмжээ 0.3 - 0.6 пунктээр нэмэгдэж бусад ажил мэргэжлийн ажиллагчдын үндсэн цалингийн нийт цалинд эзлэх хувь 0.1 - 5.1 пунктээр буурсан байна.

ХАА, загас, ан агнуурын мэргэжлийн ажиллагчдын нэмэгдэл, бичиг хэргийн туслах ажиллагчдын нэмэгдэл хөлсний үндсэн цалинд эзлэх хувь өмнөх оны судалгааны үр дүнгээс 1 пунктээр буурч бусад ажил мэргэжлийн ажиллагчдын үндсэн цалингийн нийт цалинд эзлэх нэмэгдэл, нэмэгдэл хөлс өссөн байна.

*Зураг 6.13 Цалингийн бүтцийн өөрчлөлт ажил мэргэжлийн үндсэн ангилалаар*




Судалгааны үр дүнгээр цалингийн бүтцийн дийлэнх хувийг бүрдүүлэгч үндсэн цалингийн өөрчлөлт бичиг хэргийн туслах ажиллагчид болон ХАА, загас, ан агнуурын үндсэн мэргэжлийн ажиллагчдын хувьд нэмэгдэж бусад ажил мэргэжлийн ажиллагчдын үндсэн цалин буурсан үзүүлэлтийг графикаар доор харууллаа.

*Зураг 6.14 Үндсэн цалингийн өөрчлөлт ажил мэргэжлийн үндсэн ангилалаар*



## 6.5. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс доогуур цалинжиж буй ажиллагчид

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2019 оны судалгааны мэдээлэл цуглуулах, үр дүн тооцох үед сард 320.000 төгрөг байсан бол 2021 онд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны шинэчлэн тогтоосон дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420.000 төгрөг байсан.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын мэдээллийг өмнөх судалгааны үр дүнгээр харьцуулж үзье. Судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын тоо өмнөх судалгааны үр дүнгээс 3.2 пунктээр өссөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын эзлэх хувь өөрчлөлт ороогүй байна.

*Хүснэгт 6.2 ХХДХ ба түүнээс доогуур цалинжиж байгаа ажиллагчид*

| Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 320,000 | Ажиллагчид | | | |
|---|---|---|---|---|
| | Тоо | | Эзлэх хувь | |
| | 2019 он | 2021 он | 2019 он | 2021 он |
| ХХДХ-ээс бага | 536 | 1053 | 1.4 | 4.6 |
| ХХДХ-ээр | 1844 | 1082 | 4.7 | 4.7 |

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын өөрчлөлтийг ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр харвал хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллага дахь ХХДХ, түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын тоо буурсан бусад өмчийн хэлбэрийн байгууллагуудын хувьд өссөн байна..

*Зураг 6.15 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ба түүнээс бага үндсэн цалингаар ажиллаж буй ажиллагчдын хувь харьцуулсан дүнгээр*




ААНБ-ын өмчийн хэлбэрээр харьцуулбал, төрийн өмчийн хамтарсан оролцоотой ААНБ-д ХХДХ, түүнээс бага үндсэн цалинтай ажиллагчдын хувь 36.6 пунктээр өссөн байна.

*Зураг 6.16 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын эзлэх хувь ААНБ-ын өмчийн хэлбэрээр*




Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харьцуулан үзвэл бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллагчдын эзлэх хувь өмнөх оны судалгааны үр дүнгээс 5.9 пунктээр, боловсруулах үйлдвэрлэл 2.9 пунктээр, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн салбарт 2.6, үйлчилгээний бусад салбарт 1.9 пункт, хүний эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын салбар, цахилгаан хий агааржуулалтын салбарт 0.9 хүртэлх пунктээр нэмэгдсэн. Бусад салбаруудад ХХДХ-ээс доогуур үндсэн цалин авсан ажиллагчдын тоо буурсан эерэг үр дүн гарсан. Үүнээс зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны салбарт хамгийн их бууралт ажиглагдсан.

*Зураг 6.17 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллагчдын эзлэх хувь ЭЗҮС*



# VII БҮЛЭГ

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗАРДАЛ ТООЦСОН ҮР ДҮН



ААНБ тэдгээрийн үйл ажиллагаа эрхлэх, бараа бүтээгдэхүүний боловсруулах үйл явцад ажил олгогчоос гарч буй хөдөлмөр эрхлэлтийн нийт зардал нь:

- Цалин хөлсний зардал
- Ажиллагчдад биет болон бүтээгдэхүүн хэлбэрээр олгосон нөхөн олговрын зардал
- Ажиллагчдын нийгмийн хамгааллын зардал
- Ажиллагчдын сургалтын зардал

Хөдөлмөрийн бусад зардал гэсэн үндсэн бүлгүүдэд хуваагддаг.

Тайлангийн энэ бүлэгт судалгаанд хамрагдсан ажил олгогчдын үйл ажиллагаа хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гарсан зардлын бүтцийг байршил, байгууллагын хариуцлагын болон өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбар зэрэг тодорхой үзүүлэлтээр харьцуулан авч үзлээ.

## 7.1. ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц.

*Зураг 7.1 Нийт хөдөлмөр эрхлэлтийн зардал*




Тухайн ажил олгогчид ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, ажил үйлчилгээтэй холбоотой гарч буй нийт зардлыг хөдөлмөр эрхлэлтийн зардалд тооцдог. Судалгаанд хамрагдсан ААНБ ажил олгогчдын хөдөлмөр эрхлэлтийн зардлын 80.1 хувийг ажиллагчдын цалин хөлсний, 12.5 хувийг нийгмийн хамгааллын 2.5 хувийг нөхөн олговрын, 0.6 хувийг сургалтын, 4.3 хувийг хөдөлмөрийн бусад зардал эзэлж байна.

Ажил олгогчоос ажиллагчидтай хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний дагуу 2 талын тохиролцоогоор тухайн ажил үүргийг гүйцэтгэсэн хөдөлмөрийн хөлсөнд мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр гарсан зардлыг цалин хөлсний зардалд тооцно.

*Зураг 7.2 Цалин хөлсний зардал*




Цалин хөлсний нийт зардал нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, ажиллаагүй цагийн болон ажиллагчдад олгосон бусад олговроос бүрдэнэ. Цалин хөлсний зардлын 77.1 хувийг үндсэн цалин, 0.6 хувийг нэмэгдэл, 9.8 хувийг нэмэгдэл хөлс, 8.8 хувийг шагнал урамшуулал, 3.4 хувийг ажиллаагүй цагийн олговор, 0.2 хувийг ажил гүйцэтгэхтэй холбоотой олговрын зардал бүрдүүлж байна.

Нөхөн олговрын зардал нь ажиллагчдын ажил үүргээ гүйцэтгэх явцад ажил олгогчоос биет болон бүтээгдэхүүн үйлчилгээ хэлбэрээр олгож буй хоол, унаа, тээврийн хөлсний хөнгөлөлт, түлш шатахуун, ажиллагчдад олгосон түлээ нүүрсний үнэ болон хөнгөлөлтийн зардлаас бүрдэнэ.

*Зураг 7.3 Нөхөн олговрын зардал*




Ажиллагчдад биет болон бүтээгдэхүүн хэлбэрээр олгосон нийт нөхөн олговрын зардлын 63.9 хувийг хоолны, 12.3 хувийг унааны, 14.1 хувийг ажиллагчдын тээврийн түлш шатахууны, 7.1 хувийг түлээ нүүрсний, 2.6 хувийг бусад зардал эзэлж байна.

Нийгмийн хамгааллын зардал нь ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ хэлэлцээр, ААНБ-ын дотоод журамд тусгагдсан тусламж, дэмжлэг болон бусад нэмэлт даатгалд хамрагдахтай холбоотой ажил олгогчоос зарцуулсан зардлаас бүрдэнэ.

Ажил олгогчоос ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн зардал нь нийт нийгмийн хамгааллын зардлын 94.3 эзэлж байна. Бусад нийгмийн хамгааллын зардлын бүрэлдэхүүнд орж буй үзүүлэлтээр эзлэх хувийг доорх зурагт харууллаа.

*Зураг 7.4 Нийгмийн хамгааллын зардал*




ААНБ эрхэлж буй ажил үйлчилгээний хүрээнд үйл ажиллагаагаа сайжруулах, өргөжүүлэх болон шинэ дэвшилтэт технологи ашиглах зорилгоор шинэ ажилтан дадлагажуулах, мэргэжил олгох, давтан сургах, ажиллагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах зэрэг бусад шаардлагын хүрээнд ажил олгогчоос гарсан зардлыг сургалтын зардалд хамруулна.

*Зураг 7.5 Сургалтын зардал*




Ажиллагчдыг давтан сургах тухайн ажил мэргэжилд мэргэшүүлэх зардалд нийт сургалтын зардлын 49.5 хувийг, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд 39.5 хувийг, шинэ ажиллагчдыг дадлагажуулахад 2.0 хувийг, ажиллагчдын сургалт түүнтэй холбоотой бусад зардалд 9.0 хувийг зарцуулдаг байна.

Ажил олгогчдоос зарцуулж буй хөдөлмөрийн бусад зардал үйл ажиллагаа эрхэлж байгаа эзэмшлийн болон түрээсийн байр, тоног төхөөрөмжийн урсгал засвар, техникийн үйлчилгээний зардал, ажиллагчдын амралт чөлөөт цагийн үйл ажиллагаатай холбоотой гарсан зардал, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хангамжийн зардал, ажиллагчдын ажлын тусгай хувцас,

хамгаалах хэрэгсэл худалдан авах, цэвэрлэх, ариутгах зардал, гадаадын иргэн ажиллуулсны ажлын байрны төлбөр хураамж зэрэг зардлаас бүрдэнэ.

*Зураг 7.6 Хөдөлмөр эрхлэлтын бусад зардал*




ААНБ-ын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн бусад зардлын 76.9 хувийг ажлын байрны урсгал зардал, түрээсийн байрны төлбөр, техник тоног төхөөрөмжийн урсгал засвар, техникийн үйлчилгээний зардал, 19.0 хувийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардал, байгаль орчны менежментийн зардал, ажиллагчдын ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл худалдан авах, цэвэрлэх, ариутгах зардал, 2.3 хувийг ажиллагчдын соёл амралт чөлөөт цаг зэрэг бусад үйл ажиллагаатай холбоотой зардал, 1.8 хувийг аж ахуйн нэгж нь гадаадын иргэн, ажиллах хүч ажиллуулсны төлбөр хураамжийн зардал бүрдүүлдэг байна.

### 7.2. ААНБ-ын байршил аймаг бүсээр хөдөлмөр эрхлэлтийн зардал

Ажил олгогчдын үйл ажиллагаа эрхлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гарсан зардлын үндсэн бүлгээр ААНБ-ын байршил аймаг, бүсээр харьцуулан авч үзлээ.

Улсын хэмжээнд цалин хөлсний зардал нийт хөдөлмөр эрхлэлтийн зардлын 80.0 хувийг бүрдүүлж байгаа бол баруун бүсэд нийт хөдөлмөр эрхлэлтийн зардлын 86.3 хувийг бүрдүүлж байгаа нь хамгийн өндөр хувь байлаа. Бусад зардлын хувьд төвийн бүсэд нөхөн олговрын зардал 3.0 хувь буюу нийт дунджаас 0.6 пунктээр, Улаанбаатарт нийгмийн хамгааллын зардал 12.5 хувь буюу 0.4 пунктээр, сургалтын зардал 0.6 хувь буюу 0.1 пунктээр, хангайн бүсэд хөдөлмөрийн бусад зардал 4.5 хувь буюу 5.1 пунктээр тус тус нийт хөдөлмөр эрхлэлтийн дунджаас өндөр байна.

Бүсээр харьцуулсан дүнгээр баруун бүсийн хувьд цалингийн зардал өндөр байгаа ч бусад хөдөлмөр эрхлэлтийн зардал хамгийн бага хувийг бүрдүүлж байгаа үр дүн гарсан байна.

*Хүснэгт 7.1 Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц аймаг бүсээр /хувь/*

| Байршил аймаг бүс | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дундаж** | **80.1** | **2.5** | **12.5** | **0.6** | **4.3** |
| **Баруун бүс** | **86.3** | **1.5** | **9.2** | **0.2** | **2.8** |
| Баян-Өлгий | 86.2 | 2.9 | 10.5 | 0.1 | 0.4 |
| Говь-Алтай | 86.8 | 0.8 | 7.5 | 0.1 | 4.8 |
| Завхан | 84.8 | 1.1 | 10.8 | 0.2 | 3.1 |
| Увс | 87.7 | 0.7 | 8.7 | 0.2 | 2.7 |
| Ховд | 85.0 | 2.7 | 9.4 | 0.3 | 2.6 |
| **Хангайн бүс** | **79.7** | **2.2** | **10.8** | **0.7** | **6.6** |
| Архангай | 77.1 | 1.5 | 9.7 | 0.0 | 11.7 |
| Баянхонгор | 81.1 | 1.0 | 9.2 | 0.5 | 8.2 |
| Булган | 75.3 | 1.4 | 10.4 | 0.5 | 12.4 |
| Орхон | 79.7 | 3.0 | 11.2 | 1.4 | 4.7 |
| Өвөрхангай | 80.7 | 1.7 | 10.8 | 0.2 | 6.6 |
| Хөвсгөл | 81.1 | 2.7 | 12.3 | 0.1 | 3.9 |
| **Төвийн бүс** | **79.7** | **3.0** | **12.8** | **0.4** | **4.1** |
| Говь-сүмбэр | 81.0 | 0.8 | 9.3 | 0.0 | 8.9 |
| Дархан-Уул | 80.3 | 2.7 | 13.7 | 0.9 | 2.4 |
| Дорноговь | 74.4 | 2.0 | 11.0 | 0.1 | 12.5 |
| Дундговь | 83.8 | 3.1 | 12.2 | 0.1 | 0.9 |
| Өмнөговь | 84.2 | 3.3 | 11.0 | 0.2 | 1.3 |
| Сэлэнгэ | 77.2 | 4.2 | 12.9 | 0.0 | 5.7 |
| Төв | 77.1 | 4.4 | 15.5 | 0.4 | 2.6 |
| **Зүүн бүс** | **81.3** | **2.0** | **11.1** | **0.2** | **5.4** |
| Дорнод | 84.3 | 2.3 | 11.7 | 0.2 | 1.4 |
| Сүхбаатар | 79.0 | 1.4 | 9.3 | 0.1 | 10.3 |
| Хэнтий | 78.5 | 2.0 | 11.9 | 0.2 | 7.3 |
| **Улаанбаатар** | **79.8** | **2.5** | **12.9** | **0.7** | **4.1** |
| Улаанбаатар | 79.8 | 2.5 | 12.9 | 0.7 | 4.1 |

Хөдөлмөр эрхлэлтийн нийт зардлын бүтцийг аймаг, нийслэлээр харьцуулбал Булган аймгийн цалин хөлсний зардал нийт дунджаас 4.8 пунктээр бага, харин хөдөлмөрийн бусад зардал нийт дунджаас 8.2 пунктээр хамгийн өндөр байгаа нь анхаарал татах үр дүн байлаа. Нийт хөдөлмөр эрхлэлтийн зардлын харьцуулсан дүнгээр Төв аймагт нөхөн олговрын зардал нийт дунджаас 2.0 пунктээр, нийгмийн хамгааллын зардал 3.0 пунктээр, Орхон аймагт сургалтын зардал 0.8 пунктээр нийт дунджаас хамгийн өндөр байгаа үр дүнтэй байна. Харин Баян-Өлгий аймагт хөдөлмөр эрхлэлтийн зардалд хөдөлмөрийн бусад зардал хамгийн бага хувийг бүрдүүлдэг байна.

## 7.3. ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хөдөлмөр эрхлэлтийн зардал

Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтцийг ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар  харьцуулан авч үзлээ.

*Хүснэгт 7.2 Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/*

| Эдийн засгийн үйл ажиллагааны салбар | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 80.1 | 2.5 | 12.5 | 0.6 | 4.3 |
| Зочид буудал, байр сууц болон нийтийн хоол | 84.3 | 3.1 | 9.5 | 0.2 | 2.9 |
| Барилга | 85.4 | 3.0 | 8.6 | 0.4 | 2.6 |
| Боловсрол | 82.5 | 0.9 | 10.4 | 0.2 | 6.0 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 77.9 | 4.5 | 12.2 | 0.7 | 4.7 |
| Бөөний болон жижиглэн худалдаа засвар | 81.3 | 3.8 | 10.1 | 0.5 | 4.3 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх | 78.5 | 2.9 | 9.8 | 1.0 | 7.7 |
| Мэдээлэл холбоо | 79.7 | 3.8 | 14.6 | 0.7 | 1.2 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн | 81.3 | 3.9 | 10.3 | 0.4 | 4.1 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 86.4 | 3.7 | 6.6 | 0.5 | 2.9 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 82.2 | 2.6 | 11.6 | 0.8 | 2.8 |
| Урлаг, үзвэр , тоглоом наадам | 80.4 | 2.8 | 12.2 | 0.1 | 4.6 |
| Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 78.6 | 5.0 | 11.9 | 0.1 | 4.3 |
| Уул уурхай | 74.7 | 1.6 | 18.3 | 1.2 | 4.2 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн | 83.3 | 2.4 | 10.7 | 0.1 | 3.5 |
| Хөдөө аж ахуй, загас ан, агнуур | 81.4 | 4.5 | 9.1 | 0.2 | 3.9 |
| Цахилгаан, хий уур, агааржуулалт | 80.3 | 3.2 | 11.6 | 0.6 | 4.3 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 82.9 | 2.1 | 9.3 | 0.6 | 5.1 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 78.6 | 3.3 | 15.1 | 0.7 | 2.4 |

Судалгааны үр дүнгээр боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн салбарын ААНБ-ын цалин хөлсний зардал нь нийт хөдөлмөр эрхлэлтийн зардлын

хамгийн бага хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтцээр нөхөн олговрын зардал нь хамгийн бага салбар боловсрол, уул уурхай бол хамгийн их нөхөн олговрын зардалтай салбар нь усан хангамж, бохир ус хог хаягдлын үйл ажиллагааны салбар байна.

Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын нийт хөдөлмөр эрхлэлтийн зардлын 6.6 хувийг нийгмийн хамгааллын зардал бүрдүүлж байгаа нь нийт дунджаас 5.9 пунктээр бага харин уул уурхайн салбарын нийгмийн хамгааллын зардал нийт дунджаас 5.8 пунктээр өндөр байна.

*Зураг 7.7 Цалин хөлсний зардал эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хувь/*




Нийт хөдөлмөр эрхлэлтийн зардалд цалин хөлсний зардал ихээхэн хувийг эзэлж байгаа тул ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагаа, салбарын цалин хөлсний зардлын дүнг нийт дундажтай харьцуулан авч үзлээ. Уул уурхайн салбар болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамгийн бага буюу нийт дунджаас 5.2 хүртэлх пунктээр доогуур байна. Магадгүй эдгээр салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ууд хөдөлмөр эрхлэлтийн бусад зардал болох нөхөн олговор, нийгмийн хамгаалал, сургалт, нөхөн олговорт ихээхэн анхаарал хандуулдаг гэж дүгнэж болох юм.

### 7.4. Хөдөлмөр эрхлэлтийн зардал ААНБ-ын хариуцлага, өмчийн хэлбэрээр /хувь/.

Хөдөлмөр эрхлэлтийн зардлыг ААНБ-ын хариуцлагын болон өмчийн хэлбэрээр харьцуулбал бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн цалингийн зардал нийт дунджаас 11.9 пунктээр бага байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байсан бол төрийн бус байгууллагуудад цалингийн зардал 4.2 пунктээр их буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлдэг байна.

*Хүснэгт 7.3 Хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтэц ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/*

| ААНБ-ын хариуцлагын хэлбэр | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 80.1 | 2.5 | 12.5 | 0.6 | 4.3 |
| Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл | 68.0 | 5.1 | 7.6 | 0.5 | 18.9 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл | 73.8 | 12.1 | 8.0 | 0.1 | 6.0 |
| Хоршоо | 82.0 | 5.1 | 9.9 | 0.2 | 2.8 |
| Хувьцаат компани | 79.0 | 1.7 | 17.2 | 1.5 | 0.7 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай компани | 81.9 | 3.4 | 10.3 | 0.4 | 4.0 |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 71.5 | 3.4 | 13.5 | 0.5 | 11.0 |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | 77.3 | 3.8 | 12.5 | 0.1 | 6.4 |
| Төсөвт байгууллага | 82.6 | 1.8 | 10.6 | 0.1 | 4.8 |
| Төрийн бус байгууллага | 84.3 | 1.4 | 9.0 | 0.5 | 4.9 |

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын өмчийн хэлбэрээр төрийн, орон нутгийн, хувь иргэний гэсэн үндсэн бүлэгт нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн зардлын бүтцийг харьцуулан авч үзлээ.

Нийт төрийн эзэмшлийн ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийн зардлыг нийт дундажтай харьцуулж харвал цалингийн зардал 1.1 пунктээр, нөхөн олговор нийт дунджаас 0.6 пунктээр бага, нийгмийн хамгаалал, сургалт, хөдөлмөрийн бусад зардал 0.1 - 1.4 пунктээр өндөр байна.

*Зураг 7.8 Хөдөлмөр эрхлэлтийн зардал ААНБ-ын өмчийн хэлбэрээр*




Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой хамтарсан ААНБ-д цалин хөлсний зардал болон нийгмийн хамгаалал сургалтын зардал нь нийт дундаж

зардлаас 0.5 - 6.3 пунктээр бага, харин нөхөн олговор, хөдөлмөрийн бусад зардал нь 1.6 – 1.7 пунктээр өндөр байна.

Хувийн хэвшлийн ААНБ-д цалин хөлсний зардал болон нөхөн олговрын зардал 0.9 - 2.1 пунктээр өндөр, нийгмийн хамгааллын зардал, сургалтын зардал, хөдөлмөр эрхлэлтийн бусад зардал нь нийт дундаж зардлаас 0.2 – 2.5 пунктээр бага байна.

Тухайн үр дүн нь ААНБ-ын өмчийн хэлбэрээс хамааран хөдөлмөр эрхлэлтийн нийт зардал харилцан адилгүй байна. Тэр дундаа орон нутгийн байгууллагууд хамгийн их ялгаатай байгааг дээрх үр дүн харуулж байна.

# ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ



## ДҮГНЭЛТ

Цалин хөлсний бүтцийн судалгаанд нийт 2474 ААНБ, тэдгээрт байгууллагад хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын 15.5 хувь нь буй 23087 ажиллагчид хамрагдсан. Нийт хамрагдсан ААНБ-ын 755 нэгж буюу 30.5 хувь нь орон нутгийн, 1719 нэгж буюу 69.5 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ байсан. Ажиллагчдын 47.3 хувь нь эрэгтэй, 52.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байжээ. Тус судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

### Цалин хөлсний бүтэц

Нийт цалингийн бүтцийг 2019 оны нийт цалингийн бүтэцтэй харьцуулбал 2021 оны үндсэн цалин 2.8 пунктээр, шагнал урамшуулал 0.4 буурсан. Харин нэмэгдэл 2.5 пунктээр, нэмэгдэл хөлс 0.7 пунктээр өссөн дүнтэй байна.

- Нийт цалинд эзлэх нэмэгдэл болон нэмэгдэл хөлс өссөн ч үндсэн цалин, шагнал урамшууллын дүн буурсан нь нийт цалингийн хэмжээний өсөлтийг сааруулсан байна.
- Цалин хөлсний бүтцийг бүсээр харьцуулан авч үзвэл Улаанбаатар хотын ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн 87.6 хувь нь үндсэн цалин, 7.4 хувь нь нэмэгдэл, 4.2 хувь нь нэмэгдэл хөлс, 0.7 хувийг шагнал урамшуулал байгаа нь улсын дундажтай харьцуулахад үндсэн цалин илүү харин нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал бага байна. Орон нутагт эсрэгээр буюу нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь улсын дунджаас бага, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал хувь өндөр байна.
- Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ААНБ-ын ажиллагчдын нийт цалингийн бүтцийг авч үзвэл цахилгаан хий, уур агааржуулалтын хангамжийн салбарт ажиллагчдын үндсэн цалин 61.7 хувь байгаа нь бусад салбартай харьцуулахад хамгийн бага үзүүлэлт болж байна. Харин санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын ажиллагчдын нийт цалингийн бүтцэд эзлэх үндсэн цалин 98.0 хувь буюу хамгийн өндөр байна. Үндсэн цалингийн хэмжээ өндөр учраас нэмэгдлийн хэмжээ бага 2.1 хувьтай байхад цахилгаан хий, уур агааржуулалтын хангамжийн салбарт ажиллагчдын нийт цалингийн бүтцэд эзлэх нэмэгдлийн хувь 23.7 хувь байгаа юм.
- ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр хувьцаат компанийн ажиллагчдын үндсэн цалин нийт цалингийн 73.1 хувийг, харин хоршооны ажиллагчдын үндсэн цалин нийт цалингийн 93 хувийг бүрдүүлж байна.
- ААНБ-ын хариуцлагын хэлбэр, ажиллагчдын хүйсээр цалингийн бүтцийг харьцуулбал, эмэгтэй ажиллагчдын нийт цалинд эзлэх үндсэн цалингийн хувь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар эрэгтэй ажиллагчдынхаас 3.6 - 7.2 пунктээр өндөр байна.

### Цалинг тооцож буй үзүүлэлт

- Ажиллагчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр ажил олгогчдын 21.1 хувь нь ажиллагчдын ажилласан жилээр, 5.3 хувь нь ур чадвар мэргэжлийн зэргээр, 25.5 хувь нь ажлын гүйцэтгэл буюу хийснээр, 48.1 хувь нь ажлын байран дах ажил үүрэг, албан тушаал гэсэн үзүүлэлтээр үндсэн цалин тооцож байна.
- ААНБ-ын ажиллагчдын цалин тооцож буй үндсэн үзүүлэлтээр ангилан, нийт цалингийн хэмжээтэй харьцуулан харвал ур чадвар мэргэжлийн зэрэг, гүйцэтгэлээр буюу хийснээр, ажил үүрэг, албан тушаалаар харгалзан тогтоосон нийт цалин улсын нийт дундаж цалингаас 11.2 хувиар, ур чадвар мэргэжлийн зэрэг, ажил үүрэг албан тушаалаар харгалзан үндэслэн цалингаа тогтоолгосон ажиллагчдын нийт цалин 7.3 хувиар өндөр байна. Харин ажилласан жил, ур чадвар мэргэжлийн зэрэг, гүйцэтгэлд суурилан тогтоосон цалинтай ажиллагчдын дундаж нийт цалин улсын дунджаас 26.2 хувиар бага байна.

### Нийт ба үндсэн цалин

Ажиллагчдын нийт цалингийн дундаж 2019 онд 2017 оныхоос 29.1 хувиар нэмэгдэж байсан бол 2021 онд 2019 оныхоос дөнгөж 1.9 хувиар өссөн байна.

- Цалин хөлсний бүтцийн 2021 оны судалгааны дүнгээр ажиллагчдын нийт цалингийн дундаж 2019 оны дүнгээс 1.9 хувиар нэмэгдсэн, үндсэн цалин 1.5 хувиар буурсан.
- Нийт ба үндсэн цалингийн өөрчлөлтийг хүйсээр тодруулбал эрэгтэй ажиллагчдын нийт цалин 0.6 хувиар, эмэгтэй ажиллагчдын цалин 4.4 хувиар нэмэгдсэн байна. Харин эрэгтэй ажиллагчдын үндсэн цалин 1.9 хувиар буурсан, эмэгтэй ажиллагчдынх 0.3 хувиар нэмэгдсэн.
- ААНБ-ын нийт цалингийн дунджийг байршлаар харьцуулан авч үзвэл Орхон аймаг 6.8 хувиар, Улаанбаатар хотод улсын дунджаас 4.9 хувиар илүү байна. Харин Булган аймаг 39.9 хувиар хамгийн бага, Хэнтий болон Завхан аймагт 20.8 – 20.9 хувиар улсын дунджаас бага байна.
- Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ЭЗҮА-ны салбараар нийт цалингийн дунджийг, судалгааны дундаж нийт цалинтай харьцуулахад уул уурхай, олборлолтын салбар 46.4 хувиар, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбар 31.4 хувиар ахиу байна.
- Үндсэн цалингийн хувьд Улаанбаатар хотын ажиллагчдынх улсын дунджаас 9.5 хувиар өндөр байна. Бусад аймгийн үндсэн цалин (Өмнөговь аймагт 913.7 мянган төгрөг буюу улсын дундажтай тэнцүү) улсын дунджаас доогуур байна. Булган аймгийн хувьд үндсэн цалин улсын дунджаас 37.0 хувиар бага байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.
- Бүсээр харьцуулбал орон нутгийн ажиллагчдын үндсэн цалингийн дундаж улсын дундажаас 12.5 – 22.0 хувиар бага. Баруун бүсэд хамгийн бага буюу улсын дунджаас 22.0 хувиар доогуур байна.

- Үндсэн цалингийн дунджийг харьцуулан үзвэл уул уурхай, олборлолтын салбарт хамгийн өндөр 58.8 хувиар, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт 52.9 хувиар улсын үндсэн цалингийн дунджаас өндөр байна.
- Судалгаанд хамрагдсан магистр зэрэгтэй ба түүнээс дээш боловсролтой ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 37.4 хувиар илүү байгаа боловч эрэгтэй ажиллагчид улсын дунджаас 61.5 хувиар илүү цалин авдаг байхад магистр зэрэгтэй эмэгтэй ажиллагчид 22.2 хувиар л илүү байна. Харин бага боловсролтой эсвэл боловсролгүй эмэгтэй ажиллагчдын үндсэн цалингийн дундаж эрэгтэйчүүдийнхээс ахиу байдаг байна.
- Ажиллагчдын үндсэн цалинг байгууллагын хариуцлагын хэлбэрээр харьцуулбал ХХК-ны ажиллагчдын үндсэн цалин улсын үндсэн цалингийн дунджаас 14.6 хувиар өндөр байна. Харин төсөвт байгууллагын ажиллагчдын үндсэн цалин улсын дунджаас 20.4 хувиар бага байна.

**Цалин хөлс нэмсэн/ буурсан**

- Судалгаанд хамрагдсан нийт 2474 ААНБ-ын 542 буюу 21.3 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд цалин хөлсөө дунджаар 15.6 хувиар нэмэгдүүлсэн байна. Харин ажил олгогчдын шийдвэрээр нийт ААНБ-ын 2.7 хувь нь бүх ажиллагчдын, 1.1 хувь нь зарим ажиллагчдынхаа цалин хөлсийг бууруулсан.
- Ажиллагчдын цалин хөлс нэмэгдүүлсэн ААНБ-ын 10.7 хувь нь Засгийн газрын тогтоол, шийдвэрээр ажиллагчдын цалин хөлсийг 14.2 хувиар, 84.7 хувь нь ажил олгогчийн шийдвэрээр 17.6 хувиар, 4.6 хувь нь хамтын гэрээ хэлэлцээрийн үр дүнд 14.6 хувиар нь нэмсэн байна.
- Ажил олгогчдын дийлэнх нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн, бараа үйлчилгээний үнэ нэмэгдсэн, ажиллагчдын ажлын ачаалал нэмэгдсэн, ажиллагчдын ажлын бүтээмж ур чадварыг үнэлсэн, үйл ажиллагаа нэмэгдсэн, ажиллагчдын өрхийн амьжиргааг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг харгалзан цалин хөлсийг нэмэгдүүлжээ.

**Шагнал урамшуулал**

- Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын 10.1 хувь нь шагнал урамшуулал хүртжээ. Шагнал урамшуулал авсан ажиллагчдын 58.8 хувь нь эмэгтэй, 41.2 хувь нь эрэгтэй ажиллагчид байна. Ажил олгогч шагналыг үндсэн цалингийн 10.2 хувиар тооцож, шагнал урамшуулал олгосон.
- Төсөвт байгууллагын ажиллагчид шагнал урамшуулалд хамрагдах нь их боловч хэмжээ нь улсын дундажтай ойролцоо үндсэн цалингийн 11.1 хувь байна. Харин хувьцаат компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын ажиллагчид үндсэн цалингийн 67.5, 39.4 хувиар тус тус шагнагдсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж буй ажиллагчид**

- Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 4.6 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, 4.7 хувь нь ХХДХ-ээс багаар цалинжиж байна. Ажиллагчдын 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй ажиллагчид. Насны хувьд 26-35 насны ажиллагчид өндөр хувийг эзэлж байна.
- ХХДХ болон түүнээс доогуур үндсэн цалинтай ажиллагчдын 94.6 хувь нь байнгын ажлын байранд, 5.4 хувь нь түр ажлын байранд ажиллаж байна.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур үндсэн цалинтай ажиллаж буй ажиллагчдын 14.3 хувь нь ажлын 22 өдөр ажилласан бол 9.6 хувь нь 1-10 өдөр хөдөлмөр эрхэлсэн байна.
- ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр ХХДХ-ээс бага цалинтай 88.3 хувийг нөхөрлөл хоршоо, төрийн бус байгууллагын ажиллагчид, байгууллагын өмчийн хэлбэрээр 77.8 хувь нь Монгол Улсын иргэний өмчийн ААНБ-д ажиллаж байна. ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл томоохон ААНБ-ууд ажиллагчдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр болон түүнээс доогуур үндсэн цалингаар цалинжуулах нь ховор байдгийг ажиглаж болно.

**Ажлын цагийн үзүүлэлт:**

- Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 8.6 хувь нь бүрэн бус цагаар хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байна.
- Тэдний 3.2 хувь нь ажлын бус өдрөөр, 5.2 хувь нь илүү цагаар хөдөлмөр эрхэлсэн. Ажлын бус өдөр ажиллаж байсан ажиллагчид тухайн ажлын байранд сард дунджаар 3.4 өдөр, илүү цагаар ажилласан ажиллагчид сард дунджаар 39.3 цаг ажилласан байна.
- Ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан ажиллагчдын 47 хувь нь нэмэгдэл хөлс авсан бол 53 хувь нь ажлын хөлс аваагүй гэжээ.
- Ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан нийт ажиллагчдын 74.2 хувь нь Монгол Улсын иргэний хувийн, 15.3 хувь нь төрийн өмчийн ААНБ-уудад ажиллаж буй ажиллагчид байна.

**Цар тахлын нөлөө:**

- Цар тахлын улмаас судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 35.0 хувь нь үйл ажиллагаагаа түр хугацаагаар хаасан, 32.3 хувь нь үйл ажиллагаа буурсан, 32.8 хувьд тодорхой өөрчлөлт гараагүй байна.
- Ажиллагчдын тооноос шалтгаалан цар тахлын нөлөөлөл харилцан адилгүй байсан. Ажиллагчидын тоо нэмэгдэх тусам тухайн ААНБ-уудад цар тахлын нөлөө харьцангуй бага байсан нь ажиглагдлаа. Томоохон байгууллагууд цар тахлын улмаас үйл ажиллагааны хүрээнд хийсэн зохион байгуулалт нь цар тахлын нөлөөг бууруулсан байж болно.

- Монгол Улсын засгийн газраас эдийн засгийг дэмжих чиглэлээр авсан ажиллагчдын нийгмийн даатгалыг бүрэн тэглэх арга хэмжээнд судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 26.8 хувь нь, цалингаас орлогын албан татвар авахгүй чөлөөлөх арга хэмжээнд 25.8 хувь нь, орлогоос шалтгаалан ААНОАТ авахгүй чөлөөлөх арга хэмжээнд 12.2 хувь нь, цахилгаан дулаан усан хангамжийн төлбөр тэглэх арга хэмжээнд 26.0 хувь нь, зээлийн эргэн төлөх хугацааг хойшлуулах арга хэмжээнд 9.2 хувь нь хамрагдсан байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн зардал:**

- Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагаанд гарч буй нийт зардлын 80.1 хувийг нь ажиллагчдын цалин хөлсний зардал, 2.5 хувийг нөхөн олговрын зардал, 12.5 хувийг нийгмийн хамгааллын зардал, 0.6 хувийг сургалтын зардал, 4.3 хувийг хөдөлмөрийн бусад зардалд зарцуулж байна.
- Цалин хөлсний нийт зардалд үндсэн цалин 77.1 хувийг, нэмэгдэл 0.6 хувийг, нэмэгдэл хөлс 9.8 хувийг, шагнал урамшуулал 8.8 хувийг ажиллаагүй цагийн олговор 3.4 хувийг, ажил гүйцэтгэх түүнтэй холбоотой олговрын зардал 0.2 хувийг бүрдүүлж байна.
- Ажиллагчдад биет болон бүтээгдэхүүн хэлбэрээр олгосон нийт нөхөн олговрын зардлын 63.9 хувийг хоолны, 12.3 хувийг унааны, 14.1 ажиллагчдын тээврийн түлш шатахууны, 7.1 хувийг түлээ нүүрсний, 2.6 хувийг бусад зардал эзэлж байна.
- Ажил олгогчоос ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн зардал нь нийт нийгмийн хамгааллын зардлын 94.3 эзэлж байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

* ААНБ-ууд ажиллагчдынхаа цалинг тооцож буй үзүүлэлтийг сонгохдоо үндсэн үзүүлэлтийг цогцоор нь харгалзан үзэх шаардлагатай. Аль болохоор ур чадвар, мэргэжлийн зэрэгт суурилан цалинг тогтоож байх нь ажил олгогчийн хувьд чадварлаг хүний нөөцтэй байх, ажиллагчдад цалингийн хэмжээ нэмэгдэх давуу талыг олгоно.

* Түүнчлэн судалгааны үр дүнгээс нийт цалинд эзлэх нэмэгдэл, шагнал урамшууллыг нэмэгдүүлэх нь чухал гэдэг нь ажиглагдсан. Ингэснээр ажиллагчдын нийт цалингийн хэмжээг нэмэгдүүлэх төдийгүй орон нутагт цалингийн хэмжээ улсын дундажаас доогуур байгааг нөхөх зэрэгт хэрэглэх боломж олдож болно.

* Хүйсээр цалингийн зөрүү байгаад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хот төвлөрсөн газар, боловсролын төвшин өндөр болох тутам эрэгтэй ажиллагчдын цалин өндөр байгаа нь судалгааны дүнгээс харагдсан.

* Судалгааны үр дүнгээс харахад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалин хөлс олгож байгаа ААНБ байсаар байгаад анхаарлаа хандуулах.

* Ажлын бус өдөр болон илүү цагаар ажилласан боловч тохирсон цалин хөлс аваагүй ажиллагчид эдийн засгийн үйл ажиллагаа салбарт ялгаатай байгаа бөгөөд цаашид анхаарах.

* Түүнчлэн ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийн зардалд сургалтын зардал маш бага байгааг анхаарч ажиллагчдын ур чадвар, мэргэжлийн зэргийг дээшлүүлж байх нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэг гэдгийг сурталчилан таниулах хэрэгтэй юм.

# ХАВСРАЛТ

*Хавсралт хүснэгт 1. Нийт цалингийн бүтэц аймаг, бүсээр /мян, төг/*

| Байршил, бүс, аймаг, нийслэл | Нийт цалингийн дундаж | | | Үүнээс: бүтэц, хувиар | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| Улсын дундаж | **1087.7** | **1151.9** | **1030.2** | **913.1** | **985.5** | **848.3** | **108.3** | **95.3** | **119.9** | **56.1** | **60.3** | **52.4** | **10.2** | **10.8** | **9.6** |
| Баруун бүс | **929.4** | **891.6** | **954.7** | **712.3** | **711.0** | **713.2** | **167.0** | **129.2** | **192.3** | **41.3** | **42.1** | **40.8** | **8.8** | **9.4** | **8.4** |
| Баян-Өлгий | 872.9 | 835.0 | 894.4 | 698.2 | 674.0 | 711.9 | 130.2 | 112.6 | 140.2 | 39.4 | 47.1 | 35.1 | 5.1 | 1.3 | 7.3 |
| Говь-Алтай | 1041.5 | 952.3 | 1084.2 | 746.6 | 750.0 | 744.9 | 262.1 | 177.7 | 302.5 | 23.3 | 17.8 | 25.9 | 9.5 | 6.8 | 10.8 |
| Завхан | 861.6 | 804.1 | 893.3 | 689.7 | 672.0 | 699.4 | 140.5 | 111.0 | 156.8 | 15.2 | 8.8 | 18.7 | 16.3 | 12.3 | 18.5 |
| Увс | 946.9 | 901.6 | 982.6 | 692.4 | 683.3 | 699.6 | 191.8 | 161.3 | 215.8 | 52.4 | 37.2 | 64.4 | 10.3 | 19.8 | 2.8 |
| Ховд | 930.1 | 959.2 | 895.5 | 752.0 | 788.9 | 708.0 | 98.0 | 80.9 | 118.4 | 77.0 | 85.3 | 67.0 | 3.1 | 4.0 | 2.1 |
| Хангайн бүс | **985.5** | **1026.4** | **958.9** | **725.9** | **741.1** | **716.1** | **156.7** | **161.4** | **153.7** | **89.0** | **107.0** | **77.3** | **13.8** | **16.9** | **11.8** |
| Архангай | 945.9 | 1003.4 | 914.8 | 733.9 | 771.3 | 713.6 | 106.7 | 107.0 | 106.5 | 89.8 | 112.4 | 77.6 | 15.5 | 12.6 | 17.1 |
| Баянхонгор | 1079.1 | 1002.0 | 1115.4 | 730.6 | 721.7 | 734.8 | 249.6 | 200.1 | 272.8 | 83.3 | 70.1 | 89.5 | 15.6 | 10.0 | 18.2 |
| Булган | 653.3 | 609.3 | 688.3 | 575.3 | 584.6 | 567.9 | 77.6 | 24.4 | 119.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.4 | 0.3 | 0.4 |
| Орхон | 1161.1 | 1347.3 | 1042.8 | 808.3 | 869.7 | 769.2 | 195.3 | 269.2 | 148.4 | 133.3 | 164.1 | 113.7 | 24.2 | 44.3 | 11.5 |
| Өвөрхангай | 893.3 | 844.6 | 928.3 | 642.8 | 603.2 | 671.2 | 131.7 | 82.9 | 166.8 | 118.8 | 158.5 | 90.3 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хөвсгөл | 899.7 | 931.8 | 872.3 | 707.1 | 714.4 | 700.9 | 145.3 | 159.6 | 133.0 | 36.2 | 48.5 | 25.7 | 11.1 | 9.3 | 12.6 |
| Төвийн бүс | **1026.1** | **1087.4** | **982.3** | **798.7** | **860.5** | **754.5** | **123.1** | **108.3** | **133.8** | **85.4** | **94.8** | **78.6** | **18.9** | **23.8** | **15.4** |
| Говьсүмбэр | 975.3 | 982.5 | 971.2 | 717.3 | 725.8 | 712.5 | 71.1 | 65.1 | 74.6 | 163.9 | 172.1 | 159.1 | 23.0 | 19.5 | 25.0 |
| Дархан-Уул | 1028.5 | 1177.7 | 921.5 | 749.9 | 812.4 | 705.1 | 142.9 | 169.6 | 123.8 | 91.5 | 129.9 | 63.9 | 44.2 | 65.7 | 28.7 |
| Дорноговь | 1004.1 | 1047.3 | 974.7 | 796.4 | 884.3 | 736.8 | 116.9 | 68.6 | 149.6 | 89.7 | 93.3 | 87.2 | 1.1 | 1.1 | 1.2 |
| Дундговь | 974.2 | 880.7 | 1010.7 | 694.2 | 689.7 | 695.9 | 190.2 | 120.5 | 217.3 | 73.7 | 61.1 | 78.6 | 16.2 | 9.4 | 18.9 |
| Өмнөговь | 1035.1 | 1068.2 | 1006.3 | 913.7 | 931.3 | 898.4 | 36.2 | 28.9 | 42.6 | 84.5 | 107.9 | 64.1 | 0.7 | 0.1 | 1.2 |
| Сэлэнгэ | 1047.5 | 1057.6 | 1039.1 | 818.3 | 900.0 | 749.9 | 132.8 | 106.7 | 154.6 | 86.7 | 46.8 | 120.1 | 9.8 | 4.0 | 14.5 |
| Төв | 1078.1 | 1103.5 | 1054.7 | 903.6 | 956.9 | 854.2 | 119.3 | 96.7 | 140.3 | 53.1 | 48.5 | 57.3 | 2.1 | 1.4 | 2.9 |
| Зүүн бүс | **1011.5** | **1114.1** | **946.8** | **779.0** | **852.9** | **732.4** | **177.2** | **187.5** | **170.7** | **48.2** | **64.6** | **37.8** | **7.1** | **9.1** | **5.9** |
| Дорнод | 1068.6 | 1219.2 | 963.2 | 807.3 | 915.0 | 731.9 | 214.5 | 263.1 | 180.5 | 38.1 | 35.1 | 40.2 | 8.7 | 6.0 | 10.6 |
| Сүхбаатар | 1064.4 | 1159.8 | 1007.8 | 797.8 | 873.4 | 752.8 | 186.4 | 160.8 | 201.6 | 71.1 | 105.7 | 50.5 | 9.2 | 19.8 | 2.9 |
| Хэнтий | 860.5 | 861.0 | 860.2 | 711.8 | 710.1 | 712.7 | 104.7 | 68.9 | 124.6 | 41.7 | 78.0 | 21.4 | 2.3 | 3.9 | 1.4 |
| Улаанбаатар | **1141.2** | **1204.8** | **1074.8** | **999.7** | **1069.0** | **927.1** | **84.7** | **76.0** | **93.7** | **48.4** | **51.2** | **45.5** | **8.5** | **8.6** | **8.5** |
| Улаанбаатар | 1141.2 | 1204.8 | 1074.8 | 999.7 | 1069.0 | 927.1 | 84.7 | 76.0 | 93.7 | 48.4 | 51.2 | 45.5 | 8.5 | 8.6 | 8.5 |

*Хавсралт хүснэгт 2. Нийт цалингийн бүтэц ААНБ-ын өмчийн хэлбэрээр /мян, төг/*

| Байгууллагын өмчийн хэлбэр | | Нийт цалингийн дундаж | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | |
| | | Нийт | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм |
| Улсын дундаж | | **1087.7** | **1151.9** | **1030.2** | **913.1** | **985.5** | **848.3** | **108.3** | **95.3** | **119.9** | **56.1** | **60.3** | **52.4** | **10.2** | **10.8** | **9.6** |
| Төрийн | Өмчийн | 1043.0 | 1098.2 | 1017.8 | 749.9 | 771.8 | 739.9 | 198.2 | 209.1 | 193.2 | 76.0 | 88.3 | 70.4 | 19.0 | 29.0 | 14.4 |
| | Өмчийн оролцоотой | 1616.6 | 1741.0 | 1423.1 | 1007.8 | 998.3 | 1022.5 | 285.0 | 308.2 | 249.0 | 293.9 | 393.2 | 139.5 | 29.9 | 41.3 | 12.1 |
| | Хамтарсан | 1448.8 | 1553.2 | 1273.0 | 1310.5 | 1414.8 | 1134.8 | 83.5 | 76.9 | 94.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 54.8 | 61.5 | 43.7 |
| ОН-ын | Өмчийн | 876.8 | 890.6 | 862.0 | 700.5 | 704.8 | 695.9 | 120.2 | 120.4 | 120.0 | 53.6 | 63.7 | 42.8 | 2.5 | 1.7 | 3.3 |
| | Өмчийн оролцоотой | 1280.7 | 1367.9 | 1165.1 | 877.3 | 906.4 | 838.7 | 354.0 | 392.9 | 302.6 | 49.3 | 68.7 | 23.7 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | Хамтарсан | 1348.7 | 1391.7 | 1205.3 | 710.8 | 730.5 | 645.0 | 637.9 | 661.2 | 560.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хувийн | МУ-ын иргэн | 1086.4 | 1140.8 | 1014.8 | 999.6 | 1045.2 | 939.7 | 42.0 | 45.1 | 37.9 | 41.0 | 46.6 | 33.5 | 3.8 | 3.9 | 3.7 |
| | Хамтарсан | 1285.5 | 1329.6 | 1223.5 | 1176.2 | 1225.4 | 1106.9 | 54.7 | 49.0 | 62.6 | 41.3 | 43.6 | 38.1 | 13.4 | 11.5 | 15.9 |
| | Гадаадын иргэн | 1455.1 | 1508.9 | 1386.9 | 1342.0 | 1400.9 | 1267.3 | 64.3 | 62.7 | 66.3 | 41.9 | 42.9 | 40.7 | 6.9 | 2.4 | 12.7 |

*Хавсралт хүснэгт 3. Нийт цалингийн бүтэц ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /мян, төг/*

| Байгууллагын өмчийн хэлбэр | Нийт цалингийн дундаж | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | |
| | Нийт | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм |
| Улсын дундаж | **1,087.7** | **1,151.9** | **1,030.2** | **913.1** | **985.5** | **848.3** | **108.3** | **95.3** | **119.9** | **56.1** | **60.3** | **52.4** | **10.2** | **10.8** | **9.6** |
| Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл | 902.4 | 989.8 | 860.6 | 853.4 | 980.7 | 792.5 | 28.9 | 6.7 | 39.5 | 19.1 | 2.3 | 27.1 | 1.0 | - | 1.5 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл | 1,159.4 | 1,239.2 | 1,081.1 | 1,019.1 | 1,092.2 | 947.5 | 49.6 | 26.5 | 72.2 | 90.7 | 120.5 | 61.4 | - | - | - |
| Хоршоо | 721.1 | 662.5 | 768.8 | 670.5 | 632.0 | 701.8 | 36.1 | 28.4 | 42.4 | 14.4 | 2.1 | 24.4 | 0.1 | - | 0.2 |
| Хувьцаат компани | 1358.9 | 1423.3 | 1245.5 | 992.7 | 1023.9 | 937.8 | 166.4 | 168.5 | 162.6 | 132.3 | 158.7 | 86.0 | 67.5 | 72.2 | 59.1 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай компани | 1,130.3 | 1,181.6 | 1,059.1 | 1,046.0 | 1,091.0 | 983.7 | 43.7 | 46.9 | 39.1 | 37.1 | 40.5 | 32.4 | 3.5 | 3.2 | 3.9 |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 1,325.7 | 1,407.1 | 1,192.9 | 866.5 | 885.0 | 836.5 | 302.9 | 333.0 | 253.7 | 116.8 | 146.1 | 69.1 | 39.4 | 43.0 | 33.6 |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | 1,036.4 | 1,058.6 | 999.4 | 789.7 | 792.7 | 784.7 | 224.2 | 239.3 | 199.0 | 21.2 | 25.4 | 14.1 | 1.4 | 1.3 | 1.7 |
| Төсөвт байгууллага | 994.2 | 983.0 | 998.4 | 727.2 | 717.9 | 730.6 | 183.0 | 171.5 | 187.3 | 72.9 | 81.8 | 69.6 | 11.1 | 11.8 | 10.8 |
| Төрийн бус байгууллага | 830.8 | 768.5 | 874.4 | 765.3 | 706.6 | 806.4 | 29.8 | 26.4 | 32.2 | 32.3 | 33.8 | 31.3 | 3.4 | 1.7 | 4.5 |

*Хавсралт хүснэгт 4. Нийт цалингийн бүтэц эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /мян, төг/*

| ЭЗҮА-ын салбарын ангилал | Нийт цалингийн дундаж | | | Үндсэн цалин | | | | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дундаж | Хүйсээр | | Дундаж | | | Дундаж | Хүйсээр | | Дундаж | Хүйсээр | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| **Улсын дундаж** | **913.1** | **985.5** | **848.3** | **108.3** | **95.3** | **119.9** | **56.1** | **60.3** | **52.4** | **10.2** | **10.8** | **9.6** | **913.1** | **985.5** | **848.3** |
| Хөдөө аж ахуй, загас, ан агнуурын | 825.7 | 849.9 | 793.1 | 27.5 | 24.8 | 31.2 | 9.8 | 6.0 | 15.0 | 0.2 | 0.4 | - | 825.7 | 849.9 | 793.1 |
| Уул уурхай | 1,450.1 | 1,476.3 | 1,351.4 | 91.0 | 106.9 | 31.0 | 42.8 | 46.6 | 28.4 | 8.9 | 9.3 | 7.8 | 1,450.1 | 1,476.3 | 1,351.4 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 944.3 | 1,022.2 | 858.9 | 69.3 | 72.4 | 65.9 | 70.2 | 75.6 | 64.3 | 10.8 | 11.2 | 10.4 | 944.3 | 1,022.2 | 858.9 |
| Цахилгаан, хий уур, агааржуулалт | 862.5 | 856.4 | 877.4 | 331.5 | 338.9 | 313.3 | 124.4 | 134.0 | 100.8 | 79.1 | 78.8 | 79.8 | 862.5 | 856.4 | 877.4 |
| Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 773.1 | 793.8 | 747.3 | 176.3 | 193.7 | 154.6 | 60.8 | 66.1 | 54.2 | 1.0 | 0.8 | 1.2 | 773.1 | 793.8 | 747.3 |
| Барилга | 1,110.4 | 1,104.5 | 1,123.5 | 33.8 | 35.6 | 30.1 | 56.6 | 65.0 | 37.8 | 4.6 | 4.5 | 4.8 | 1,110.4 | 1,104.5 | 1,123.5 |
| Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклын засвар үйлчилгээ | 955.2 | 1,009.8 | 889.5 | 51.1 | 49.4 | 53.1 | 49.2 | 52.5 | 45.3 | 2.2 | 1.9 | 2.7 | 955.2 | 1,009.8 | 889.5 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1,034.7 | 1,002.9 | 1,140.2 | 50.6 | 35.5 | 100.6 | 31.9 | 37.5 | 13.3 | 4.1 | 3.7 | 5.3 | 1,034.7 | 1,002.9 | 1,140.2 |
| Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 886.3 | 937.7 | 851.6 | 26.1 | 28.4 | 24.6 | 17.1 | 15.2 | 18.3 | 1.1 | 1.4 | 1.0 | 886.3 | 937.7 | 851.6 |
| Мэдээлэл холбоо | 1,212.6 | 1,347.2 | 1,038.0 | 55.9 | 56.5 | 55.2 | 46.9 | 53.4 | 38.6 | 1.8 | 2.8 | 0.6 | 1,212.6 | 1,347.2 | 1,038.0 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 1,395.7 | 1,532.2 | 1,280.6 | 29.8 | 39.8 | 21.3 | 1.5 | 2.6 | 0.6 | 2.5 | - | 4.6 | 1,395.7 | 1,532.2 | 1,280.6 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 1,130.7 | 1,120.1 | 1,143.5 | 25.9 | 33.8 | 16.4 | 12.9 | 16.8 | 8.0 | 8.4 | 4.9 | 12.6 | 1,130.7 | 1,120.1 | 1,143.5 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 1,001.0 | 1,019.2 | 986.7 | 133.0 | 132.2 | 133.5 | 29.3 | 28.1 | 30.3 | 13.3 | 13.1 | 13.5 | 1,001.0 | 1,019.2 | 986.7 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 950.9 | 931.8 | 986.2 | 68.1 | 63.4 | 76.8 | 32.1 | 41.4 | 14.9 | 1.6 | 0.6 | 3.3 | 950.9 | 931.8 | 986.2 |
| Боловсрол | 747.1 | 726.3 | 754.0 | 166.0 | 151.4 | 170.7 | 48.6 | 53.0 | 47.2 | 9.5 | 10.4 | 9.2 | 747.1 | 726.3 | 754.0 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 765.2 | 783.4 | 759.2 | 158.7 | 159.3 | 158.5 | 129.9 | 165.4 | 118.4 | 10.8 | 10.6 | 10.9 | 765.2 | 783.4 | 759.2 |
| Урлаг, үзвэр , тоглоом наадам | 723.2 | 744.9 | 694.6 | 109.5 | 93.2 | 131.0 | 38.7 | 40.1 | 36.9 | 16.1 | 14.2 | 18.5 | 723.2 | 744.9 | 694.6 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 667.3 | 688.1 | 647.6 | 20.5 | 22.0 | 19.2 | 8.0 | 6.2 | 9.7 | 1.6 | 1.3 | 1.9 | 667.3 | 688.1 | 647.6 |

*Хавсралт хүснэгт 5. Нийт цалингийн бүтэц ажиллагчдын боловсролын түвшингээр /мян, төг/*

| Ажиллагчдын боловсролын түвшин | Нийт цалингийн дундаж | | | Үүнээс: бүтэц | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| **Улсын дундаж** | **1,087.7** | **1,151.9** | **1,030.2** | **913.1** | **985.5** | **848.3** | **108.3** | **95.3** | **119.9** | **56.1** | **60.3** | **52.4** | **10.2** | **10.8** | **9.6** |
| Боловсролгүй | 792.3 | 759.4 | 829.3 | 677.3 | 641.7 | 717.2 | 66.8 | 62.8 | 71.4 | 47.6 | 54.9 | 39.3 | 0.7 | - | 1.4 |
| Бага | 783.7 | 721.0 | 856.0 | 689.5 | 588.0 | 806.6 | 34.2 | 48.9 | 17.3 | 58.6 | 82.1 | 31.4 | 1.3 | 2.0 | 0.6 |
| Суурь | 768.8 | 832.3 | 685.4 | 617.2 | 669.2 | 549.0 | 77.0 | 80.7 | 72.0 | 63.9 | 68.4 | 58.1 | 10.7 | 14.0 | 6.3 |
| Бүрэн дунд | 845.9 | 926.6 | 746.1 | 718.2 | 788.8 | 630.8 | 72.5 | 76.4 | 67.6 | 49.0 | 54.0 | 42.8 | 6.3 | 7.4 | 4.9 |
| Техникийн болон мэргэжлийн анхан шат | 1,000.5 | 1,081.0 | 838.4 | 831.8 | 901.8 | 690.8 | 87.3 | 89.3 | 83.1 | 70.4 | 78.5 | 54.2 | 11.0 | 11.4 | 10.2 |
| Диплом тусгай мэргэжлийн | 1,009.3 | 1,053.1 | 965.2 | 816.9 | 888.6 | 744.7 | 98.5 | 74.8 | 122.5 | 82.9 | 83.3 | 82.6 | 10.9 | 6.4 | 15.5 |
| Дээд бакалавр | 1,184.1 | 1,278.0 | 1,119.0 | 997.7 | 1,105.7 | 922.7 | 123.5 | 106.1 | 135.6 | 51.8 | 53.7 | 50.5 | 51.8 | 53.7 | 50.5 |
| Зэрэгтэй дээд магистр | 1,529.6 | 1,744.4 | 1,394.9 | 1,254.4 | 1,474.9 | 1,116.2 | 173.7 | 158.7 | 183.0 | 84.7 | 91.6 | 80.3 | 16.8 | 19.1 | 15.3 |

*Хавсралт хүснэгт 6. Нийт цалингийн бүтэц ажил мэргэжлийн үндсэн ангилалаар /мян, төг/*

| Ажил мэргэжлийн ангиллаар | Нийт цалингийн дундаж | | | Үүнээс: бүтэц | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| **Улсын дундаж** | **1087.7** | **1151.9** | **1030.2** | **913.1** | **985.5** | **848.3** | **108.3** | **95.3** | **119.9** | **56.1** | **60.3** | **52.4** | **10.2** | **10.8** | **9.6** |
| Хууль тогтоогч, удирдах албан тушаалын ажилтан, менежер | 1380.2 | 1430.4 | 1335.4 | 1254.0 | 1308.0 | 1205.8 | 79.0 | 81.0 | 77.3 | 39.5 | 34.1 | 44.3 | 7.7 | 7.2 | 8.0 |
| Мэргэжилтэн | 1182.6 | 1287.4 | 1116.5 | 983.3 | 1106.9 | 905.1 | 132.4 | 111.9 | 145.3 | 55.5 | 56.2 | 55.0 | 11.5 | 12.4 | 11.0 |
| Инженер, техникийн ажилтан | 1061.7 | 1253.0 | 896.1 | 880.3 | 1044.9 | 737.9 | 94.3 | 101.7 | 88.0 | 74.9 | 92.7 | 59.4 | 12.1 | 13.7 | 10.8 |
| Бичиг хэргийн туслах ажилтан | 986.5 | 1135.7 | 890.3 | 880.0 | 1046.2 | 772.9 | 74.5 | 54.9 | 87.2 | 23.9 | 31.7 | 18.9 | 8.1 | 2.9 | 11.4 |
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 762.6 | 745.8 | 787.9 | 645.5 | 629.8 | 669.3 | 67.6 | 57.2 | 83.3 | 45.3 | 55.2 | 30.3 | 4.1 | 3.7 | 4.9 |
| ХАА, загас, ан агнуурын ажилтан | 628.1 | 700.8 | 591.7 | 564.1 | 636.2 | 528.0 | 37.2 | 41.8 | 34.8 | 22.2 | 22.8 | 21.9 | 4.6 | 0.0 | 6.9 |
| Үйлдвэрийн ба худалдааны ажилтан | 1044.4 | 1106.9 | 871.6 | 847.9 | 904.0 | 692.7 | 108.5 | 110.3 | 103.6 | 68.0 | 69.5 | 64.0 | 20.0 | 23.1 | 11.3 |
| Машин тоног төхөөрөмжийн оператор, угсрагч | 1038.9 | 1041.3 | 1019.7 | 851.9 | 849.2 | 873.5 | 93.8 | 98.3 | 59.2 | 85.2 | 86.1 | 78.1 | 7.9 | 7.8 | 8.9 |
| Энгийн ажил мэргэжил | 721.4 | 823.2 | 672.2 | 622.1 | 723.3 | 573.2 | 60.7 | 45.7 | 67.9 | 34.4 | 50.0 | 26.9 | 4.2 | 4.2 | 4.2 |
| Мэргэжилгүй | 1449.5 | 1449.5 | 0.0 | 1317.0 | 1317.0 | 0.0 | 132.5 | 132.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

*Хавсралт хүснэгт 7. Нийт цалингийн бүтэц ажиллагчдын тооны бүлэг, насны бүлэг /мян, төг/*

| Ажиллагчид | | Нийт цалингийн дундаж/мян, төг/ | | | Үнээс: бүтэц /мян төг/ | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үндсэн цалин | | | Нэмэгдэл | | | Нэмэгдэл хөлс | | | Шагнал урамшуулал | | |
| | | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм | Нийт | Эр | Эм |
| Улсын дундаж | | 1087.7 | 1151.9 | 1030.2 | 913.1 | 985.5 | 848.3 | 108.3 | 95.3 | 119.9 | 56.1 | 60.3 | 52.4 | 10.2 | 10.8 | 9.6 |
| Насны бүлэг | 16-25 | 995.8 | 1048.4 | 942.9 | 866.3 | 911.9 | 820.6 | 67.5 | 71.9 | 63.1 | 52.6 | 56.1 | 49.1 | 9.3 | 8.5 | 10.1 |
| | 26-35 | 1099.0 | 1168.9 | 1026.4 | 944.3 | 1010.0 | 876.0 | 88.4 | 84.6 | 92.3 | 56.0 | 62.3 | 49.4 | 10.4 | 12.0 | 8.7 |
| | 36-45 | 1103.5 | 1177.7 | 1043.1 | 922.5 | 1005.1 | 855.2 | 118.7 | 105.6 | 129.4 | 52.8 | 56.9 | 49.4 | 9.5 | 10.0 | 9.0 |
| | 46-55 | 1088.4 | 1134.2 | 1057.4 | 873.6 | 949.5 | 822.2 | 140.3 | 108.7 | 161.7 | 62.5 | 63.4 | 61.8 | 12.0 | 12.5 | 11.7 |
| | 55+ | 1066.8 | 1128.8 | 991.6 | 891.8 | 960.4 | 808.6 | 110.5 | 100.4 | 122.8 | 56.5 | 60.3 | 51.9 | 8.0 | 7.7 | 8.3 |
| Ажиллагчдын тооны бүлэг | 1-5 | 865.4 | 907.4 | 822.4 | 838.5 | 879.7 | 796.1 | 17.5 | 18.0 | 17.0 | 7.9 | 9.4 | 6.3 | 1.6 | 0.3 | 3.0 |
| | 6-19 | 1038.4 | 1070.9 | 1002.2 | 991.7 | 1036.0 | 942.3 | 30.6 | 22.8 | 39.2 | 13.7 | 10.5 | 17.2 | 2.4 | 1.6 | 3.4 |
| | 20-49 | 1077.7 | 1147.5 | 1016.3 | 957.1 | 1053.0 | 872.7 | 72.9 | 48.0 | 94.9 | 44.2 | 44.3 | 44.0 | 3.5 | 2.2 | 4.6 |
| | 50-149 | 1062.9 | 1119.2 | 1019.8 | 839.5 | 897.7 | 795.0 | 144.8 | 128.0 | 157.6 | 65.7 | 80.5 | 54.4 | 12.9 | 13.0 | 12.8 |
| | 150+ | 1267.2 | 1396.6 | 1156.8 | 922.1 | 1021.7 | 837.0 | 205.6 | 214.5 | 198.0 | 115.9 | 129.0 | 104.7 | 23.7 | 31.3 | 17.2 |

*Хавсралт хүснэгт 8. Үндсэн цалин ажиллагчдын хүйс, боловсролын түвшин бүсээр /мян, төг/*

| Боловсрол | Улсын дундаж | Боловсролгүй | Бага | Суурь | Бүрэн дунд | ТБМАШ | Дипломын тусгай мэргэжлийн | Дээд /бакалавр/ | Зэрэгтэй дээд /магистр ба түүнээс дээш/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 913.1 | 677.3 | 689.5 | 617.2 | 718.2 | 831.8 | 816.9 | 997.7 | 1254.4 |
| Эрэгтэй | 985.5 | 641.7 | 588.0 | 669.2 | 788.8 | 901.8 | 888.6 | 1105.7 | 1474.9 |
| Эмэгтэй | 848.3 | 717.2 | 806.6 | 549.0 | 630.8 | 690.8 | 744.7 | 922.7 | 1116.2 |
| Баруун бүс | 712.3 | 519.9 | 594.7 | 593.2 | 549.4 | 616.7 | 622.9 | 782.9 | 818.9 |
| Хангайн бүс | 725.9 | 664.0 | 979.8 | 514.1 | 582.4 | 598.2 | 660.2 | 794.3 | 1012.5 |
| Төвийн бүс | 798.7 | 781.4 | 523.6 | 618.8 | 706.6 | 773.1 | 764.3 | 845.3 | 936.4 |
| Зүүн бүс | 779.0 | 674.5 | 492.0 | 531.8 | 603.7 | 848.2 | 646.9 | 843.3 | 1046.5 |
| Улаанбаатар | 999.7 | 690.8 | 696.3 | 674.6 | 770.4 | 893.9 | 893.7 | 1098.3 | 1383.1 |

*Хавсралт хүснэгт 9. Нийт цалингийн өөрчлөлт байршил бүсээр /мян, төг/*

| Байршил, бүс, аймаг, нийслэл | 2019 он | | | 2021 он | | | Өөрчлөлт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт цалин, мян.төг | | | Нийт цалин, мян.төг | | | Нийт цалин, мян.төг | | |
| | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | |
| | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм |
| Улсын дундаж | 1067.9 | 1144.5 | 987.2 | 1087.7 | 1151.9 | 1030.2 | 19.8 | 7.4 | 43.1 |
| Баруун бүс | 809.8 | 790.8 | 826.6 | 929.4 | 891.6 | 954.7 | 119.6 | 100.9 | 128.0 |
| Баян-Өлгий | 525.2 | 496.4 | 552.6 | 872.9 | 835.0 | 894.4 | 347.7 | 338.5 | 341.8 |
| Говь-Алтай | 588.2 | 595.9 | 578.2 | 1041.5 | 952.3 | 1084.2 | 453.3 | 356.4 | 506.0 |
| Завхан | 559.3 | 519.9 | 605.4 | 861.6 | 804.1 | 893.3 | 302.3 | 284.2 | 287.9 |
| Увс | 641.2 | 625.1 | 659.5 | 946.9 | 901.6 | 982.6 | 305.7 | 276.5 | 323.1 |
| Ховд | 538.6 | 509.2 | 563.8 | 930.1 | 959.2 | 895.5 | 391.5 | 450.0 | 331.6 |
| Хангайн бүс | 613.9 | 612.4 | 615.3 | 985.5 | 1026.4 | 958.9 | 371.5 | 414.0 | 343.6 |
| Архангай | 582.2 | 569.5 | 592.8 | 945.9 | 1003.4 | 914.8 | 363.7 | 433.8 | 322.0 |
| Баянхонгор | 663.6 | 642.0 | 684.3 | 1079.1 | 1002.0 | 1115.4 | 415.5 | 360.0 | 431.1 |
| Булган | 596.2 | 589.4 | 604.4 | 653.3 | 609.3 | 688.3 | 57.1 | 19.8 | 83.9 |
| Орхон | 672.9 | 781.3 | 605.0 | 1161.1 | 1347.3 | 1042.8 | 488.2 | 566.0 | 437.8 |
| Өвөрхангай | 590.4 | 548.5 | 630.0 | 893.3 | 844.6 | 928.3 | 302.9 | 296.1 | 298.3 |
| Хөвсгөл | 550.5 | 525.4 | 581.7 | 899.7 | 931.8 | 872.3 | 349.1 | 406.3 | 290.6 |
| Төвийн бүс | 719.6 | 765.7 | 673.9 | 1026.1 | 1087.4 | 982.3 | 306.5 | 321.7 | 308.4 |
| Говьсүмбэр | 978.5 | 1100.0 | 697.1 | 975.3 | 982.5 | 971.2 | -3.2 | -117.5 | 274.0 |
| Дархан-Уул | 803.2 | 860.3 | 744.2 | 1028.5 | 1177.7 | 921.5 | 225.3 | 317.4 | 177.3 |
| Дорноговь | 601.5 | 605.7 | 599.0 | 1004.1 | 1047.3 | 974.7 | 402.5 | 441.6 | 375.7 |
| Дундговь | 592.8 | 526.8 | 653.6 | 974.2 | 880.7 | 1010.7 | 381.4 | 354.0 | 357.1 |
| Өмнөговь | 812.8 | 879.2 | 731.8 | 1035.1 | 1068.2 | 1006.3 | 222.3 | 188.9 | 274.6 |
| Сэлэнгэ | 558.2 | 522.7 | 591.3 | 1047.5 | 1057.6 | 1039.1 | 489.3 | 534.9 | 447.8 |
| Төв | 675.8 | 707.5 | 648.7 | 1078.1 | 1103.5 | 1054.7 | 402.4 | 395.9 | 405.9 |
| Зүүн бүс | 670.9 | 694.9 | 649.1 | 1011.5 | 1114.1 | 946.8 | 340.6 | 419.1 | 297.8 |
| Дорнод | 779.0 | 865.3 | 696.9 | 1068.6 | 1219.2 | 963.2 | 289.6 | 353.9 | 266.3 |
| Сүхбаатар | 602.9 | 580.5 | 626.0 | 1064.4 | 1159.8 | 1007.8 | 461.5 | 579.3 | 381.7 |
| Хэнтий | 556.2 | 502.3 | 595.7 | 860.5 | 861.0 | 860.2 | 304.2 | 358.7 | 264.5 |
| Улаанбаатар | 918.2 | 991.7 | 839.7 | 1141.2 | 1204.8 | 1074.8 | 223.0 | 213.1 | 235.1 |
| Улаанбаатар | 918.2 | 991.7 | 839.7 | 1141.2 | 1204.8 | 1074.8 | 223.0 | 213.1 | 235.1 |

*Хавсралт хүснэгт 10. Үндсэн цалингийн өөрчлөлт байршил бүсээр /мян, төг/*

| Байршил, бүс, аймаг, нийслэл | 2019 он | | | 2021 он | | | Өөрчлөлт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт цалин, мян.төг | | | Нийт цалин, мян.төг | | | Нийт цалин, мян.төг | | |
| | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | | Улсын дундаж | Хүйсээр | |
| | | Эр | Эм | | Эр | Эм | | Эр | Эм |
| Улсын дундаж | 927.0 | 1004.5 | 845.4 | 913.1 | 985.5 | 848.3 | -13.9 | -19.0 | 2.9 |
| Баруун бүс | 627.3 | 618.2 | 635.4 | 712.3 | 711.0 | 713.2 | 85.0 | 92.7 | 77.8 |
| Баян-Өлгий | 611.1 | 622.9 | 599.7 | 698.2 | 674.0 | 711.9 | 87.1 | 51.1 | 112.2 |
| Говь-Алтай | 664.4 | 664.3 | 664.5 | 746.6 | 750.0 | 744.9 | 82.2 | 85.7 | 80.4 |
| Завхан | 602.5 | 592.4 | 613.1 | 689.7 | 672.0 | 699.4 | 87.2 | 79.7 | 86.3 |
| Увс | 581.2 | 522.9 | 624.3 | 692.4 | 683.3 | 699.6 | 111.2 | 160.5 | 75.3 |
| Ховд | 671.4 | 662.2 | 678.8 | 752.0 | 788.9 | 708.0 | 80.6 | 126.8 | 29.2 |
| Хангайн бүс | 653.3 | 676.2 | 635.0 | 725.9 | 741.1 | 716.1 | 72.6 | 64.9 | 81.1 |
| Архангай | 681.9 | 714.6 | 655.1 | 733.9 | 771.3 | 713.6 | 52.0 | 56.7 | 58.5 |
| Баянхонгор | 635.6 | 638.3 | 633.8 | 730.6 | 721.7 | 734.8 | 95.1 | 83.4 | 101.1 |
| Булган | 600.8 | 623.6 | 584.8 | 575.3 | 584.6 | 567.9 | -25.5 | -39.0 | -16.9 |
| Орхон | 648.6 | 656.6 | 640.9 | 808.3 | 869.7 | 769.2 | 159.6 | 213.1 | 128.3 |
| Өвөрхангай | 703.7 | 752.5 | 666.8 | 642.8 | 603.2 | 671.2 | -60.9 | -149.4 | 4.4 |
| Хөвсгөл | 636.9 | 662.4 | 616.0 | 707.1 | 714.4 | 700.9 | 70.2 | 51.9 | 84.9 |
| Төвийн бүс | 710.9 | 736.9 | 686.2 | 798.7 | 860.5 | 754.5 | 87.8 | 123.6 | 68.3 |
| Говьсүмбэр | 746.9 | 848.8 | 664.5 | 717.3 | 725.8 | 712.5 | -29.6 | -123.1 | 48.0 |
| Дархан-Уул | 743.4 | 752.3 | 732.7 | 749.9 | 812.4 | 705.1 | 6.5 | 60.1 | -27.7 |
| Дорноговь | 698.9 | 720.4 | 685.6 | 796.4 | 884.3 | 736.8 | 97.5 | 163.9 | 51.1 |
| Дундговь | 629.8 | 591.6 | 648.8 | 694.2 | 689.7 | 695.9 | 64.4 | 98.0 | 47.1 |
| Өмнөговь | 736.2 | 749.6 | 715.6 | 913.7 | 931.3 | 898.4 | 177.5 | 181.7 | 182.8 |
| Сэлэнгэ | 668.2 | 686.1 | 653.2 | 818.3 | 900.0 | 749.9 | 150.1 | 213.9 | 96.7 |
| Төв | 712.3 | 781.6 | 653.1 | 903.6 | 956.9 | 854.2 | 191.3 | 175.3 | 201.1 |
| Зүүн бүс | 668.7 | 694.5 | 651.3 | 779.0 | 852.9 | 732.4 | 110.3 | 158.3 | 81.1 |
| Дорнод | 699.0 | 727.4 | 680.3 | 807.3 | 915.0 | 731.9 | 108.2 | 187.6 | 51.6 |
| Сүхбаатар | 677.2 | 757.5 | 625.0 | 797.8 | 873.4 | 752.8 | 120.6 | 116.0 | 127.8 |
| Хэнтий | 589.8 | 560.1 | 611.4 | 711.8 | 710.1 | 712.7 | 122.0 | 150.0 | 101.3 |
| Улаанбаатар | 1064.6 | 1148.7 | 965.4 | 999.7 | 1069.0 | 927.1 | -64.9 | -79.7 | -38.2 |
| Улаанбаатар | 1064.6 | 1148.7 | 965.4 | 999.7 | 1069.0 | 927.1 | -64.9 | -79.7 | -38.2 |

*Хавсралт хүснэгт 11. Хөдөлмөр эрхлэлтийн зардал ААНБ-ын хариуцлагын хэлбэрээр /хувь/*

| ААНБ-ын хариуцлагын хэлбэр | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 80.1 | 2.5 | 12.5 | 0.6 | 4.3 |
| Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл | 68.0 | 5.1 | 7.6 | 0.5 | 18.9 |
| Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл | 73.8 | 12.1 | 8.0 | 0.1 | 6.0 |
| Хоршоо | 82.0 | 5.1 | 9.9 | 0.2 | 2.8 |
| Хувьцаат компани | 79.0 | 1.7 | 17.2 | 1.5 | 0.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хязгаарлагдмал хариуцлагатай компани | 81.9 | 3.4 | 10.3 | 0.4 | 4.0 |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 71.5 | 3.4 | 13.5 | 0.5 | 11.0 |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | 77.3 | 3.8 | 12.5 | 0.1 | 6.4 |
| Төсөвт байгууллага | 82.6 | 1.8 | 10.6 | 0.1 | 4.8 |
| Төрийн бус байгууллага | 84.3 | 1.4 | 9.0 | 0.5 | 4.9 |
| Бусад | 74.7 | 1.3 | 20.6 | 0.0 | 3.4 |

*Хавсралт хүснэгт 12. Хөдөлмөр эрхлэлтийн зардал ажиллагчдын тооны бүлгээр /хувь/*

| Ажиллагчдын тооны бүлэг | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 80.1 | 2.5 | 12.5 | 0.6 | 4.3 |
| 1-5 | 81.8 | 4.4 | 6.6 | 0.6 | 6.6 |
| 6-19 | 80.1 | 4.0 | 10.5 | 0.5 | 4.9 |
| 20-49 | 81.1 | 2.6 | 10.7 | 0.4 | 5.1 |
| 50-149 | 81.5 | 2.5 | 10.8 | 0.2 | 5.0 |
| 150+ | 79.7 | 2.4 | 13.3 | 0.7 | 3.9 |

*Хавсралт хүснэгт 13. Хөдөлмөр эрхлэлтийн зардал ЭЗҮАСалбараар /хувь/*

| Эдийн засгийн үйл ажиллагааны салбар | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|
| Улсын дундаж | 80.1 | 2.5 | 12.5 | 0.6 | 4.3 |
| Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 84.3 | 3.1 | 9.5 | 0.2 | 2.9 |
| Барилга | 85.4 | 3.0 | 8.6 | 0.4 | 2.6 |
| Боловсрол | 82.5 | 0.9 | 10.4 | 0.2 | 6.0 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 77.9 | 4.5 | 12.2 | 0.7 | 4.7 |
| Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклийн засвар үйлчилгээ | 81.3 | 3.8 | 10.1 | 0.5 | 4.3 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 78.5 | 2.9 | 9.8 | 1.0 | 7.7 |
| Мэдээлэл холбоо | 79.7 | 3.8 | 14.6 | 0.7 | 1.2 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 81.3 | 3.9 | 10.3 | 0.4 | 4.1 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 86.4 | 3.7 | 6.6 | 0.5 | 2.9 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 82.2 | 2.6 | 11.6 | 0.8 | 2.8 |
| Урлаг, үзвэр , тоглоом наадам | 80.4 | 2.8 | 12.2 | 0.1 | 4.6 |
| Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 78.6 | 5.0 | 11.9 | 0.1 | 4.3 |
| Уул уурхай | 74.7 | 1.6 | 18.3 | 1.2 | 4.2 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 83.3 | 2.4 | 10.7 | 0.1 | 3.5 |
| Хөдөө аж ахуй, загас, ан агнуурын | 81.4 | 5.4 | 9.1 | 0.2 | 3.9 |
| Цахилгаан, хий уур, агааржуулалт | 80.3 | 3.2 | 11.6 | 0.6 | 4.3 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 82.9 | 2.1 | 9.3 | 0.6 | 5.1 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 78.6 | 3.3 | 15.1 | 0.7 | 2.4 |

*Хавсралт хүснэгт 14. Хөдөлмөр эрхлэлтийн зардал аймаг нийслэлээр /хувь/*

| Байршил аймаг бүс | | Цалин хөлсний зардал | Нөхөн олговор | Нийгмийн хамгааллын зардал | Сургалтын зардал | Хөдөлмөрийн бусад зардал |
|---|---|---|---|---|---|---|
| **Улсын дундаж** | | **80.1** | **2.5** | **12.5** | **0.6** | **4.3** |
| **Баруун бүс** | | **86.3** | **1.5** | **9.2** | **0.2** | **2.8** |
| | Баян-Өлгий | 86.2 | 2.9 | 10.5 | 0.1 | 0.4 |
| | Говь-Алтай | 86.8 | 0.8 | 7.5 | 0.1 | 4.8 |
| | Завхан | 84.8 | 1.1 | 10.8 | 0.2 | 3.1 |
| | Увс | 87.7 | 0.7 | 8.7 | 0.2 | 2.7 |
| | Ховд | 85.0 | 2.7 | 9.4 | 0.3 | 2.6 |
| **Хангайн бүс** | | **77.1** | **2.2** | **10.5** | **0.6** | **9.6** |
| | Архангай | 77.1 | 1.5 | 9.7 | 0.0 | 11.7 |
| | Баянхонгор | 81.1 | 1.0 | 9.2 | 0.5 | 8.2 |
| | Булган | 75.3 | 1.4 | 10.4 | 0.5 | 12.4 |
| | Орхон | 79.7 | 3.0 | 11.2 | 1.4 | 4.7 |
| | Өвөрхангай | 80.7 | 1.7 | 10.8 | 0.2 | 6.6 |
| | Хөвсгөл | 81.1 | 2.7 | 12.3 | 0.1 | 3.9 |
| **Төвийн бүс** | | **79.7** | **3.0** | **12.8** | **0.4** | **4.1** |
| | Говь-сүмбэр | 81.0 | 0.8 | 9.3 | 0.0 | 8.9 |
| | Дархан-Уул | 80.3 | 2.7 | 13.7 | 0.9 | 2.4 |
| | Дорноговь | 74.4 | 2.0 | 11.0 | 0.1 | 12.5 |
| | Дундговь | 83.8 | 3.1 | 12.2 | 0.1 | 0.9 |
| | Өмнөговь | 84.2 | 3.3 | 11.0 | 0.2 | 1.3 |
| | Сэлэнгэ | 77.2 | 4.2 | 12.9 | 0.0 | 5.7 |
| | Төв | 77.1 | 4.4 | 15.5 | 0.4 | 2.6 |
| **Зүүн бүс** | | **81.3** | **2.0** | **11.1** | **0.2** | **5.4** |
| | Дорнод | 84.3 | 2.3 | 11.7 | 0.2 | 1.4 |
| | Сүхбаатар | 79.0 | 1.4 | 9.3 | 0.1 | 10.3 |
| | Хэнтий | 78.5 | 2.0 | 11.9 | 0.2 | 7.3 |
| **Улаанбаатар** | | **79.8** | **2.5** | **12.9** | **0.7** | **4.1** |
| | Улаанбаатар | 79.8 | 2.5 | 12.9 | 0.7 | 4.1 |

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ

77111331

www.rilsp.gov.mn

ХУД 2-р хороо
Хөдөлмөрийн ордон